



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ СУЛ, ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НАЙДВАРТАЙ
БАЙДАЛ АЛДАГДАЖ, САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ
ТООЦДОГГУЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН 2017-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ГАГ-2025/17-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Энхболд

Утас: 263755 Цахим хаяг: enkboldd@audit.gov.mn

Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга:

Х.Баярмаа

Утас: 261639 Цахим хаяг: bayarmaakh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Наранжаргал

Утас: 262451 Цахим хаяг: naranjargalm@audit.gov.mn

Аудитор: Н.Хандмаа

Б.Бүрэнхүү

Н.Наранзаяа



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлан болон аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар, Боловсролын яам, "Боловсролын зээлийн сан"-ийн ажлын албанд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Г.Занданшатар), Боловсролын сайд (П.Наранбаяр), Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Сийлэгмаа) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газар (Ч.Цэвэгдорж)-т даалгасугай.

5.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улсын Ерөнхий аудиторов
2025 оны 10 дугаар сарын 5-ний
өдрийн 10 дугаар тушаалын хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн
албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Төлбөрийн акт, албан шаардлагын товч утга	Төлбөрийн акт, албан шаардлагын дүн (төгрөгөөр)
	Байгууллага	Албан тушаалтан		
1	Боловсролын зээлийн сангийн ажлын алба	Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Сийлэгмаа	- БШУС-ын 2022 оны А/480 дугаар тушаалаар "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг" хамрагдах 8 иргэн, мөн сайдын 2022 оны А/502 дугаар тушаалаар БНПУ-д Засгийн газрын тэтгэлгээр суралцах суралцагчдад амьжиргааны тэтгэлэгт хамрагдах 8 иргэний нэр давхцаж, 2022-2024 онд амьжиргааны тэтгэлэгт нэр давхацсан 8 иргэнд нийт 36,000 ам.доллар буюу 129,340,080.0 төгрөг илүү олгосон байна. "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"¹-ын 3.1.-т "Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг нэг суралцагчид нэг удаа олгоно" гэсэн заалтыг, "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"²-ын 10.11-т "Дараах тохиолдолд зээл олгохгүй", 10.11.2-т "сангаас өмнө авсан зээл төлөөгүй" гэж заасныг зөрчиж 2016-2018 оны хооронд зээлийн санхүүжилт дахин авсан 3 иргэнд нийт 96.0 мянган ам.доллар буюу 344,906,880.0 төгрөгийг давхар олгосон байна.	Төлбөрийн акт 474,246,960.0 ³ төгрөг
2	Боловсролын зээлийн сангийн	Ажлын албаны даргын	Боловсролын зээлийн сангийн захирлын 2023 оны Б/57 дугаар тушаалаар "Судалгаа, шинжилгээ, статистик	Төлбөрийн акт 17,136,000.0 төгрөг

¹Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан /хүчин төгөлдөр мөрдөгдөж байх хугацаанд/

²Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан

³ Монголбанкны 2025 оны 10 сарын 01-ний өдрийн ханшвар хөрвүүлэлт

	ажлын алба	албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Сийлэгмаа	хариуцсан ахлах мэргэжилтэн"-ий албан тушаалд нэг албан хаагчийг шилжүүлэн томилсон нь Үндэсний статистикийн хорооноос "сэлгэн ажиллуулах боломжгүй" гэсэн хариу санд ирүүлсэн ч тус албан хаагчийг 2024 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын хооронд АА-5 ангиллын цалингаар тооцож нийт 49,461,044.35 төгрөгийн хөдөлмөрийн хөлсийг олгож, уг албан тушаалд ТҮ-8 ангиллаар хөдөлмөрийн хөлсийг тооцож олгох байтал нийт 17,136,000.0 төгрөгийг илүү олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь заалт, Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмын 2.3 дахь заалтыг зөрчсөн байна.	
3	Боловсролын яам	Сайд П.Наранбаяр	- Салбарын сайдаас 2017-2023 оны хооронд гаргасан зарим тушаалд гадаадын их, дээд сургуульд суралцагч 26 иргэний овог, нэрийг өөрчилж, Дэлхийн шилдэг их сургуульд бакалаврын хөтөлбөрт суралцах 22 суралцагчийг "бэлтгэл хөтөлбөр"-т суралцуулах шийдвэр гаргаж, зарим суралцагчийн сургууль, мэргэжил, овог нэр сольсноос 123 суралцагч нь тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй байна. - Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрт "магистр, доктор"-т суралцуулах шийдвэртэй 77 суралцагч нь Дэлхийн шилдэг, гадаад хэлний шаардлага хангаагүй, 2 дахь удаагаа суралцаж буй 22 суралцагч нь тэргүүлэх болон эрэлттэй чиглэлийн жагсаалтад ороогүй мэргэжлийг сонгон суралцсан байна.	Албан шаардлага
4	Боловсролын яам	Сайд П.Наранбаяр	- Салбарын Сайдаас 2017-2023 оны хооронд 17 удаагийн тушаалаар томилогдсон "Ажлын хэсэг" нь Гадаадын их, дээд сургуульд бакалавр, магистрантур, докторантурт суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан баримт материал байхгүй, аудитын багт гаргах өгөөгүй, - Салбарын Сайдаас 2019-2023 оны хооронд 5 удаагийн тушаалаар томилогдсон "Ажлын хэсэг" нь сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг	Албан шаардлага

			хэрэгжүүлсэн тайлан, дүгнэлт гаргаагүй, илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн эсэх тодорхойгүй, хяналтын үр дүн, үр нөлөөг тооцоогүй байна. ○ Засгийн газрын 2023 оны 226 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 107 дугаар захирамж, БШУС-ын 2023 оны А/261 дүгээр тушаалаар "Монгол Улсын Ерөнхий Сайдын нэрэмжит хөтөлбөрт нэр бүхий 100 шилдэг суралцагч тус бүрд 10.0 сая төгрөгийн тэтгэлэг олгох..." шийдвэрийг тус тус гаргасан нь "Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ын 4.1.1-д "...дотоодын сургалтын байгууллагад суралцах 50 хүртэлх суралцагчид тэтгэлэг олгох..." гэж заасныг зөрчсөн байна.	
5	Боловсролын зээлийн сангийн ажлын алба	Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Сийлэгмаа	○ БСШУС-ын 2020 оны А/195, 2023 оны А/31, А/139 дүгээр тушаалаар гэрээний үүргийг дуусгавар болгох, сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлөх шийдвэрт хамрагдсан 5 суралцагчийн хувийн хэрэг, баримт материалыг аудитын багт ирүүлээгүй, нотлох баримтгүй байна. ○ Гадаадын их, дээд сургуульд 2017–2024 оны хооронд суралцах гэрээ байгуулсан 495 суралцагчаас 278 суралцагчийн хувийн хэрэгт үл хөдлөх хөрөнгийн лавлагааг хавсаргаагүй, 178 суралцагчийн барьцаалбарын дүн нь сургалтын төлбөрийн зээлийн дүнд хүрээгүй байна. ○ БЗС дахь архивын баримтад давхардсан тоогоор 1857 суралцагчийн хувийн хэргийн бүрдэлд гэрээний загвар өөрчилсөн 794, амьжиргааны тэтгэлгийн гэрээг байгуулаагүй 516, холбогдох тогтоолын дагуу гэрээний загварт өөрчлөлт оруулаагүй 332, хүчин төгөлдөр бус загвараар гэрээ байгуулсан 183, гэрээ байхгүй 28, 4 суралцагчийн гэрээг баталгаажуулаагүй байна ○ БЗС-ийн санхүүжилтээр гадаадын их дээд сургуульд зээл, тэтгэлгээр суралцсан, суралцаж буй суралцагчийн хувийн хэргийг Архив,	Албан шаардлага

			албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасаар болон цахимаар хадгална гэж заасан ч цахим мэдээллийн сан бүрдээгүй байна.	
6	Боловсролын зээлийн сангийн ажлын алба	Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Сийлэгмаа	БЗС-аас 2017–2018 онд арилжааны 6 банкттай 2016.11.30-нд "Зээлийн гэрээ", 2017.08.16-нд нэмэлт өөрчлөлтийн гэрээг /жилийн 2 хувийн хүүтэй зээл олгож, сангаас нийт 11,000.0 сая төгрөгийн хөрөнгийг банканд эх үүсвэр болгон шилжүүлж, арилжааны банкнаас "энгийн вексель" бичиж баталгаажуулсан/ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөж байсан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2020.01.01-ний өдрөөс хүчингүй), Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль (2023.07.07-ны өдрөөс хүчингүй), Оюутны хөгжлийн зээлийн журам (2017.06.20-ны өдрөөс хүчингүй) нь тус тус хүчингүй болсон ч Арилжааны банкттай байгуулсан зээлийн гэрээний үйлчлэл өнөөдрийг хүртэл хүчинтэй хэвээр мөрдөгдөж байна. Гэтэл БЗС-аас гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, дуусгавар болгох зохицуулалтыг хийгээгүйгээс арилжааны банканд эх үүсвэрээр ашиглуулж буй нийт 35,779,082.0 төгрөгийг 2025.06.30-ны өдрийн байдлаар буцаан татаагүй, гэрээний үүргийг дуусгавар болгоогүй байна.	Албан шаардлага 35,779,082.0 төгрөг
7	Боловсролын зээлийн сангийн ажлын алба	Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Сийлэгмаа	Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2017-2024 оны хооронд гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн 299 иргэн 19,927.8 мянган.ам доллар буюу 71,607,560.1 ⁴ мянган төгрөгийн зээлийн төлбөрийг эргэн төлөөгүй байна.	Албан шаардлага 71,607,560,100.0 төгрөг
			1. Төлбөрийн актын нийт дүн 491,382,960.0 төгрөг 2. Албан шаардлагын нийт дүн 71,643,339,182.0 төгрөг	

⁴ Монголбанкны 2025 оны 10 сарын 01-ний өдрийн ханшаар хөрвүүлэлт

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	4
Ерөнхий мэдээлэл	6
БҮЛЭГ-1: САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ СУЛ, ХҮНИЙ НӨӨЦ ТОГТВОРГҮЙ БАЙНА	7
Засгийн газраас хуулийн этгээдийг байгуулаагүй, сангийн тогтолцоо, зорилго, төрийн үйлчилгээ үзүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт сул байна	7
“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн баримт бичгийн “Дээд боловсролыг хөгжүүлэх”-д чиглэсэн сангаас үзүүлэх үйлчилгээ хангалтгүй байна	9
БҮЛЭГ-2: НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН 57 ХУВИЙГ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ЭЗЭЛЖ, ГАДААДЫН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ 1.5 ХУВЬТАЙ, 11.2 САЯ АМ.ДОЛЛАРЫН ЗЭЭЛИЙГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ЧӨЛӨӨЛСӨН БАЙНА	18
Боловсролын зээлийн сангийн хөрөнгийн эх үүсвэр зөвхөн улсын төсвөөс бүрдэж байна	18
Гадаадын их, дээд сургуульд 2017-2024 оны хооронд нийт 113,595.7 сая төгрөгийн сургалтын төлбөрийн зээл олгосон ч эргэн төлөлт 1.5 хувьтай байна	21
Дотоодын их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлд 90,094.2 сая төгрөгийг олгосон байна	29
Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр 2022-2024 оны хооронд 738 суралцагчид нийт 45,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна	31
Засгийн газрын тэтгэлгээр нийт 77 суралцагчид 3,267.2 мянган ам.долларын сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон байна	31
Хоёр улсын Засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу амьжиргааны зардлын тэтгэлэгт нийт 390 суралцагч 7 улсад суралцсан байна	33
БЗС болон суралцагчтай байгуулсан гэрээ, хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байна ..	35
Салбарын сайд 2017-2024 оны хооронд 487 суралцагчийн 16.1 сая ам.долларын чөлөөлөлт хийснээс 381 суралцагчийн 11.2 сая ам.долларын чөлөөлөлт шаардлага хангаагүй байна	35
БҮЛЭГ-3: ЦАХИМ СИСТЕМ АШИГЛАЛТ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ, БОЛОВСРУУЛАХ БОЛОН ДОТООД ХЯНАЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА	39
Сангийн үйл ажиллагаанд ашиглаж буй цахим системүүд хангалтгүй бөгөөд хоорондын уялдаа хангагдаагүй байна.	39
Олон нийтэд мэдээлэх, зарлах болон нийтэд хүртээмжтэй байх хэрэгжилт хангалтгүй байна	40
Сангийн үйл ажиллагаанд тавьсан дотоод хяналтын үр дүн хангагдаагүй байна	42
ДҮГНЭЛТ	44
ЗӨВЛӨМЖ	46
Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	48
Үндэсний аудитын газрын тайлбар:	53
Хавсралтууд	54

Товчилсон үгийн тайлбар

АТГ	Авлигатай тэмцэх газар
АНУ	Америкийн Нэгдсэн улс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХИС	Батлан хамгаалахын их сургууль
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУ	Боловсрол, шинжлэх ухаан
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЗС	Боловсролын зээлийн сан
БНАЛАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард улс
БНКУ	Бүгд Найрамдах Куба улс
БНПУ	Бүгд Найрамдах Польш улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ДБССНБТ	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай
ДБСБ	Дээд боловсролын сургалтын байгууллага
ЗГ	Засгийн газар
ЗГТСТ	Засгийн газрын тусгай сангийн тухай
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗМС	Зээлийн мэдээллийн сан
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс
МУЕС	Монгол Улсын Ерөнхий Сайд
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОТБЗ	Орон тооны бус зөвлөл
ОХУ	Оросын Холбооны улс
СШАХ	Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг
СЧЕУ	Суралцах чадварын ерөнхий үнэлгээ
СТЗ	Сургалтын төлбөрийн зээл
СТС	Сургалтын төрийн сан
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТАХ	Төрийн албан хаагч
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТБАГ	Төрийн байгууллага, албан газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ТЗ	Төрийн захиргаа
ТНБ	Төрийн нарийн бичиг
ТҮ	Төрийн үйлчилгээ
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАМИС	Хамтарсан ашигт малтмалын их сургууль
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ХДЖ	Хөдөлмөрийн дотоод журам
ЭСЯ	Элчин сайдын яам

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Боловсролын зээлийн сангийн ажлын албаны захирлууд	6
Хүснэгт 2 Албан хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн мэдээлэл	16
Хүснэгт 3 Боловсролын зээлийн сангийн 2017-2024 он тус бүрийн суралцагчдын тоо, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн дүн /сая.төгрөгөөр/	18
Хүснэгт 4 Засгийн газрын тогтоолоор баталсан "...Гадаадын их, дээд сургуульд суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох..." журмын заалтын нэгтгэл судалгаа	19
Хүснэгт 5 Салбарын Сайдын тушаалаар баталсан "...гадаадын их, дээд сургуульд тэтгэлгээр суралцагчдад амьжиргааны зардал олгох..." төлбөрийн хэмжээ, хугацааны судалгаа	20
Хүснэгт 6 2017-2024 оны хооронд БЗС-ийн Гадаадын сургуульд сургалтын төлбөрийн зээлээр суралцагчдад олгосон санхүүжилт /сая ам.доллар/	25
Хүснэгт 7 Арилжааны банканд олгосон зээлийн эх үүсвэр, үлдэгдэл /сая.төгрөгөөр/	31
Хүснэгт 8 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлсөн шийдвэрийн судалгаа	37
Хүснэгт 9 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөгдсөн шийдвэрт багтсан ч нотлох баримтгүй иргэдийн нэгтгэл	37
Хүснэгт 10 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөгдсөн иргэдийн холбогдох нөхцөлийг хангасан эсэх судалгааны нэгтгэл	37
Хүснэгт 11 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөгдсөн шийдвэрт хамрагдсан ч сургалтын төлбөрийг эргэн төлсөн иргэдийн судалгаа	38
Хүснэгт 12 Алдаа зөрчлийн нэгтгэл	43
Хүснэгт 13 Монгол Улсын Боловсролын зээлийн сан, АНУ-ын Холбооны Оюутны Санхүүгийн Тусламжийн Алба / FSA/, Өмнөд Солонгосын Оюутны санхүүгийн дэмжлэгийн сан /KOSAF/, БНХАУ-ын Хятадын тэтгэлгийн зөвлөл (China scholarship council) хоорондын үйл ажиллагаа үйлчилгээний нөхцөлийг харьцуулсан судалгаа	56

Дүрслэлийн жагсаалт

Дүрслэл 1 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үүрэг	11
Дүрслэл 2 2016-2024 оны Салбарын сайдын "Боловсролын зээлийн сангийн орон тооны хязгаар батлах тухай" тушаалууд /Дэлгэрэнгүйг хавсралт №1/	13
Дүрслэл 3 БЗС-ийн захирлын орон тооны бүтэцтэй холбоотой баталсан тушаал /Дэлгэрэнгүйг хавсралт №2/	14
Дүрслэл 4 Хөдөлмөрийн дотоод журам 2018-2022 он	15
Дүрслэл 5 2016-2024 онд шинээр ажилд томилогдсон ба ажлаас гарсан ажилтны тоо	16
Дүрслэл 6 Үндсэн үйл ажиллагааны зардлын төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл /сая.төгрөгөөр/	17
Дүрслэл 7 Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл /сая.төгрөгөөр/	21
Дүрслэл 8 Дэлхийн шилдэг их сургуулийн эхний 20-д багтаагүй сургуульд тэргүүлэх, эрэлттэй мэргэжил харгалзахгүйгээр сургалтын төлбөрийн зээлээр суралцсан суралцагчийн тоо	26
Дүрслэл 9 2017-2024 онд сурсан суралцагчдыг мэргэжлийн чиглэл, индексээр харвал	27
Дүрслэл 10 Суралцсан суралцагчийн тоо, санхүүжилт	33
Дүрслэл 11 Засгийн газар хоорондын гэрээгээр тэтгэлэгт хамрагдаж буй суралцагчид /суралцсан улсаар/	34

Хавсралтын жагсаалт

1 Дүрслэл БШУС-ын Боловсролын зээлийн сангийн орон тоог баталсан тухай мэдээлэл	54
2 Дүрслэл БШУЯ-ны Боловсролын зээлийн сангийн захирлын орон тооны нэгжийн бүтцийг баталсан тухай мэдээлэл	55

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Аудитын сэдэв батлах тухай", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/108 дугаар, 2025 оны А/80 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан "Төрийн аудитын байгууллагын 2025 онд хийж гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г үндэслэн гүйцэтгэл-нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилго

"Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн"-д аудит хийж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

1. Боловсролын зээлийн санг холбогдох хуульд нийцүүлэн боловсруулсан эрх зүйн актаар зохицуулж байгаа эсэх;
2. Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд оролцогч талууд журмын дагуу чиг үүргээ хэрэгжүүлж, гэрээний үүргийн хэрэгжилтийг бүрэн хянаж байгаа эсэх;
3. Тус сангийн суралцагчдын цахим мэдээллийн сан дахь мэдээлэл бодитой, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт үр нөлөөтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Боловсролын зээлийн тусгай сангийн 2017-2024 оны үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох замаар дээд боловсрол эзэмших хүсэлтэй тодорхой шалгуур, шаардлагыг хангасан иргэнийг төрөөс дэмжих бодлогын хэрэгжилтэд хамаарах Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яам, холбогдох бусад яам, УБЕГ, НДЕГ, ТЕГ, Магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллага, дотоодын болон гадаадын их дээд сургуульд суралцагчид зэрэг шалгагдагч болон хамрагдагч этгээдийг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000, АДБОУС 4000, Монгол Улсын төрийн аудитын багц стандарт MNS 6817-2020 "Төрийн аудитын стандарт", "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ыг ашиглан "Боловсролын зээлийн сан"-ийн үйл ажиллагаанд оролцогч талуудын холбогдох хууль, дүрэм, журамд заасан чиг үүргийн хэрэгжилт, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих дотоод, гадаадын их дээд сургуульд суралцагчидтай байгуулсан гэрээ, сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, зээлийн эргэн төлөлтөд тавьсан хяналт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн шийдвэр, цахим мэдээллийн сан, эрх бүхий байгууллагын хяналтын тайлан, цахим болон цаасан суурьтай баримтад үндэслэн асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, мэдээ, тайланд дүн шинжилгээ, харьцуулалт хийж аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

Хууль:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.72 дахь заалт /1992 он/;
- Боловсролын ерөнхий хууль /2002 он, 2023 он/;
- Дээд боловсролын тухай хууль /2002 он, 2023 он/;
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль /2011 он/;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /2006 он, 2019 он/;
- Төрийн албаны тухай хууль /2017 он/;
- Төрийн албаны ёс зүйн тухай хууль /2024 он/;
- Монгол Улсын 2017 он, 2018 он, 2019 он, 2020 он, 2021 он, 2022 он, 2023 он, 2024 оны Төсвийн тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хууль /2016 он/;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /2021 он/;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /2021 он/.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 03 сарын 29-ний өдрийн 42 дугаар зарлиг
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 05 сарын 20-ны өдрийн 78 дугаар зарлиг
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 08 сарын 27-ны өдрийн 23 дугаар зарлиг

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах журам";

- Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам", "Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл";
- Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор баталсан "Боловсролын зээлийн сангийн дүрэм", "Боловсролын зээлийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн", "Оюутны хөгжлийн зээлийн журам";
- Засгийн газрын 2017 оны 176 дугаар тогтоолоор баталсан "Оюутны хөгжлийн зээлийн журам";
- Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам";
- Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журам", "Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт";
- Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам";
- Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам";
- Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам", "Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам";
- Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 115 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл";
- Засгийн газрын 2023 оны 326 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай";
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 72 дугаар тогтоолоор баталсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам";
- Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс олгох санхүүгийн дэмжлэг, тэтгэлгийн талаар авах зарим арга хэмжээ";
- Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 103 дугаар тогтоолоор баталсан "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам".

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг Бодлого, төлөвлөлт, инновацийн газрын дарга Х.Баярмаа хэрэгжүүлж, ахлах аудитор М.Наранжаргал, аудитор Б.Бүрэнхүү, Н.Хандмаа, Н.Наранзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл

Аудитын горим хэрэгжүүлэх явцад аудитад шалгуулагч байгууллага Боловсролын яам, Боловсролын зээлийн санд "Аудитад шаардлагатай баримт материалын жагсаалт"-ыг 2025.04.29, 2025.05.26, 2025.06.20, 2025.07.01, 2025.07.23-ны өдрүүдэд хүргүүлж, аудитын горим хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт материалыг авах хүсэлт гаргасан ч, аудитын явцад Боловсролын яамнаас 2017 оны 2, 2018 оны 1, 2019 оны 3, 2020 оны 3, 2021 оны 5, 2022 оны 1, 2023 оны 2, нийт 17 удаагийн салбарын сайдын тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн сонгон шалгаруулалтын баримт материалыг ирүүлээгүй, харин Боловсролын яамнаас 2025.08.07-ны өдрийн 2/3486, БЗС-аас нэмэлтээр 2025.08.25-ны 01/819 тоот албан бичгээр тайлбар ирүүлснээс аудитын тайлан бэлтгэх хугацаа 1 сараар хоцрох шалтгаан болсон.

Түүнчлэн аудитын горим хэрэгжүүлэх явцад суралцагчдын 1857 хувийн хэргийн бүрдлийг цаасан хэлбэрээр ирүүлсэн тул гараар нэг бүрчлэн шалгах шаардлага гарч, тухайн оюутанд олгосон санхүүжилтийг жил бүр шилжүүлсэн мөнгөн дүн нь Монгол банк болон Сангийн яамны дансны мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхэд нэг бүрчлэн тулган баталгаажуулах нэмэлт горим хийгдсэн нь аудитын ачааллыг нэмэгдүүлж, хугацаа алдах шалтгаан болсон.

Мөн аудитын үйл ажиллагаанд оролцогч нэр бүхий 6 арилжааны банкнаас 2025.08.20-09.15-ны өдрүүдэд аудитад шаардлагатай мэдээ мэдээлэл, нотлох баримтыг ирүүлж, харин УАГ-аас 2025.07.23-ны өдрийн 07/2141 тоот албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлсэн албан бичгийн хариуг аудитын тайлан баталгаажих хугацаанд ирүүлээгүй байна.

Ерөнхий мэдээлэл

Засгийн газрын 1997 оны 179 дүгээр тогтоолын 1-д "Дотоод, гадаадын их, дээд сургууль, коллежид дипломын болон бакалаврын боловсрол эзэмшигчдийг төлбөртэйгөөр суралцуулж байх", 3-т "Суралцагчдад хөнгөлөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх **"Сургалтын төрийн сан"**-г Гэгээрлийн яамны харьяанд ажиллуулах шийдвэрийг гаргажээ.

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор Сургалтын төрийн санг **"Боловсролын зээлийн сан"** болгон өөрчилж, "Боловсролын зээлийн сан"-ийн дүрэм, сангийн "Удирдах зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан байна.

Боловсролын зээлийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай, Боловсролын тухай болон Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай /*тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан*/, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Шилэн дансны тухай, Боловсролын ерөнхий хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 удаагийн зарлиг, Засгийн газрын тогтоолоор баталсан 1 дүрэм, 15 журам, салбарын Сайд болон бусад салбарын Сайдтай хамтран гаргасан тушаал, шийдвэрийн дагуу үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Боловсролын зээлийн сан нь улсын төсвөөс эх үүсвэрээ бүрдүүлдэг. 2017-2024 оны хооронд нийт 677,291.6 сая төгрөгийн төсөвтэй, Засгийн газраас баталсан холбогдох журмын дагуу 16 хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, амьжиргааны зардалд 473,158.5 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан тушаалыг 2017-2024 оны хооронд нэр бүхий дараах хүмүүс хашиж ирсэн байна. Үүнд:

Хүснэгт 1 Боловсролын зээлийн сангийн ажлын албаны захирлууд

№	Хамрагдах хугацаа	Сангийн ажлын албаны захирлын нэр
1	2015 оны 11 сарын 09-ний өдрөөс 2018 оны 07 сарын 09-ний өдөр	П.Лхагвасүрэн
2	2018 оны 07 сарын 09-ний өдрөөс 2020 оны 02 сарын 20-ны өдөр	Н.Ариунжаргал
3	2020 оны 02 сарын 28-ны өдрөөс 2022 оны 02 сарын 22-ны өдөр	Ж.Ариунболд
4	2022 оны 02 сарын 22-ны өдрөөс 2023 оны 07 сарын 20-ны өдөр	Д.Гарид
5	2023 оны 08 сарын 24-ний өдрөөс 2023 оны 09 сарын 11-ний өдөр	С.Дэлгэрмаа
6	2023 оны 09 сарын 11-ний өдрөөс 2024 оны 08 сарын 23-ны өдөр	Б.Амарсанаа
7	2024 оны 08 сарын 23-ны өдрөөс одоо хүртэл	О.Сийлэгмаа

Эх сурвалж: Салбарын сайдын 2015 оны Б/446, 2018 оны Б/057, 2018 оны Б/058, 2020 оны Б/19, 2020 оны Б/21, 2022 оны Б/15, 2023 оны Б/80, 2023 оны Б/88, Б/92, 2023 оны Б/93, 2024 оны Б/18 дугаар тушаалууд.

БҮЛЭГ-1: САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ СУЛ, ХҮНИЙ НӨӨЦ ТОГТВОРГУЙ БАЙНА

Засгийн газраас хуулийн этгээдийг байгуулаагүй, сангийн тогтолцоо, зорилго, төрийн үйлчилгээ үзүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт сул байна

Боловсролын зээлийн тусгай сангийн тогтолцоог салбарын хуульд тусгаагүй байна.

1.1. ЗГТСТ /2006 оны/ хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.13¹-т “Боловсролын зээлийн сан” тусгай сан² байх бөгөөд **ажлын албатай байна**, 2019.11.13-ны өдөр шинэчлэн батлагдсан ЗГТСТ хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т “... 5.3.2-т заасан ажлын албаны орон тооны хязгаарыг Засгийн газар батална...” гэж хуульчилсан байна.

1.2. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн³ 12.1-д “Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага нь **“Ажлын алба”**⁴ гэж заасан байна.

1.3. Дээр дурдсанаас үзэхэд ЗГТСТ хуулийн “Ажлын алба”-ны албан тушаалтны ангилалтай нийцээгүй, хууль хоорондын уялдаагүй байна.

1.4. Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн⁵ 14.1-д “Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараах албан тушаал хамаарна” гэж, мөн хуулийн 14.1.2-т **“боловсрол, шинжлэх ухаан, ... төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал”** гэж заасан бөгөөд БЗС-ийн ажлын албаны албан тушаалтан нь төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарахаар байна.

1.5. ЗГТСТ хуулийн /2019 онд батлагдсан/ 8 дугаар зүйлийн 8.1-д “Боловсролын зээлийн сан нь санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох замаар дээд боловсрол эзэмших хүсэлтэй тодорхой шалгуур, шаардлагыг хангасан иргэнийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай байна”, 8.3-т “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна” гэж тус тусгай сангийн зориулалт, үйл ажиллагааг хуульчилсан байна.

1.6. Боловсролын тухай хууль /2002.05.03-аас 2023.07.07-ны хооронд хүчин төгөлдөр мөрдсөн/, Боловсролын ерөнхий хуульд боловсролын байгууллагын тогтолцоо, ангилал, удирдлагын тогтолцоог хуульчилсан ч “Боловсролын зээлийн сан”-ийн тогтолцоог хуульчлаагүй байна. Тухайлбал:

Боловсролын тухай хуульд:

- хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Боловсролын байгууллагын тогтолцоо нь сургалтын, эрдэм шинжилгээ, арга зүйн, боловсролын үнэлгээний, мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн болон бусад байгууллагаас бүрдэнэ” гэж,
- хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.8-д “хөдөөгийн сумдын захиалга-гэрээний дагуу багш мэргэжлээр суралцаж байгаа оюутан, магистрантад Боловсролын зээлийн сангаас хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл, тэтгэлэг олгох;”, 43.2.9-д “сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох;” гэж тус тус заасан ч БЗС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эсэх зохицуулалт нь тодорхойгүй;

Боловсролын ерөнхий хуульд /хүчин төгөлдөр/:

¹ Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан

² 26.3.Энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарган бөгөөд энэ хуулийн ..., 6.4.6,....-т зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулж, санхүүжүүлэхийг хориглоно.

³ “Төрийн захиргааны албан тушаал”

⁴ Төрийн захиргааны албан тушаал: 12.1.1-д “Төрийн захиргааны албан тушаал нь: Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал, 12.1.2-д “Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны ажлын алба, бүх шатны шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргааны бусад байгууллага, прокурорын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал, 12.1.3-д “Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал, 12.1.4-д “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэж,

⁵ Төрийн үйлчилгээний албан тушаал.

- хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн, боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвөөс бүрдэнэ" гэж заасан ч ЗГТСТ хуулийн 5.3.2-т заасан "Боловсролын зээлийн сан" тусгай сангийн тогтолцоо орхигдсон байна.
- Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "Гадаадын болон дотоодын мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно", 11.5-д "Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгоно" гэж тус тус заасан ч БЗС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эсэх зохицуулалт нь тодорхойгүй байна.

1.7. Дээрх байдал нь ЗГТСТ хууль болон Боловсролын ерөнхий хууль хоорондын уялдаа хангагдаагүйг харуулж байна.

Засгийн газраас сангийн ажлын албыг байгуулаагүй, сангийн ажлын алба нь улсын бүртгэлд хариуцлагын хосолмол хэлбэрээр бүртгэлтэй байна.

1.8. Засгийн газраас 2016 оны 111 дүгээр тогтоолоор сангийн дүрмийг баталсан ч сангийн ажлын албыг байгуулаагүй нь ТБОНӨТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д "хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, ..." гэж заасантай нийцээгүй байна.

1.9. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн⁶ 7.5-д "Энэ хуулийн 7.1.8⁷, 7.1.9⁸-д олон улсын байгууллага, Засгийн газрын тусгай сан,...хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй" гэж хуульчилсан байна.

1.10. БЗС-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг "ТБАГУТУГ" гэсэн хариуцлагын хосолмол хэлбэрээр 2016.10.25-ны өдөр гэж бүртгэсэн байна.

1.11. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн⁹ 7.5-д "Энэ хуулийн 7.1.8¹⁰, 7.1.9¹¹-д олон улсын байгууллага, Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй бөгөөд улсын бүртгэлд бүртгэхгүй" гэсэн заалтыг зөрчсөн, мөн "ТБАГ", "УТУГ" гэсэн тусдаа хариуцлагын хэлбэрийг хамт бүртгэсэн байна.

Боловсролын зээлийн сангийн зорилгыг бүрэн тодорхойлж чадаагүй байна.

1.12. ЗГТСТ хууль, Төрийн албаны тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд иргэнийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомжийн дагуу үзүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх гэсэн зохицуулалтын талаар заасан байна.Үүнд:

- ЗГТСТ хуулийн 8.1-д "Боловсролын зээлийн сан нь санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох замаар дээд боловсрол эзэмших хүсэлтэй тодорхой шалгуур, шаардлагыг хангасан иргэнийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай байна" гэж;
- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12-т "төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх;" гэж;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.13¹²-т "төрийн үйлчилгээ" гэж ..., боловсрол,... төрөөс иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомж, стандартын дагуу үзүүлж байгаа олон нийтэд зориулсан үйлчилгээг;" гэж тус тус хуульчилсан ч Боловсролын зээлийн сангийн зорилгыг тодорхойлохдоо дээрх хуулиудын агуулга, зохицуулалтыг бүрэн тусгаагүй байна.

1.13. Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор баталсан сангийн дүрэмд Боловсролын зээлийн сангийн зорилгыг ... "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох,

⁶ Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд

⁷ "Төрийн байгууллага, албан газар"

⁸ "Улсын төсөвт үйлдвэрийн газар"

⁹ Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд

¹⁰ "Төрийн байгууллага, албан газар"

¹¹ "Улсын төсөвт үйлдвэрийн газар"

¹² 5.1.13."төрийн үйлчилгээ" гэж иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дэд бүтэц, эрчим хүч, зам, тээвэр, эрүүл мэнд, боловсрол, соёл болон холбогдох бусад салбарт төрөөс иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомж, стандартын дагуу үзүүлж байгаа олон нийтэд зориулсан үйлчилгээг;

зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулахад оршино”... гэж заасан ч иргэнийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомжийн дагуу үзүүлэх, ялгаварлан гадуурхахгүй байх гэсэн зохицуулалтыг орхигдуулж ирсэн байна.

Тусгай сангаас үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг зохицуулсан Засгийн газраас баталсан журмын олон удаагийн өөрчлөлтөөс сангийн эрх зүйн актын зохицуулалт тогтворгүй байна.

1.14. ЗГТСТ хуулийн /2019 онд батлагдсан/ 8 дугаар зүйлийн 8.3-т “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна” гэж заасан.

1.15. Боловсролын зээлийн сан нь “Сургалтын төрийн сан” байхад батлагдсан журам болон Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор баталсан дүрэм, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлиг, Засгийн газрын тогтоолоор баталсан 15 журам, салбарын Сайдын болон бусад салбарын Сайдтай хамтран баталсан 4 удаагийн тушаал, шийдвэрийн хүрээнд сангаас үзүүлэх төрийн үйлчилгээг үзүүлж байна.

1.16. Засгийн газрын тогтоолоор 2012-2024 оны хооронд 15 журам баталсан, үүний 10 журмыг 7 дугаар сараас 1 жил 8 сарын хугацаатай мөрдсөн, 5 журмын хүчин төгөлдөр мөрдөх хугацаанд 1-5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн нь эрх зүйн актын зохицуулалт тогтворгүй байсныг илтгэж байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2016.10.05-ны 111 дүгээр тогтоолоор “Оюутны хөгжлийн зээлийн журам”-ыг анх баталсан ч 2017.06.20-ны 176 дугаар тогтоолоор хүчингүй /8 сар 15 хоног мөрдсөн/ болгож, мөн тогтоолоор дээрх журмыг дахин шинэчлэн баталсан ч 2018.02.06-ны 46 дугаар тогтоолоор хүчингүй болгосон /7 сар 16 хоног мөрдсөн/;
- Засгийн газрын 2021.08.31-ний 275 дугаар тогтоолоор “Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох”, “Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох” журмыг баталж, 2022.09.14-ны 346 дугаар тогтоолоор хүчингүй /1 жил 14 хоног мөрдсөн/ болгож, мөн тогтоолоор дээрх журмыг шинэчлэн баталсан ч 2024.03.06-ны 102 дугаар тогтоолоор дахин хүчингүй болгосон /1 жил 5 сар мөрдсөн/ байна;
- Засгийн газрын 2013.07.06-ны 271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах” журамд 2014.03.07-ны 71, 2020.02.19-ний 70 дугаар тогтоолуудаар нэмэлт өөрчлөлт оруулсан /2 удаа/ ч уг журмыг 2021.11.10-ны 347 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон;
- Засгийн газрын 2014.03.07-ны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох” журамд 2014.07.04-ний 214, 2015.01.26-ны 26, 2016.10.05-ны 111, 2018.02.06-ны 46, 2020.02.19-ний 70 дугаар тогтоолуудаар нэмэлт өөрчлөлт оруулсан /5 удаа/ ч уг журмыг 2021.08.25-ны 264 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна.

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн баримт бичгийн “Дээд боловсролыг хөгжүүлэх”-д чиглэсэн сангаас үзүүлэх үйлчилгээ хангалтгүй байна.

1.17. БЗС-аас үзүүлэх төрийн үйлчилгээ, үйл ажиллагааг зохицуулсан зарим журамд “Алсын хараа 2050”¹³ урт хугацааны бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” бодлогын Боловсролын чиглэлийн 2.1¹⁴ зорилтын хүрээнд 2.1.28¹⁵, 2.1.42¹⁶ үйл ажиллагааг, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-ийн 4.2.4-д “Дээд боловсролын зорилго”-ын 5.1¹⁸, 5.2¹⁹ зорилтын хөтөлбөр, зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ч журмын

¹³ УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

¹⁴ “Боловсрол”-ын зорилт 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүл, амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ”

¹⁵ 2.1.28-д “Нийгэмд нэн чухал боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн болон эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаад суралцагчдыг төрөөс дэмжин

¹⁶ 2.1.42.Боловсролын салбарын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, бүх түвшинд нэвтрүүлэн салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвшин, мэдээллийн аюулгүй байдлыг хангана... гэсэн арга хэмжээ;

¹⁷ “Шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, олон улсын түвшинд нийцсэн, чанартай, тэгш боломжийг олгосон мэдлэг, технологийг тасралтгүй үйлдвэрлэх, хүний нөөцийг бэлтгэх, уян хатан сургалттай, ахисан түвшний судалгаа бүхий дээд боловсролыг хөгжүүлнэ”

¹⁸ Зорилт 5.1 (Чанар): Суралцагчийн хэрэгцээ, шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, олон улсын түвшинд нийцүүлэн чанарыг сайжруулна

¹⁹ Зорилт 5.2 (Хүртээмж): Нээлттэй, уян хатан боловсролыг хөгжүүлэх замаар тэгш боломжийг нэмэгдүүлэх

дагуу сангаас үзүүлэх үйлчилгээний хэрэгжилт, үр дүн хангалтгүй, тодорхой үр нөлөө гараагүй байна.

1.18. “Алсын хараа 2050”-ийн 2.1.28-д “Нийгэмд нэн чухал боловсрол, ...эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хүний нөөцийг бэлтгэж, төр, хувийн хэвшлийн дэмжлэг, хамтын ажиллагааны үр нөлөөтэй зохицуулалт бүрдүүлж, стратегийн ач холбогдол бүхий чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжинэ” гэж заасан үйл ажиллагааны хүрээнд ...тэргүүлэх чиглэлүүдээр хүний нөөц бэлтгэж, стратегийн чиглэлээр гадаадад суралцагчдыг төрөөс дэмжих..., “Тэргүүлэх/эрэлттэй мэргэжлийн жагсаалт”-ыг батлах, шинэчлэх, түүнд тулгуурлан хяналтын тоо, мэргэжил, улс, их сургуулиудыг жил бүр тогтоох зохицуулалттай шууд уялдсан байна.

1.19. Харин Дэлхийн шилдэг их сургуульд суралцах “үндсэн хөтөлбөр”-ийн шаардлагыг хангаагүй, дэлхийн шилдэг сургуулийн жагсаалтын 21-100-д тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцах шаардлагад нийцээгүй, бэлтгэл хөтөлбөрт санхүүжилт олгосон, мөн нэг суралцагчид давхар зээл олгосон зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь хүний нөөцийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, хөрөнгийн үр ашиг буурахад хүргэж байна. /дэлгэрэнгүйг Бүлэг 2-ын 2.26-2.27 заалт, хуудас 26-27-с харна уу/

1.20. Мөн “Алсын хараа 2050”-ийн 2.1.42-д “Боловсролын салбарын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, бүх түвшинд нэвтрүүлэн салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвшин, мэдээллийн аюулгүй байдлыг хангана” гэж заасан ч ...Боловсролын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж чадаагүй, мэдээллийн системийг бодлого-төлөвлөлт-хяналтад бүрэн ашиглах нөхцөл хязгаарлагдмал, БЗС-ийн зээл/тэтгэлгийн бүх өгөгдлийг нэгдсэн платформд нэгтгэж нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, өргөдөл, гомдол-сонгон шалгаруулалт-гэрээ байгуулах-зээл эргэн төлөлт зэрэг бүх үе шатыг мэдээллийн системээр удирдах нөхцөл бүрдээгүй, сангийн ашиглаж буй цахим систем хооронд уялдаагүй, гар ажилбар их шаарддаг, Монгол банкны ЗМС-д мэдээллийг нөхөж оруулсан ч бүртгэлийн чанар, огноо/дүнгийн зөрүүтэй мэдээлэл их, нэгдсэн дата суурьгүйгээс бодлого, төлөвлөлт, хяналт-үнэлгээ мэдээлэлд суурилах боломж хумигдаж байна.

Сангийн “Удирдах зөвлөл” нь дүрмээр хүлээсэн үүргээ огт хэрэгжүүлээгүй, сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт алдагдсан байна.

1.21. Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор²⁰ “Боловсролын зээлийн сангийн дүрэм, орон тооны бус “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүн /2020.02.19 хүртэл хүчин төгөлдөр/, чиг үүргийг баталсан ч тус зөвлөл нь үйл ажиллагаа явуулаагүй, зөвлөлөөс ямар нэгэн шийдвэр, дүгнэлт гараагүйгээс дор дурдсан чиг үүрэг хэрэгжээгүй, сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт алдагдсан байна. Үүнд:

²⁰ Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн 70 дугаар тогтоолоор Боловсролын зээлийн сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орж, Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 374 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/

Дүрслэл 1 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үүрэг

Удирдах
зөвлөлийн
бүрэлдэхүүн

Удирдах зөвлөлийн дарга: БСШУССайд

Удирдах зөвлөлийн дэд дарга: БСШУСЯ-ны ТНБ-ийн дарга

Удирдах зөвлөлийн гишүүд:

1. ХНХЯ-ны ТНБ-ийн дарга,
2. ХЗДХЯ-ны ТНБ-ийн дарга,
3. ГХЭГ-ын Боловсролын асуудал хариуцсан референт,
4. БСШУСЯ-ны Боловсролын газрын дарга,
5. Монгол банкны Мөнгөний бодлогын Бодлогын хэрэгжилт, зээлийн хэлтсийн захирал /зөвшилцсөнөөр/,
6. Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга,

Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга: Боловсролын зээлийн сангийн гүйцэтгэх захирал

Удирдах
зөвлөлийн
үүрэг

- 2.7.1. сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах;
- 2.7.2. сангийн үйл ажиллагааны болон сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлах;
- 2.7.3. сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг даалгавар өгөх;
- 2.7.4. сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэн дүгнэлт өгөх;
- 2.7.5. сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх.

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын 1 дүгээр, 2 дугаар хавсралт

Боловсролын зээлийн сангийн дэргэд 2024 оноос эхлэн "Орон тооны бус зөвлөл"-ийг байгуулсан байна.

1.22. БШУС-ын 2024.06.14-ний өдрийн А/299 дүгээр тушаалаар БЗС-ийн ажлын албаны дэргэд сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан өргөдөл, гомдолд хариу өгөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг²¹ баталсан байна.

1.23. БЗС-ийн ажлын албаны даргын 2024.06.19-ний өдрийн А/48 дугаар тушаалаар "Орон тооны бус зөвлөлийн ажиллах дүрэм"-ийг баталж, ...сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдолд хариу өгөх үүрэг бүхий олон нийтийн оролцоог хангасан чиг үүрэгтэй орон тооны бус Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулна... гэж дүрмийн зорилгыг тодорхойлсон байна.

Дүрэмд ОТБЗ-ийн чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна.

- 2.9.1. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих,
- 2.9.2. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдолд хариу хүргүүлэх, сонгон шалгаруулалтын ажлын хэсгээс шаардлагатай материалыг гаргуулах, санал зөвлөмж гаргаж, ажлын хэсэгт хүргүүлэх,
- 2.9.4. Сонгон шалгаруулалтын дүнг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж байгаа эсэхэд хяналт тавих,
- 2.9.5. Үйл ажиллагааны болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг жил бүр нэгтгэн гаргаж, олон нийтэд мэдээлэх.

Бусад байгууллага, иргэдтэй хамтран ажиллах.

- 4.1.1. чиг үүргийн хүрээнд хамтарсан үнэлгээний ажил гүйцэтгүүлэх.

1.24. БЗС-ийн ажлын албаны дэргэдэх ОТБЗ нь БШУС-ын 2024.05.08-ны өдрийн А/221, А/222 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны явцад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хөндлөнгийн хяналт хэрэгжүүлсэн ч "Орон тооны бус зөвлөлийн ажиллах дүрэм"-ийн 2.9.2-д "Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдолд хариу хүргүүлэх,..." гэсэн үүргийг хэрэгжүүлсэн нотлох баримтгүй байна. Тухайлбал:

²¹БЗС-ийн ажлын албаны даргын 2024.06.19-ний өдрийн А/48 дугаар тушаалаар "Орон тооны бус зөвлөлийн ажиллах дүрэм"-ийн 2.1-д Зөвлөл 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 1, хувийн болон төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын төлөөлөл тус бүр 1, гадаадад төгсөгчдийн төлөөлөл 2 нийт 5 иргэнийг дээрх байгууллагуудаас нэр дэвшүүлж ирүүлсэн иргэнийг сангийн зүгээс боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөлийн гишүүнд хүргүүлж, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн орон тооны бус зөвлөлийн гишүүнээр 3 жилийн хугацаатай томилж чөлөөлнө.

- ОТБЗ-ийн 2024.06.27-ны өдрийн хурлын шийдвэрт²² ...сонгон шалгаруулалтын баримт бичгийн иж бүрдэл хангаагүй 27 суралцагчийн гаргасан өргөдөл, гомдлыг хэлэлцэж... 21 суралцагчийг холбогдох журмын дагуу СЧЕУ-ний шалгалтад оролцуулахгүй, 6 суралцагчийг 2024.07.01-ний өдөр зохион байгуулагдах СЧЕУ-ний шалгалтад оруулахаар шийдвэрлэв... гэж дурдсан ч 21 иргэнд хариу хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй /нотлох баримтгүй/ байна.
- ОТБЗ-ийн 2024.06.27-ны өдрийн хурлын тэмдэглэлд²³... Магистр, докторын хөтөлбөрт суралцах суралцагчдын сонгон шалгаруулалтын баримт бичгийн иж бүрдэл хангаагүй 17 суралцагчийн өргөдөл гомдлыг хянаж ...гомдол гаргасан 15 суралцагчийг холбогдох журмын дагуу дараагийн шатны ярилцлагад оруулах боломжгүй, 2 суралцагчийг 2024.07.01-ний өдөр зохион байгуулагдах ярилцлагад оруулахаар шийдвэрлэв гэж дурдсан ч 15 иргэнд хариу хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй /нотлох баримтгүй/ байна.

Боловсролын ерөнхий хуульд “суралцагчдад тэтгэлэг олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх, буцалтгүй тусламж олгох журмыг батлах, хэмжээг тогтоох” журмыг Засгийн газар батална гэж хуульчилсан байна.

1.25. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн /тухайн үед мөрдөгдөж байсан/ 8 дугаар зүйлийн 8.8-д заасан журмыг УИХ-аас тогтооно гэж хуульчилж байсан бол Боловсролын ерөнхий хуулийн /2023.07.07-ны өдөр баталсан/ 24 дүгээр²⁴ зүйлийн 24.1.1, 24.1.11 дэх заалтаар ...суралцагчдад тэтгэлэг олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх, буцалтгүй тусламж олгох журмыг батлах, хэмжээг тогтоох... гэж Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- хуулийн 24.1.1-д “энэ хуулийн 11.3²⁵, 11.4²⁶, 11.5²⁷-д заасан тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх журмыг баталж, хэмжээг тогтоох;” гэж,
- хуулийн 24.1.11-д “энэ хуулийн 38.8²⁸-д заасан дэмжлэг үзүүлэх, буцалтгүй тусламж олгох журам батлах;” гэж тус тус заасан байна

Албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг 2017-2019 оны хооронд батлаагүй, “Хөдөлмөрийн дотоод журам”-д зарим нэгжүүдийн чиг үүргийг тусгаагүй байна.

1.26. ЗГТСТ /2006 оны/ хуульд Сангийн орон тооны хязгаарыг эрх бүхий байгууллагаас батлах зохицуулалтыг хуульчлаагүй бол 2019 онд шинэчлэн баталсан хуулийн 22 дугаар зүйлийн 22.3²⁹-т орон тооны хязгаарыг Засгийн газар батална гэж хуульчилсан байна.

1.27. Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын 1-д “...орон тооны хязгаар, цалингийн санг баталж мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд ..., Сангийн сайд ... нарт даалгасны дагуу БСШУСС, Сангийн сайдын хамтарсан 2016 оны А/78/351 дугаар тушаалаар “Боловсролын зээлийн сангийн орон тооны хязгаар”-ыг “23” орон тоотой анх /2020 оны 3 дугаар сарын 04-ний өдөр хүртэл/ баталж, Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолоор сангийн орон тооны хязгаарыг “32” гэж тогтоосон байна.

Салбарын сайдаас 2016-2024 оны хооронд Сангийн бүтэц, орон тоог батлахдаа тухайн нэгжид хамаарах албан тушаалын нэр, чиг үүргийг орхигдуулсан байна.

1.28. Салбарын сайдаас 2016-2024 оны хооронд гаргасан 5 удаагийн³⁰ тушаалаар БЗС-ийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан ч Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын³¹ 2 дугаар зүйлийн 2.6³², 2.4³³-т заасныг тус тус бүрэн мөрдлөг болгоогүй, батлагдсан бүтцэд тухайн нэгжид ямар албан тушаал байхыг тусгаагүй байна.

²² БШУС-ын 2024.05.08-ны А/221 дүгээр тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын ажлын хэсэг

²³ БШУС-ын 2024.05.08-ны А/222 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын ажлын хэсэг

²⁴ 24 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

²⁵ 11.3. Гадаадын болон дотоодын мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгоно.

²⁶ 11.4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг олгож болно

²⁷ 11.5. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгоно

²⁸ 38 дугаар зүйлийн 38.8-д “Нийгэм, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, бүс, орон нутгийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээнд үндэслэн мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяас, чадварыг дэмжих, зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгоно”

²⁹ 22.3. Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.13, 5.3.20, 5.3.25-д зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулахыг хориглоно. Ажлын албаны орон тооны хязгаарыг Засгийн газар батална.


³⁰ БСШУС-ын 2020 оны А/109, 2021 А/353, БШУС-ын 2022 оны А/52, 2024 оны А/299 дүгээр тушаалуудаар

³¹ Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан

³² 2.6 Ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, захирлыг томилж, чөлөөлнө.

³³ 2.4 Боловсролын зээлийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.3-т зааснаар Ажлын албатай байх бөгөөд Ажлын албаны орон тооны хязгаарыг Засгийн газар батална

Дүрслэл 2 2016-2024 оны Салбарын сайдын "Боловсролын зээлийн сангийн орон тооны хязгаар батлах тухай" тушаалууд /Дэлгэрэнгүйг хавсралт №1/



Эх сурвалж. Аудитын баг

1.29. Тухайлбал: БШУС-ын 2020 оны А/109 дүгээр тушаалаар "Боловсролын зээлийн сангийн орон тооны хязгаар"-ыг баталсан нь ЗГТСТ хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т "...орон тооны хязгаарыг Засгийн газар батална" гэсэн заалттай нийцээгүй байна.

1.30. БШУС-ын 2024 оны А/256 дугаар тушаалаар сангийн бүтэц, орон тоог "Орон тооны бус зөвлөл"-5, "Захиргаа удирдлагын хэлтэс"-6, "Санхүүгийн хэлтэс"-5, "Сонгон шалгаруулалтын хэлтэс"-4, "Эргэн төлөлт, судалгааны хэлтэс"-4, "Олон нийтийн хэлтэс"-5, "Боловсролын хөгжлийн хэлтэс"-7 зэрэг нийт 6 нэгжид 31 орон тоотой байхаар баталсан ч дээрх бүтцийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнд:


- Сангийн дэргэд Орон тооны бус зөвлөлийг байгуулсан ч Сонгон шалгаруулалтын хэлтэс, Боловсролын хөгжлийн хэлтэс, эргэн төлөлт, судалгааны хэлтсийг байгуулаагүй нь сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг бие даан явуулах боломж бүрдээгүй, гадаад, дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн бүртгэл, санхүүжилт, эргэн төлөлт, тайлагналын үйл ажиллагааг нэгтгэсэн цахим мэдээллийн системгүй, хүний нөөцийн хүрэлцээ, үр чадвар сул зэрэг шалтгаанаар Салбарын сайдын баталсан бүтцээр ажиллаагүй байна.

1.31. Боловсролын сайдын 2025.06.10-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар Боловсролын зээлийн сангийн бүтэц, зохион байгуулалтыг дахин шинэчлэн баталсан ч тухайн бүтцийн нэгжид хамаарах албан тушаал, тэдгээрийн үүргийг батлаагүй орхигдуулсан байна.

БЗС-ийн ажлын албаны дарга нь ТАЗ-өөс баталсан журмыг мөрдлөг болгохгүйгээр "төрийн тусгай" албан тушаалын зэрэглэлтэй албан хаагчийг томилж ажиллуулсан байна.

1.32. БЗС-ийн ажлын албаны даргын 2016-2024 оны хооронд салбарын сайдын тушаалд үндэслэн гаргасан 10 удаагийн³⁴ тушаалаар хэлтэс, нэгжүүдийн албан тушаалын нэршлийг олон янзаар бичиж баталснаас давхардсан тоогоор 2017-2024 оны хооронд 82 албан тушаалын нэршил бий болсон байна.

³⁴ 2016 оны 2/16, 2020 оны А/52, 2021 оны А/55, 2022 оны А/56, А/57, А/62, 2023 оны А/21, А/22, А/80, 2024 оны А/256 дугаар тушаалаар



Эх сурвалж: Аудитын баг

Тухайлбал:

- Хамтын ажиллагаа, хандив, аж ахуйн асуудал эрхэлсэн мэргэжилтэн; Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн; Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, судалгаа хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн;
- Хуулийн зөвлөх, гэрээ, эрхийн мэргэжилтэн, Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Гэрээ, хэлэлцээр, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Төлөвлөлт, тайлагнал, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Мэдээллийн технологи, программ хангамжийн мэргэжилтэн, Систем хөгжүүлэлтийн ахлах мэргэжилтэн
- Төгсөгчдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Төгсөлтийн дараах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

1.33. БЗС-ийн ажлын албаны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар "Сангийн албан тушаал, ажлын байрны нэр, ангилал, зэрэглэл"-д ТЗ-ны албан тушаалын ангиллаар 2 албан тушаалтныг /Захиргааны удирдлагын хэлтсийн дарга ТЗ-4, Сургалтын зээл, тэтгэлгийн хэлтсийн дарга ТЗ-7/ баталж, 3³⁵ ТАХ-ийг сэлгэн ажиллуулах гэрээгээр, шилжин ирсэн 1 албан хаагчийг тус тус томилсон нь "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"³⁶-ын 3.5³⁷-д "Сэлгэн ажиллуулах албан хаагчийг анх илгээсэн байгууллага болон сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хооронд гэрээ байгуулна ..." гэсэн нөхцөлийг дараах албан тушаалтан хангаагүй байна. Үүнд:

Сэлгэн ажилласан албан хаагч:

- Сангийн захирлын 2023 оны Б/47 дугаар ...албан хаагчийг сэлгэн ажиллуулах...тушаалаар "Санхүүгийн алба"-ны даргаар ТТ албан хаагчийг /2023–2025 оны хооронд/ ажиллуулсан байна. Гэвч сэлгэн ажиллуулахдаа ТАЗ-ийн 2019 оны "Төрийн жинхэнэ алба хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 3.5-д заасан "сэлгэн ажиллуулах гэрээ"-г тухайн албан хаагчтай байгуулаагүй байна.

Шилжин ажилласан албан хаагч:

- Сангийн захирлын 2023 оны Б/57 дугаар тушаалаар "Судалгаа, шинжилгээ, статистик хариуцсан ахлах мэргэжилтэн"-д ТТ албан хаагчийг шилжүүлэн томилсон /АА-5 зэрэглэлээр 2024–2025 оны хооронд/ ба ҮСХ-ны 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн албан бичгээр "сэлгэн ажиллуулах боломжгүй" гэсэн хариуг санд ирүүлсэн байна. Гэтэл тус албан хаагчид Төрийн үйлчилгээний албан тушаалтны (ТҮ) цалингийн ангиллаар бус АА-5 ангилалд хэвээр үлдээсэн нь дээрх журмын заалтыг мөрдлөг болгоогүй байна.

³⁵ Гадаад зээл, тэтгэлгийн мэргэжилтнээр ТЗ-10-5 зэрэглэлээр 2022 оны 7 дугаар сараас/ ажиллаж байгаад, Захиргааны удирдлагын хэлтсийн даргаар ТЗ-7 зэрэглэлээр 2022–2024 оны хооронд/, Санхүүгийн албаны дарга ТТ, дэс түшээ зэрэглэлээр 2023–2025 оны хооронд/, Сургалтын зээл, тэтгэлгийн хэлтсийн дарга ТЗ-7 зэрэглэлээр 2022–2024 оны хооронд/

³⁶ ТАЗ-ийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар баталсан

³⁷ 3.5. Сэлгэн ажиллуулах албан хаагчийг анх илгээсэн байгууллага болон сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хооронд гэрээ байгуулна. Гэрээнд тухайн албан хаагчийн ажиллах хугацаа, хариуцан гүйцэтгэх ажлын чиг үүрэг, ажиллах хугацааны цалин хөлс, орон байрны болон бусад зардал, хүлээх хариуцлага, ажлын эцсийн үр дүнг үнэлж дүгнэх зэрэг асуудлыг тодорхой тусгах бөгөөд гэрээнд төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч гарын үсэг зурж баталгаажуулна.

Сан нь 2017-2019 оны хооронд албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг батлаагүй, 2018-2020 оны хооронд мөрдөж байсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д зарим нэгжүүдийн чиг үүргийг тусгаагүй байна.

1.34. БЗС-ийн захирал нь 2017-2019 оны хооронд албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг батлаагүйгээс "хуулийн зөвлөх", "гэрээ, эрхийн мэргэжилтэн", "зээлийн мэргэжилтэн", "төгсөгчдийн асуудал хариуцсан мэргэжилтэн", "зорилтот хөтөлбөрийн мэргэжилтэн" зэрэг албан тушаалтны хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй, сангийн дүрмийн 3.3-т³⁸ "Гүйцэтгэх захирал нь ...сангийн ажилтнуудтай ...тэдгээрийн ажил, үүргийн хуваарийг батлах чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэсэн заалт болон дараах чиг үүрэг хэрэгжээгүй байна.Тухайлбал:

- "...сургалтын төлбөрийн зээлийн болон амьжиргааны зардлын тэтгэлэг олгох гэрээ байгуулах, суралцагчийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл, сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гадаад, дотоодын төсөл хэрэгжүүлэх, зээлийн гэрээний биелэлттэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих, сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах, зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн баталгаа бүрдүүлэх, сургалтын төлбөрийн зээлийн гэрээг зөрчсөн тохиолдолд нэхэмжлэх гаргах, сургалтын төлбөрийн зээлийг төлөхөөс зайлсхийсэн этгээдэд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, сангийн санхүүжилтээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын талаар мэдээллийн сан бүрдүүлэх..." зэрэг чиг үүргүүд хэрэгжээгүй байна.

1.35. Харин Сангийн захирлын 2020 оны А/11, 2021 оны А/56 дугаар тушаалаар албан тушаалтны "Ажлын байрны тодорхойлолт"-ыг, 2022 оны А/62, 2023 оны А/22, 2024 оны А/36 дугаар тушаалаар "Албан тушаалын тодорхойлолт"-ыг тус тус баталж мөрдүүлсэн байна.

1.36. БЗС-ийн захирлын 2018 оны А/18, 2020 оны А/61, 2022 оны А/06 дугаар тушаалаар "Боловсролын зээлийн сангийн хөдөлмөрийн дотоод журам"-ыг баталсан байна.

Дүрслэл 4 Хөдөлмөрийн дотоод журам 2018-2022 он



Эх сурвалж: Аудитын баг

1.37. Гэтэл сангийн захирлын 2018 оны А/18 дугаар тушаалаар баталсан журамд "Зээлийн алба", "Зорилтот хөтөлбөрийн алба" зэрэг дотоод нэгжүүдийн чиг үүргийг орхигдуулсан, ХДЖ-ын 3.6³⁹, 3.8⁴⁰-т тусгасан захиргаа, хүний нөөц, хамтын ажиллагаа, ажлын албанд хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн байхгүй байна.

1.38. 2016 онд баталсан "Боловсролын зээлийн сангийн дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.2.4⁴¹, 5.2.5⁴², 5.2.6⁴³-д заасан чиг үүргийг 2020, 2021, 2023, 2024 оны ажлын байрны болон албан тушаалын тодорхойлолтод тусгасан ч чиг үүргийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

1.39. БСШУС-ын 2015 оны Б/446, БСШУСС-ын 2018 оны Б/058, 2020 оны Б/21 дүгээр тушаалаар "БЗС-ийн захирал"-ын үүрэг гүйцэтгэгч, БШУС-ын 2022 оны Б/15, 2023 оны Б/88, Боловсролын сайдын 2024 оны Б/18 дугаар тушаалаар "БЗС-ийн ажлын албаны дарга"-ын үүрэг гүйцэтгэгч гэсэн албан тушаалд сангийн удирдлагыг томилсон шийдвэр гаргасан байна.

³⁸ 3.3. Гүйцэтгэх захирал нь Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах, зарцуулах, хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, тайлагнах ажлыг зохион байгуулах, сангийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж дүгнэх, тэдгээрийн ажил, үүргийн хуваарийг батлах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

³⁹ 3.6 ажилтан, албан хаагчийн ажилд томилогдсон тушаалын хувийг холбогдох албаны даргад танилцуулах ажлыг Захиргаа, хүний нөөц, хамтын ажиллагаа, ажлын алба хариуцна.

⁴⁰ 3.8 сангийн захирлын эрх олгосны дагуу "Ажил, албан тушаалын нэрийн жагсаалт"-д тусгагдсан байнгын ажлын байранд ажиллах ажилтнуудтай "хугацаагүй", улирлын чанартай болон түр хугацаагаар ажил гүйцэтгүүлэх, бусдын оронд түр ажиллуулах тохиолдолд "хугацаатай" хөдөлмөрийн гэрээг Захиргаа, хүний нөөц, хамтын ажиллагаа, ажлын алба дарга байгуулж болно.

⁴¹ 5.2.4. сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах, зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн баталгаа бүрдүүлэх;

⁴² 5.2.5. сургалтын төлбөрийн зээлийн гэрээг зөрчсөн тохиолдолд нэхэмжлэх гаргах;

⁴³ 5.2.6. сургалтын төлбөрийн зээлийг төлөхөөс зайлсхийсэн этгээдэд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

1.40. Сангийн захирал, ажлын албаны даргын үүрэг гүйцэтгэгчийн шийдвэрээр томилогдсон боловсон хүчин, хүний нөөц нь тогтворгүй, олон удаагийн томилгоо, чөлөөлөлтөөс сангийн үйл ажиллагаа, үүргийн хэрэгжилт хангалтгүй, хүний нөөцийн бодлого төлөвлөлтгүй, нэгж хоорондын хөдөлгөөн ихтэйгээс ажлын байрны чиг үүргийн хэрэгжилт алдагдах эрсдэлийг үүсгэсэн байна. Тухайлбал:

- Сангийн орон тооны дээд хязгаар 2017-2021 оны хооронд “23” байсан бөгөөд албан тушаалтныг тухайн ажлын байранд ил тод, нээлттэйгээр шалгаруулж авсан нь тодорхойгүй /нотлох баримтгүй/, мөн онуудад давхардсан тоогоор шинээр 104 албан хаагчийг томилсон ч, 49 албан хаагч чөлөөлөгдсөн;
- 2022-2024 оны хооронд орон тооны дээд хязгаар “32” болж, албан тушаалтны ажлын байрыг ил тод, нээлттэйгээр зарлан давхардсан тоогоор шинээр 74 албан хаагч томилсон ч, 45 албан хаагч нь “тодорхойгүй” шалтгаан, “өөрийн хүсэлт”-ээр чөлөөлөгдөж тухайн албан тушаалд багадаа 7-28 хоног, дунджаар 11 сар, ихдээ 3 жил орчим хугацаанд ажилласан;
- 2017-2024 оны хооронд Боловсролын зээлийн хэлтэст зээлийн мэргэжилтэн 35, гадаад зээл, тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн 19, сургалтын буцалтгүй тусламжийн хэлтэст буцалтгүй тусламж хариуцсан мэргэжилтэн 12 удаа, Мэдээлэл технологийн хэлтэст мэдээлэл технологи, программ хангамжийн мэргэжилтэн 17, захиргаа удирдлагын хэлтэст дотоод ажил хариуцсан мэргэжилтэн 12, мэргэжилтэн 14, дотоод аудитор 12 удаа тус тус томилогдсон нь боловсон хүчин, хүний нөөц тогтворгүй байсныг харуулж байна;
- Харин Захиргаа, удирдлагын хэлтэст судалгаа, хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн /2022 онд/, төгсөмжийн дараах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /2020 онд/, төгсөгчдийн асуудал хариуцсан мэргэжилтэн /2019 онд/, гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /2022 онд/ зэрэг албан тушаалд нэг удаа томилгоо хийгдсэн ч дахин албан тушаалтан томилогдоогүй байна.

Дүрслэл 5 2016-2024 онд шинээр ажилд томилогдсон ба ажлаас гарсан ажилтны тоо



Эх сурвалж: Аудитын баг

1.41. БЗС-аас 2017-2024 оны хооронд нийт 94 /давхардсан тоогоор/ албан хаагчдын дийлэнх нь өөр албан тушаалд шилжсэн, өөрийн хүсэлт, шалтгаан нь тодорхойгүй, байгууллагын бүтцийн өөрчлөлт зэрэг шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн байна.

Хүснэгт 2 Албан хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн мэдээлэл

№	Гарсан шалтгаан	2017-2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
1	Өөр албан тушаалд шилжсэн	5	10	6	8	5	6	40
2	Өөрийн хүсэлтээр гарсан	7	11	10	4	4	2	38
3	Тодорхойгүй	0	10	1	6	0	13	30
4	Байгууллагын бүтэц өөрчлөлт орсон	3	0	0	7	0	0	10
5	Жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй	5	0	1	0	3	0	9
6	Ар гэрийн гачигдал	0	0	0	3	0	0	3
7	Өөрийн буруугаас байгууллагад хохирол учруулсан	1	0	0	0	0	2	3
8	Хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан	1	0	0	1	0	0	2
9	Гэрээт хугацаа дууссан	0	0	0	0	0	2	2
10	Тэтгэврийн насанд хүрсэн	0	1	0	0	1	0	2
11	Өөрийн хүсэлтээр (Өөр ажилд орсон)	0	0	0	0	0	1	1
12	Өөрийн хүсэлтээр (Гадаад руу явсан)	0	0	0	1	0	0	1
13	Ажлаа хаяж явсан. Шууд тушаал гарсан	0	0	0	1	0	0	1


"Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн" аудитын тайлан							
14	Эрүүл мэндийн шалтгаанаар	1	0	0	0	0	1
15	Хууль хяналтын байгууллагын шалгалт					1	1
	Нийт чөлөөлөгдсөн ажилчдын тоо	15	22	12	16	9	94

Эх сурвалж: Аудитын баг

1.42. Дээрх байдлаас харахад БЗС-аас үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж /хөтөлбөр, суралцагчийн тоо/ нэмэгдсэн, гадаад, дотоодын сургалтын байгууллагад суралцагч болон төгсөгчдийн гэрээний үүргийн биелэлтэд тавих хяналт ихэссэн, цахим мэдээллийн системийн хөгжүүлэлт хангалтгүйгээс цаасан суурьтай баримт бичгийн бүрдүүлбэрт хугацаа их зарцуулах зэрэг шалтгаанаар тодорхойгүй болон өөрийн хүсэлтээр зарим албан хаагч чөлөөлөгдсөн байна.

1.43. БЗС-ийн үндсэн үйл ажиллагааны зардал нь 2017-2024 онд нийт 6,025.4 сая төгрөг ба албан хаагчдын үндсэн цалин, урамшуулалд нийт 3,306.3 сая төгрөг буюу 54.9 хувь нь, 2022 оноос түрээсийн зардалд 508.8 сая төгрөг буюу 16.6 хувь нь тус тус зарцуулагдаж байна.

Дүрслэл 6 Үндсэн үйл ажиллагааны зардлын төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл /сая.төгрөгөөр/



Эх сурвалж: Аудитын баг

1.44. БЗС-ийн үндсэн үйл ажиллагааны зардал нь 2022 оноос нэмэгдсэн харагдаж байгаа ч тухайн онуудад Засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

1.45. Харин БЗС-ийн санхүүжилтийг 2017-2020 онд 13 хөтөлбөрийн хүрээнд жилд дунджаар 24.4 мянган суралцагчид зарцуулж байсан бол 2021 оноос 16 хөтөлбөрийн хүрээнд жилд дунджаар 37.9 мянган суралцагч болж нэмэгдсэн байна.

1.46. Аудитын баг Монгол Улсын БЗС-ийн төрөөс үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагаанд мөрдөж буй эрх зүйн орчныг⁴⁴ гадаадын АНУ, БНХАУ, Өмнөд Солонгос улсын ижил төстэй байгууллагаас "Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцагчд"-д хөнгөлөлттэй болон эргэн төлөгдөх, эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй олгож буй сургалтын төлбөр, амьжиргааны зардлын хэмжээ, хүүгийн хэмжээ, эргэн төлөх хугацаа зэргийг хамруулан харьцуулж үзлээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-с үзнэ үү/

1.47. Монгол Улсын БЗС-аас үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг нь зохицуулж байсан журам /2025.04.30-ны өдөр хүчингүй болж/, Засгийн газраас 2025.04.30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"-д ...Олон улсын болон дотоодын тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээлд хамрагдсан оюутнууд зээлийн эргэн төлөлт нь илүү уян хатан, орлогын түвшинд тохируулан төлөх боломжтой, сургалтын зээлд хүү тогтоогдоогүй, оюутанд төлбөрийн дарамтгүй, илүү хялбар нөхцөлөөр зээл авах боломжийг олгосон давуу талтай ч сангийн хөрөнгийн үр ашиг бага, Улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ жил бүр нэмэгдэж, улсын төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.

⁴⁴ Засгийн газрын 2025.04.30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"

БҮЛЭГ-2: НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН 57 ХУВИЙГ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ЭЗЭЛЖ, ГАДААДЫН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ 1.5 ХУВЬТАЙ, 11.2 САЯ АМ.ДОЛЛАРЫН ЗЭЭЛИЙГ ҮНДЭСЛЭЛГҮЙ ЧӨЛӨӨЛСӨН БАЙНА

Боловсролын зээлийн сангийн хөрөнгийн эх үүсвэр зөвхөн улсын төсвөөс бүрдэж байна

2.1. ЗГТСТ хууль болон ЗГ-ын 2016 онд баталсан Боловсролын зээлийн сангийн дүрэм, 2021 оны 347, 2024 оны 72 дугаар журамд БЗС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл, тусламж, хандив, сургалтын зориулалттай зээлийн төлбөр, тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн хүүгийн орлого зэрэг эх үүсвэрээс бүрдүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- БЗС-ийн хөрөнгийн эх үүсвэр нь 2017-2024 онд "Улсын төсвийн хөрөнгө", Оюутны хөгжлийн зээлийн журмын дагуу 2016-2017 онд дотоодын их, дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлийн хүүгийн орлогын эх үүсвэрээс тус тус бүрдсэн байна.

2.2. Боловсролын зээлийн сан нь улсын төсвөөс эх үүсвэр бүрдүүлж, 2017-2024 онд Дэлхийн шилдэг их сургуулийн зээл, буцалтгүй тусламж буюу тэтгэлэг, Оюутны хөгжлийн буюу дотоодын их, дээд сургуулийн зээлд зориулан нийт 677,291.6 сая төгрөгийн төсөв батлагджээ. Засгийн газраас баталсан холбогдох журмын дагуу нийт 16 хөтөлбөрийн гадаад, дотоодын их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, амьжиргааны зардалд 473,158.5 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 3 Боловсролын зээлийн сангийн 2017-2024 он тус бүрийн суралцагчдын тоо, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн дүн /сая.төгрөгөөр/

он	Дэлхийн шилдэг их сургуулийн зээл		Буцалтгүй тусламж буюу тэтгэлэг		Оюутны хөгжлийн зээл		Нийт хөтөлбөр		Суралцагчдын тоо
	төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл	төсөв	гүйцэтгэл	
2017	21,800.0	20,704.2	22,680.6	21,966.7	41,314.7	2,000.0	85,795.3	44,670.9	20,450
2018	21,800.0	19,254.0	21,807.6	19,006.3	75,000.0	13,222.8	118,607.6	51,483.2	26,469
2019	23,300.0	20,328.6	19,741.5	17,321.3	31,500.0	26,718.9	74,541.5	64,368.8	38,400
2020	15,993.4	6,800.8	15,549.0	6,884.6	10,000.0	6,463.3	41,542.4	20,148.7	12,512
2021	16,408.1	16,407.3	31,356.2	30,648.7	17,377.4	17,377.4	65,141.8	64,433.4	29,413
2022	18,739.2	8,861.4	30,410.3	34,696.8	28,515.5	14,170.5	77,665.0	57,728.7	28,816
2023	10,028.1	9,268.8	59,020.2	52,265.2	21,792.2	5,792.7	90,840.4	67,326.6	25,852
2024	15,329.1	11,970.7	92,121.2	86,679.0	15,707.3	4,348.6	123,157.5	102,998.3	67,661
Нийт дүн	143,397.8	113,595.7	292,686.7	269,468.6	241,207.1	90,094.2	677,291.6	473,158.5	

Эх сурвалж: Аудитын баг

2.3. Гадаад улсын туршлагаас харахад АНУ-ын Засгийн газрын оюутны тусламжийн алба (FSA⁴⁵)-аас олгодог зээл нь жилийн 6.39 хувийн хүүтэй, зээлийн хүүг урьдчилан тооцоолдог нь дараа жилийн хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөх, хянах, сангийн хөрөнгийн тогтвортой байдал, эрсдэлийг удирдах, оюутан төлөлтөө удаан хугацаанд төлж болох уян хатан нөхцөлтэй байдаг байна⁴⁶.

2.4. Засгийн газрын тогтоолоор баталсан 2012-2024 оны хооронд мөрдөж байсан журмуудад сургалтын төлбөрийн зээлд хүү тооцох зохицуулалтгүй байсан бөгөөд цаашид оюутны хөгжлийн болон гадаад улсад суралцагчдын сургалтын төлбөрийн зээлийг тодорхой нөхцөлтэй, хүүтэй болгосноор Улсын төсөвт үзүүлэх ачааллыг багасгах, хөрөнгийн эх үүсвэрийг үр нөлөөтэй зарцуулах боломж бүрдэнэ.

Засгийн газар "Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээл"-ийн хэмжээг жил бүр ялгавартайгаар тогтоох үүргээ хэрэгжүүлээгүй байна.

⁴⁵ FSA/Federal Student Aid

⁴⁶ /эх сурвалж: <https://studentaid.gov/understand-aid/types/loans/subsidized-unsubsidized/>

2.5. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн /2011.07.09-2023.07.07-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр/ 4 дүгээр зүйлд "сургалтын төлбөр"⁴⁷, "суралцагчийн тэтгэлэг"⁴⁸, "сургалтын зээл"⁴⁹, "санхүүгийн дэмжлэг"⁵⁰ гэж хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг баталж байсан бол Дээд боловсролын тухай хуульд /2023 он/ "сургалтын төлбөр" гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг заагаагүй байна.

2.6. Гэтэл Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журам" /2020.02.19-өөс 2021.11.10-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдсөн/-ын 2.1-д "Сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, тухайн улсын амьжиргааны түвшинтэй харьцуулсны үндсэн дээр Засгийн газар жил бүр ялгавартайгаар тогтооно" гэж заасан ч Засгийн газраас сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг тогтоогоогүй байна.

2.7. Дээрх байдлаас шалтгаалж БЗС-аас гадаадын их, дээд сургууль суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг нэхэмжилсэн дүнгээр санхүүжүүлж байгаа нь улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ жил бүр нэмэгдэж, улсын төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.

Засгийн газраас баталсан зарим журамд Гадаадын их, дээд сургуульд суралцагчдад олгох амьжиргааны зардлын хэмжээг хязгаарлаагүйгээс төсвийн хөрөнгийн зарцуулалт нэмэгдэх эрсдэл үүссэн байна.

2.8. Засгийн газрын 2012 оны 19, 2013 оны 271, 2020 оны 70, 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан холбогдох журамд "сургалтын зээл" нь сургалтын төлбөр байна..., сургалтын зээл нь сургалтын төлбөр болон амьжиргааны зардлаас бүрдэнэ ... гэж зааж, зарим журамд ...сургалтын төлбөрт багтах зардал, амьжиргааны зардалд багтах зардлыг тодорхой тусгаж, зарим журамд амьжиргааны зардлын хэмжээг хязгаарлаагүйгээс төсвийн хөрөнгийн зарцуулалт нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна. Үүнд:

Хүснэгт 4 Засгийн газрын тогтоолоор баталсан "...Гадаадын их, дээд сургуульд суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох..." журмын заалтын нэгтгэл судалгаа.

№	Засгийн газрын тогтоолын батлагдсан			Тайлбар
	Огноо, дугаар	Журмын нэр	Журмын заалт	
1	2012.01.18 №19	"Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"	1.3-д "... гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгоно"	Амьжиргааны зардалд ямар зардал багтахыг тусгаагүй
2	2013.07.06 №271	Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам	2.3-д "Сургалтын зээл нь сургалтын төлбөр байна, ...гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн сургалтын төлбөрт суралцаж байгаа сургуулиас нь нэхэмжилсэн хичээлийн багц цагийн төлбөр, эрүүл мэндийн даатгал, гадаад суралцагчийн хураамж, номын сангийн үйлчилгээний төлбөр хураамжийг оруулан тооцно..."	Амьжиргааны зардал тусгаагүй
3	2020.02.19 1№70	Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журам	2.5-д "...сургалтын төлбөрт суралцаж байгаа сургуулиас нь нэхэмжилсэн хичээлийн багц цагийн төлбөр, эрүүл мэндийн даатгал, гадаад суралцагчийн хураамж, номын сангийн үйлчилгээний төлбөр хураамжийг оруулж тооцно.	Амьжиргааны зардал тусгаагүй
4	2024.03.06 №102	Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам	1.5-д "...гадаад улсад суралцах суралцагчид олгох сургалтын төлбөр, дотуур байрны зардлыг тухайн зардлын хэмжээгээр, хүнсний зардлыг Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраас ирүүлсэн гадаадад суралцагчийн тухайн жилийн хүнсний зардлын хэмжээгээр тооцох..., 1.6-д "...амьжиргааны зардалд суралцагчийн дотуур байрны болон хүнсний зардал хамаарна".	Хүнсний зардал гэж ерөнхий тусгасан

⁴⁷ 3.1.3."сургалтын төлбөр" гэж Боловсролын тухай хуулийн 34.1, 36, 11.4-т заасны дагуу Удирдах зөвлөлөөс тогтоосон суралцагчийн төлөх төлбөрийн хэмжээг;

⁴⁸ 3.1.4."суралцагчийн тэтгэлэг" гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцах болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусламжийг;

⁴⁹ 3.1.5."сургалтын зээл" гэж Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу элсэн суралцаж байгаа иргэний сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох зээлийг;

⁵⁰ 3.1.6."санхүүгийн дэмжлэг" гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид буцалтгүй мөнгөн тусламж болон хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгийг.

2.9. БСШУСС-ын 2018.08.22-ны А/523, 2022 оны А/502, 2023 оны А/179, А/548, 2024 оны А/20, А/110 дугаар "Амьжиргааны зардал олгох" тухай тушаалаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг, Хоёр Улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцаж буй суралцагчдад олгох амьжиргааны зардлыг тогтоохдоо ...ГХЯ-аас ирүүлсэн тухайн Улсын их, дээд сургуулиас тогтоосон амьжиргааны зардлын жишгийг үндэслэн сар бүр 40-400 ам.долларын хооронд дараах байдлаар тогтоож тодорхой хязгаарлалтыг бий болгон сайжруулсан байна. Үүнд:

Хүснэгт 5 Салбарын Сайдын тушаалаар баталсан "...гадаадын их, дээд сургуульд тэтгэлгээр суралцагчдад амьжиргааны зардал олгох..." төлбөрийн хэмжээ, хугацааны судалгаа

№	БШУС-ын тушаалын огноо, дугаар	Тэтгэлгийн төрөл	Улсын нэр, суралцах түвшин	Амьжиргааны зардал олгох	
				хугацаа сар бүр	/ам.доллар/ 200
1	2023.04.17-ны А/179	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг			
2	2023.12.05-ны А/548	"Ерөнхийлөгчийн илгээлт 2100" хөтөлбөрийн	Австрали, Их Британи, ХБНГУ, Франц, Польш, Унгар, Чех, Канад, АНУ, Австри, БНСУ, Япон, Тайван /БНХАУ/	сар бүр	400
			ОХУ, Румын, БНХАУ, Вьетнам, Лаос, Литва, Энэтхэг, Казахстан, Болгар, Беларусь, Тайланд, Куба	сар бүр	200
3	2022.11.30-ны А/502, 2024.09.30-ны А/110,	Хоёр Улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр	БНПУ-д 2022-2023 оны болон 2024-2025 оны хичээлийн жилд /бакалавр, магистр/	сар бүр	400
4	2018.08.22-ны А/523		ОХУ-д 2018-2019 оны хичээлийн жилд /магистр, доктор/	жилд	4000
5	2024.01.15-ны А/20		БНКУ-д 2024 оноос 1-6 курст болон хэлний бэлтгэлд суралцагч	сар бүр	200


Эх сурвалж: БСШУСС-ын 2018.08.22-ны А/523, 2022 оны А/502, 2023 оны А/179, А/548, 2024 оны А/20, А/110 дугаар "Амьжиргааны зардал олгох" тухай тушаал

2.10. Цаашид Гадаадын их, дээд сургуульд суралцагчдад олгох амьжиргааны зардлын хэмжээг Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраас ирүүлсэн судалгаанд үндэслэн холбогдох журамд заасан хугацаанд тухай бүр тогтоох нь зохистой байна.

2017-2024 онд дунджаар нийт санхүүжилтийн 57 хувийг буцалтгүй тусламжид зарцуулсан байна.

2.11. 2017-2024 он тус бүрийн Төсвийн тухай хуульд "Боловсролын сайд"-ын багцад батлагдсан төсвөөс тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдсөн 16 хөтөлбөрийн буцалтгүй тусламж /тэтгэлэг/, оюутны хөгжлийн зээл /дотоод/, гадаадын их, дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл, амьжиргааны зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

Дүрслэл 7 Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн нэгтгэл /сая.төгрөгөөр/



Эх сурвалж: Аудитын баг

2.12. Дээрх дүрслэлээс харахад 2017-2020 онд буцалтгүй тусламж/тэтгэлэг/-ийн санхүүжилт дунджаар 27 хувь байсан бол 2021 оноос өсөж, 2024 онд 84 хувь болсон байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит /Засгийн газрын/ тэтгэлэг олгох болсонтой холбоотой байна.

Гадаадын их, дээд сургуульд 2017-2024 оны хооронд нийт 113,595.7 сая төгрөгийн сургалтын төлбөрийн зээл олгосон ч эргэн төлөлт 1.5 хувьтай байна

"Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам" нь холбогдох хуультай нийцээгүй байна.

2.13. ЗГТСТ хуулийн 23.6-д "энэ хуулийн 5.3.2⁵¹-т заасан тусгай сан нь Өрийн удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан Өрийн мэдээллийн нэгдсэн санд зээлийн үлдэгдэлгүй, Зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй этгээдэд зээл олгоно" гэж заасан байна.

2.14. Гэтэл Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын /*тухайн үед мөрдөж байсан*/ 10 дугаар зүйлийн 10.3.7-д "суралцагч ЗГТСТ хуульд заасны дагуу Өрийн мэдээллийн нэгдсэн санд зээлийн үлдэгдэлгүй, Зээлийн мэдээллийн санд бусад этгээдээс авсан хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй байх" гэж заасан нь дээрх хуулийн зохицуулалттай нийцүүлж боловсруулаагүй байна.

⁵¹ 5.3.2. "Боловсролын зээлийн сан"

2.15. Авлигын эсрэг хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Авлигатай тэмцэх газрын албан хаагч нь эрдэм шинжилгээнийхээс бусад хуулиар тогтоосон үүрэгтэй нь үл хамаарах ажил хавсран гүйцэтгэхийг хориглоно" гэж заасан байна.

2.16. Гэтэл "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.8⁵²-д "... сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ...Авлигатай тэмцэх газар, ...байгууллагын төлөөллөөс бүрдсэн... байгуулна" гэж заасан нь дээрх хуулийн зохицуулалттай нийцүүлж боловсруулаагүй байна.

Боловсролын зээлийн сангийн дүрэм, холбогдох журамд ...Гадаадын их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх... гэж заасан ч журмын хэрэгжилт хангалтгүй байна.

2.17. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9⁵³-т "...сургалтын зээлийг буцаан төлүүлэхдээ зээлдэгчийн амьжиргаанд нь дарамт үүсгэхгүйгээр суутгал хийхээр журамлана...", 8.10⁵⁴-д "...улсын төсвөөс олгох сургалтын зээл нь хөнгөлөлттэй, эргэн төлөгдөнө" гэж зааж, уг хуулийн хэрэглээний явцад БЗС-ийн дүрэм⁵⁵, Засгийн газрын 2021 оны 347, 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан дараах журамд ...Гадаадын их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх... тухай заалтыг тусгасан ч 2017-2024 оны хооронд гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн 299 иргэн 19,927.8 мянган.ам долларын сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлөөгүй байна. Үүнд:

- Боловсролын зээлийн сангийн дүрмийн⁵⁶ /2016.10.05-аас 2021.11.10-ны хооронд мөрдсөн/ Удирдах зөвлөлийн үүргийн 2.7.5-т " сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх" гэж,
- Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын⁵⁷ /2021.11.10-аас 2024.02.28-ны хооронд мөрдсөн/ 6.4-т "Гадаадын их, дээд сургууль төгсөгч нь сургууль төгсөж, диплом авсан өдрөөс эхлэн 8 хүртэлх, ...жилийн дотор зээлийг төлж дууссан байхаар эргэн төлөлтийн хуваарийг гаргаж, зээлийн гэрээнд тодорхой тусгана" гэж,
- Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журмын⁵⁸ /2024.03.06-аас 2025.04.30-ны хооронд мөрдсөн/ 2.3.6-т "гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан санхүүжилтийг зогсоох, суутгах, эргэн төлүүлэх;" 10.16-т "Зээлийн эргэн төлөлтийн хуваарийг..., гадаадын сургалтын байгууллагад суралцсан бол төгсөөд 10 хүртэл жилийн дотор эргэн төлж дуусахаар сантай тохиролцон тогтооно" гэж тус тус заасан байна.

Гадаадын их, дээд сургуульд суралцах иргэдийн 2017-2023 оны сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн нотлох баримт байхгүй.

2.18. Салбарын сайдаас 2017-2024 оны хооронд гаргасан 29 удаагийн тушаалаар Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах "Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг байгуулах шийдвэрийг гаргасан байна.

- "Гадаадын их, дээд сургуульд БЗС-ийн санхүүжилтээр 2017-2018 он, 2019-2020 он, 2020-2021 он, 2023-2024 он, 2024-2025 оны хичээлийн жилд бакалавр, магистрантур, докторантурт суралцахаар шалгуулагчдын баримт бичигт дүн шинжилгээ хийх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах "Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг (2017 оны А/90, 2019 оны А/312, А/339, 2020 оны А/295, 2023 оны А/75, А/258, 2024 оны А/221 дүгээр тушаалаар) томилсон,
- Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын БСШУЯ болон гадаад Улсын холбогдох яам хооронд байгуулсан санамж бичиг, хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2017-2018 он, 2019-2020 он, 2020-2021 он, 2023-2024 он, 2024-2025 оны хичээлийн жилд бакалавр, магистрантур, докторантурт суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион

⁵² 11.8.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн их, дээд сургууль, сан, төрийн бус болон мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

⁵³ 8.9.Суралцагчид олгох сургалтын зээлийн нийт хэмжээ нь суралцагчийн суралцах хугацааны сургалтын төлбөр, амьжиргааны зардлын нийлбэрээс хэтрэхгүй байх бөгөөд сургалтын зээлийг буцаан төлүүлэхдээ зээлдэгчийн амьжиргаанд нь дарамт үүсгэхгүйгээр суутгал хийхээр журамлана.

⁵⁴ 8.10.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид улсын төсвөөс олгох сургалтын зээл нь хөнгөлөлттэй, эргэн төлөгдөнө.

⁵⁵ Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор баталсан

⁵⁶ Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан

⁵⁷ Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан

⁵⁸ Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан

байгуулах "Монголын талын бүрэлдэхүүнийг (2017 оны А/07, А/130, 2018 оны А/010, 2019 оны А/15, 2020 оны А/245, А/297, 2021 оны А/89, А/216, А/62, 2022 оны А/50, А/264, 2023 оны А/164, 2024 оны А/35, А/124, А222 дугаар тушаалаар) томилсон,

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэгт хамрагдах иргэнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг (БСШУС-ны 2021 оны А/362, А/470, 2022 оны А/03, 2023 оны А/323 дугаар тушаалаар) томилсон,
- Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэгийн дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад, гадаадын их сургуулийн магистр, докторын үндсэн хөтөлбөрт 2022-2023, 2023-2024 оны хичээлийн жилд суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг (2022 оны А/75, А/91, 2023 оны А/17, А/86 дугаар тушаалаар) тус тус томилсон байна.

2.19. Гэтэл Боловсролын яамнаас аудитын явцад БСШУСС-ын 2017 оны А/07, А/90, 2018 оны А/010, 2019 оны А/15, А/312, А/339, БСШУС-ын 2020 оны А/245, А/295, А/297 дүгээр, БШУС-ын 2021 оны А/89, А/216, А/62, А/362, А/470, 2022 оны А/03, 2023 оны А/164, А/323 дугаар тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн сонгон шалгаруулалтын баримт материалыг ирүүлээгүй.

2.20. Дээрх тушаалд заасан "Ажлын хэсэг" нь Гадаадын их, дээд сургуульд бакалавр, магистрантур, докторантурт суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулсан эсэх, ажлын хэсгийн гишүүд шалгуулагчийн онооны үнэлгээг гаргасан эсэх, гишүүдийн үнэлгээг нэгтгэж баталгаажуулсан эсэх, хуралдааны тэмдэглэл үйлдсэн эсэх, шалгаруулалтын нэгдсэн дүнг салбарын Сайд, гадаад Улсын ЭСЯ-дад хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал:

- "Гадаадын их, дээд сургуульд БЗС-ийн санхүүжилтээр 2017-2018 он, 2019-2020 он, 2020-2021 онд бакалавр, магистрантур, докторантурт суралцахаар шалгуулагчдын баримт бичигт дүн шинжилгээ хийсэн эсэх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан эсэх,
- Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд тэтгэлгээр БНХАУ, Унгар улс, Украйн улсад 2017-2018 он, 2019-2020 он, 2020-2021 он, 2021-2022 он, 2023-2024 оны хичээлийн жилээс бакалавр, магистр, докторын сургалтад суралцах иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан эсэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэгт хамрагдах иргэнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий БСШУС-ын 2021 оны А/362, А/470, БШУС-ын 2022 оны А/03, 2023 оны А/323 дугаар тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг" сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан эсэхэд аудитын горим хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй, харин холбогдох журамд заасан шаардлагыг зөрчиж, суралцагчтай гэрээ байгуулж, сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж олгосон алдаа зөрчлүүд гарсан.

2023 оны Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн иргэний нийт үнэлгээг баримтжуулаагүй.

2.21. БШУС-ын 2023.06.15-ны өдрийн А/258 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нийт 133 иргэний жагсаалт, үүнээс тэнцээгүй 40 иргэний жагсаалтыг үйлдээгүй, сонгон шалгаруулалтын нийт үнэлгээний жагсаалтыг баталгаажуулаагүй байна. Тухайлбал:

- Дэлхийн шилдэг 50 их сургуулийн бакалаврын хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын явцын мэдээлэл танилцуулгад ...Дэлхийн шилдэг 50 их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах 133 иргэн бүртгүүлсэн. Бичиг баримтын бүрдэл дэх гадаад хэлний оноо, сургуулийн эрэмбийн шаардлага хангаагүй 40 иргэнд цахим шуудангаар хариу хүргүүлсэн... гэж дурдсан ч нийт бүртгүүлсэн 133 иргэний жагсаалт, тэнцээгүй 40 иргэний жагсаалт байхгүй /номлох баримтгүй/.
- Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг "Дэлхийн шилдэг 50 их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах"-аар хүсэлт ирүүлсэн иргэдийн суурь шаардлагын онооны жагсаалт /огноо бичигдээгүй, баталгаажаагүй/, мөн суралцахаар хүсэлт ирүүлсэн иргэдийн нийт үнэлгээний жагсаалт⁵⁹ /огноо бичигдээгүй, баталгаажаагүй/ үйлдсэн хугацаа тодорхойгүй, ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулаагүй байна.

⁵⁹ Дэлхийн шилдэг 50 их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцахаар хүсэлт ирүүлсэн иргэдийн нийт үнэлгээний жагсаалт нь 14 баганад /суралцагчийн дугаар, Овог, нэр, Сургуулийн нэр, ranking, IELTS TOEFL, Мэргэжлийн чиглэл, Сургуулийн эрэмбэ-СЭ, Тэргүүлэх мэргэжлийн чиглэл-ТМ, Хэлний шалгалтын оноо-ГД, Голч оноо-ГД, 1 шат нийт, Суралцах чадварын ерөнхий үнэлгээ-СЧЕУ, нийт авсан оноо/ мэдээлэл боловсруулагдсан.

Салбарын сайд нь сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн онооны эрэмбэ, дарааллыг харгалзахгүйгээр суралцуулах шийдвэрийг гаргасан байна.

2.22. Мөн БШУС-ын 2023.11.02-ны өдрийн А/475 дугаар "Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах" тухай тушаалд сонгон шалгаруулалтад нэр нь ороогүй иргэн, ажлын хэсгээс гаргасан "Дэлхийн шилдэг 50 их сургуулийн бакалаврын хөтөлбөр"-т суралцахаар хүсэлт ирүүлсэн иргэдийн нийт үнэлгээний жагсаалтад багтсан иргэдээс онооны эрэмбэ, дарааллыг харгалзахгүйгээр зарим иргэнийг сонгож, суралцуулах шийдвэр гаргасан байна. Үүнд:

- СШАХ⁶⁰-ээс гаргасан "Дэлхийн шилдэг 50 их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах"-аар хүсэлт ирүүлсэн иргэдийн суурь шаардлагын онооны жагсаалт, нийт үнэлгээний жагсаалтад нэр нь ороогүй /тэнцээгүй/ нэг иргэнийг БШУС-ын 2023.07.07-ны өдрийн А/293 дугаар тушаалаар баталсан Дэлхийн шилдэг их сургуулийн эхний 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт СТЗ-ээр суралцах суралцагчдын нэрсийн жагсаалтын 48-д "Т.Ц нь Торонтогийн их сургуульд Хими, физикийн шинжлэх ухааны мэргэжлээр 4 жил суралцах" гэж баталсан,
- БШУС-ын 2023.11.02-ны өдрийн А/475 дугаар тушаалаар баталсан "Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" жагсаалтад нийт 8 иргэнээс 1 иргэнийг 14.6 оноотой 59-д эрэмбэлэгдсэн үндэслэн сонгосон ч 7 иргэнийг сонгохдоо 14.5-14.2 оноотой, 60-65-д эрэмбэлэгдсэн иргэнийг сонгоогүй, харин 14-11.9 оноотой 69-87-д эрэмбэлэгдсэн /14 оноогоор 69-71-д, 13.9 оноогоор 73-д, 13,4 оноогоор 78-д, 12 оноогоор 86-д, 11.9 оноогоор 87-д/ иргэнийг сонгож баталсан байна.

Салбарын сайд анх баталсан хяналтын тооноос хэтрүүлэн суралцуулах шийдвэр гаргасан байна.

2.23. "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 1.9⁶¹-д заасан хугацааг мөрдлөг болгоогүй, 11.9.3⁶²-т заасныг мөрдлөг болгохгүйгээр хяналтын тоог нэмж батлан, суралцуулах шийдвэр гаргасан байна. Үүнд:

- БШУС-ын 2024.06.19-ний өдрийн А/305 дугаар тушаалаар "...Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 2024 онд сургалтын зээл олгох хяналтын тоог 70 байхаар баталж⁶³, Боловсролын сайдын 2024.08.02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар уг хяналтыг тоог 90 гэж өөрчилж баталсан нь журмын 1.9-д "...хяналтын тоо, ...жил бүрийн I улиралд багтаан тогтооно" гэсэн хугацааг мөрдлөг болгоогүй байна,
- Боловсролын яамнаас 2024.07.22-ны өдрийн 2/32 дугаар БЗС-д хүргүүлсэн албан бичигт..., Сонгон шалгаруулалтын үр дүнтэй холбогдуулан СЧЕУ-ний шалгалтад оролцож, хяналтын тоонд багтаагүй 9 суралцагч, өргөдөл гомдол ирүүлсэн Ажлын хэсгийн дүгнэлтэд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлж буй иргэдийн асуудлаар Олон нийтийн зөвлөл болон Ажлын хэсгийг дахин хуралдуулан хариуг ирүүлнэ үү⁶⁴... гэж дурдсан,
- Ажлын хэсгийн сонгон шалгаруулалтын дүнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, асуулгын 2024.08.20-ны өдрийн №01 тэмдэглэлд ...гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчдын хяналтын тоо 90 болж нэмэгдсэн учир өмнөх хяналтын тоонд багтаагүй СЧЕУ-ний шалгалт өгсөн 9 иргэнийг нэмж, баримт бичгийн бүрдлийн шаардлага хангаагүй хасагдсан 4 иргэнийг нэмж оруулах асуудлыг олонхын саналаар дэмжиж шийдвэрлэсэн,
- БЗС-аас 2024.08.21-ний өдрийн Боловсролын сайдад хүргүүлсэн 749 тоот албан бичигт... өмнөх хяналтын тоонд багтаагүй СЧЕУ-ний шалгалт өгсөн 9 иргэнийг нэмж оруулах..., ОТБЗ-өөс 2024.08.09-ний өдөр ...өргөдөл гомдол гаргасан 4 иргэнийг⁶⁵ асуудлыг хэлэлцсэн дүгнэлт..., СШАХ-ээс 2024.08.14-ний өдөр нийт 13 иргэний нэрсийг нэмэлтээр хүргүүлсэн байна... гэж дурдсан,

⁶⁰ БШУС-ын 2023.07.07-ны өдрийн А/293 дугаар тушаалаар байгуулагдсан

⁶¹ 1.9-д "Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тухайн жил тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах суралцагч (магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах төрийн албан хаагч болон бусад)-ийн хяналтын тоо, ... жил бүрийн I улиралд багтаан тогтооно"

⁶² 11.9.3-д "энэ журмын 11.9.2-т заасан шалгалт авахад оноо тэнцсэн суралцагчдын тоо хяналтын тооноос хэтэрсэн тохиолдолд сургалтын байгууллагын эрэмбийг, дахин тэнцвэл гадаад хэлний мэдлэгийн түвшнийг, дахин тэнцвэл Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх, эрэлтэй мэргэжлийн чиглэлийн эрэмбийг харгалзан үзэж шалгаруулна"

⁶³ БШУС-ын 2024.06.19-ний өдрийн А/305 дугаар тушаалын 2-т "Дэлхийн шилдэг их сургуульд суралцагчдад 2024 онд сургалтын зээл олгох хяналтын тоог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Times Higher Education World University Rankings" эсхүл "Academic Ranking of World Universities" байгууллагын сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 50-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан суралцагчдад нийт зээл олгох хяналтыг тоог 70 байхаар баталсугай.

⁶⁴ БШУС-ын 2024 оны А/305 дугаар тушаалаар 2024 онд гадаадын сургалтын байгууллагад зээлээр суралцах иргэдийн хяналтын тоо нь 70 байхаар баталсан боловч төсвийн нөөц хүрэлцээтэй байх тул хяналтын тоог нэмэгдүүлэх боломж байна


⁶⁵ 4 иргэн баримт бичгийн бүрдэл хэсгийн сонгон шалгаруулалтын үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй

- Боловсролын сайдын 2024.07.23-ны өдрийн А/04 дугаар тушаалаар "БЗС-ийн санхүүжилтээр Гадаадын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт суралцах 70 иргэд, мөн сайдын 2024.09.09-ний өдрийн А/71 дүгээр тушаалаар 13 иргэдийн жагсаалт, нийт 83 иргэнийг жагсаалтаар баталсан нь салбарын Сайд, СШАХ, сангийн дэргэдэх ОТБЗ нь холбогдох журмын 11.9.3-т "энэ журмын 11.9.2⁶⁶-т заасан шалгалт авахад оноо тэнцсэн суралцагчдын тоо хяналтын тооноос хэтэрсэн тохиолдолд сургалтын байгууллагын эрэмбийг, дахин тэнцвэл гадаад хэлний мэдлэгийн түвшин, дахин тэнцвэл Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлийн эрэмбийг харгалзан үзэж шалгаруулна" гэсэн заалтыг баримтлаагүй, хяналтын тооноос хэтэрсэн суралцагчийг суралцуулах шийдвэр гаргасан байна.

Гадаадын их, дээд сургуульд 2017-2024 оны хооронд бакалаврын хөтөлбөрт суралцуулах 22 удаагийн тушаалаар суралцагчийн гэрээний хугацааг сунгах, сургууль, мэргэжил өөрчлөх, суралцагчийн овог, нэрийг сольсон шийдвэрийг гаргасан байна.

2.24. Салбарын сайдын "Дэлхийн шилдэг их, дээд сургуульд" 2017-2024 оны хооронд 280 суралцагч "Бакалаврын хөтөлбөрт" 2017 оны 4, 2018 оны 7, 2019 оны 3, 2020 оны 3, 2023 оны 4, 2024 оны 3-н суралцуулах тушаалаас гэрээний сунгалт хийсэн 6, сургууль, мэргэжил сольсон 9, суралцагчийн овог, нэрийг сольсон 12, нийт 22 шийдвэрт өөрчлөлт оруулсан байна.

Хүснэгт 6 2017-2024 оны хооронд БЗС-ийн Гадаадын сургуульд сургалтын төлбөрийн зээлээр суралцагчдад олгосон санхүүжилт /сая ам.доллар/



Эх сурвалж: Аудитын баг

2.25. Дээрх дүрслэлээс харахад БЗС нь Салбарын сайдын 2020 оны А/115, А/155, А/179 дүгээр тушаалаар 46 суралцагчид 7,306-98,058.42 ам.доллар, 37 суралцагчид 103,064.8-257,088.99 ам.долларын сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг санхүүжүүлсэн нь тухайн үед мөрдөж байсан журамд сургалтын төлбөрийн нэхэмжилсэн дүнгээр олгож байсантай холбоотой байна.

Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн бакалаврын хөтөлбөрт 22 суралцагч үндсэн ангид бус бэлтгэл хөтөлбөрт, 123 суралцагч тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй байна.

2.26. Дэлхийн шилдэг их сургуульд бакалаврын хөтөлбөрт суралцах 22 суралцагч үндсэн ангид суралцах байтал "бэлтгэл хөтөлбөр"-т суралцаж сайдын 6 удаагийн шийдвэрээр суралцуулах хугацааг 1-2 жилээр сунгасан нь Засгийн газрын 2013 оны 271⁶⁷, 2022 оны 346⁶⁸, 2024 оны 102⁶⁹ дугаар журамд заасан шалгууртай нийцээгүй байна. /22 суралцагчид тухайн үеийн Монгол банкны ханшаар 1,813.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон/ Тухайлбал:

⁶⁶ 11.9.2.энэ журмын 11.9.1-д заасны дагуу шалгарсан суралцагчдаас ажлын 5 өдрийн дотор суралцах чадварын ерөнхий үнэлгээний шалгалт авах;

⁶⁷ 1.4. Энэхүү журмын 1.3-т заасан жагсаалтын эхний 20-д багтсан их сургуулийн суралцагч мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр, 21-100-д багтсан их сургуульд Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр суралцагч сургалтын зээлд хамрагдах хүсэлт гаргах эрхтэй.

⁶⁸ 2.1.17... эхний 50-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах, 50 ба түүнээс дээш хувийн сургалтын тэтгэлэг авсан суралцагч;


⁶⁹ 10.7.5 ... эхний 20-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-50-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах

- Салбарын сайдын 2017.08.17-ны өдрийн А/118 дугаар тушаалаар "...2016 оны А/215 дугаар тушаал дахь Манчестрийн их сургууль..." гэснийг "Свонсий их сургууль, Боловсрол судлал 3 жил" гэж өөрчлөн баталж, тухайн суралцагч нь 2016-2018 оны хооронд 2 жил бэлтгэл хөтөлбөрт, 2018-2022 оны хооронд үндсэн ангид нийт 6 жил сурч 91,692 ам.долларын зээл авсан байна.
- Салбарын сайдын 2018.05.04-ний өдрийн А/275 дугаар тушаалаар "...2014 оны А/219 дугаар тушаалын Б.Ш-ийг М.М, Их Британи Умард Ирландын нэгдсэн Вант улс, Манчестрийн их сургууль, математик, Олон улсын бизнес, санхүү эдийн засаг, 3 жил гэж" өөрчлөн баталж 1 жил бэлтгэл хөтөлбөрт сурсан байна.
- Салбарын сайдын 2018.05.04-ний өдрийн А/275 дугаар тушаалаар "...2016 оны А/215 дугаар тушаал дахь З.Д-г О.А, АНУ, Массачусетсийн их сургууль, олон улсын бизнесийн удирдлага, 4 жил", 2023.03.03-ны өдрийн А/80 дугаар тушаалаар "...О.А-ийн БЗС-тай байгуулсан гэрээний хугацааг 1 жилээр сунгах" гэж тус бүр өөрчлөн баталж 1 жил бэлтгэл хөтөлбөрт сурсан байна.
- Салбарын сайдын 2017.01.25-ны өдрийн №А/21 дугаар тушаалаар "...2014 оны А/219 дугаар тушаалын Л.Э-г Б.О, Нагоя их сургууль, график дизайн 4 жил" гэж өөрчлөн баталж 1 жил бэлтгэл хөтөлбөрт сурсан байна.

2.27. Дэлхийн шилдэг их, дээд сургуулийн эхний 20-д багтаагүй сургуульд тэргүүлэх, эрэлттэй мэргэжил харгалзахгүйгээр суралцуулах шийдвэртэй ч, 21 удаагийн тушаалаар тухайн суралцагчийн сургууль мэргэжил, овог нэр сольсноос 123 суралцагч /8.5 сая ам.доллар бөгөөд өнөөдрийн Монгол банкны ханшаар 30.4 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна/ буюу 43.9 хувь нь тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй байна.

- Салбарын сайдын 2017.01.25-ны өдрийн А/21 дугаар тушаалаар "... 2014 оны А/219 дугаар тушаалын Л.Э-г Б.О, ... 4 жил" гэж өөрчлөн баталж, тухайн суралцагч нь тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй байна.
- Салбарын сайдын 2018.05.04-ний өдрийн А/275 дугаар тушаалаар "... 2014 оны А/219 дугаар тушаалын Б.Ш-г М.М, ...3 жил" гэж өөрчлөн баталж, тухайн суралцагч нь тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй байна
- Салбарын сайдын 2014 оны А/219 дүгээр тушаалаар "...Г.Ц-г 2018.06.25-ны өдрийн А/407 дугаар тушаалаар О.А, ...4 жил" гэж өөрчлөн баталж, тухайн суралцагч нь дэлхийн шилдэг сургуульд болон тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй байна
- Салбарын сайдын 2018.05.21-ний өдрийн А/300 дугаар тушаалаар "2014 оны А/319 дүгээр тушаалын А.Н-г Э.О, ...4 жил" өөрчлөн баталж, тухайн суралцагч нь тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй байна.

Дүрслэл 8 Дэлхийн шилдэг их сургуулийн эхний 20-д багтаагүй сургуульд тэргүүлэх, эрэлттэй мэргэжил харгалзахгүйгээр сургалтын төлбөрийн зээлээр суралцсан суралцагчийн тоо




Эх сурвалж: Аудитын баг

2.28. Салбарын сайдын 2017-2024 оны "Дэлхийн шилдэг их, дээд сургууль"-д бакалаврын хөтөлбөрт суралцуулах шийдвэртэй 138 суралцагч буюу 49.2 хувь нь "Мэдээлэл, харилцаа холбооны технологи", "Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж"-ийн чиглэлээр суралцсан ч "Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгэл зүй"-н мэргэжлээр 31 суралцагч буюу 11 хувьтай байгаа нь мэргэжлийн ажиллах хүчний тэнцвэргүй байдал бий болох нөхцөл үүсэж эхэлж байна.

2.29. Боловсролын сайдын 2024 оны А/11 дүгээр тушаалын дагуу баталсан "Мэргэжлийн чиглэл, индекс"-ийн ерөнхий төрлөөр нь харвал:

Дүрслэл 9 2017-2024 онд сурсан суралцагчдыг мэргэжлийн чиглэл, индексээр харвал



Жич: Тодорхой бус 14 суралцагчаас 3 суралцагч бэлтгэл хөтөлбөрт сурсан ба үлдсэн 11 суралцагч нь сургалтын гэрээгүй, гэрээ байгуулахаас татгалзсан суралцагчид юм. Эх сурвалж: Аудитын баг

Зээл эргэн төлөөгүй гурван суралцагчид дахин зээл олгосон байна.

2.30. "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 3.1-т "Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг нэг суралцагчид нэг удаа олгоно" гэж заасан ч дараах суралцагчийг салбарын сайдын 2000-2018 оны хооронд гаргасан шийдвэрээр сангаас авсан зээлээ эргэн төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, ЗМС-д давхар бүртгэлтэй 3 иргэнд дахин зээл олгох тушаал гаргасан байна. Үүнд:

- 2016.03.30-ны өдрийн А/112 тушаалаар суралцах эрх авсан ч 2018.11.07-ны өдрийн А/694 тушаалаар өөрчлөлт оруулсан суралцагч 1,153,000₮-н зээл 2000 онд авч, 2016 оноос эхлэн 3 жил суралцаж 48,000 ам.долларын зээл авсан байна.
- ЗМС-д 2013 онд зээл олгосон огноотой, зээлийн хэмжээ нь 201,559 ам.доллар байна. 2017.08.22-ны өдрийн А/125 тушаалаар дахин 32,000 ам.долларын зээл олгосон байна. Тухайн суралцагчид олон удаа тушаалын өөрчлөлт оруулсан байна. Үүнд: 2017.08.22-ны өдрийн А/125 дугаар тушаалд "New York University" гэснийг 2017.12.27-ны өдрийн А/421 дүгээр тушаалаар SMU Meadows сургууль, 2018.06.27-ны өдрийн А/421 дүгээр тушаалаар SMU Meadows school of art болгож тус тус өөрчилсөн.
- 2018 оны А/368 дугаар тушаалд сургууль University of Massachusetts гэснийг 2018.06.27-ны А/421 дүгээр тушаалаар University of Glasgow гэж өөрчлөн баталсан суралцагч нь ЗМС-д 2014 онд зээл олгосон огноотой, зээлийн хэмжээ нь 209,835.53 ам.доллар байгаа ба 2018 онд дахин 16,000 ам.долларын зээл авч сурсан байна.
- Тус 3 суралцагчийн нийт зээлийн үлдэгдэл нь Монгол банкны 2025 оны 8 дугаар сарын ханшаар тооцоолбол 1,8 тэрбум төгрөг байна. Зээлийн гэрээг зөрчсөн ч дахин зээл олгосон

нь журмын хэрэгжилтийг алдагдуулж, сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл бий болгож, ...нэг удаа зээл олгох ёстой.. гэсэн заалтыг мөрдөөгүйгээс бусад суралцагчдад олгох боломжийг хааж, тэгш байдлыг алдагдуулсан байна.

Магистрын хөтөлбөрт зээлээр суралцсан 4 иргэн журмын шаардлага хангаагүй байна.

2.31. Салбарын сайдын 2017-2020 оны хооронд нийт 19 тушаалаар гадаадын их, дээд сургуульд магистр 169, докторын хөтөлбөрт 23 суралцагч сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлээр суралцуулах шийдвэр гаргасан байна.

2.32. Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 1.2-т "Энэхүү журам нь ...гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын зэргийн боловсрол эзэмшихээр зохих журмын дагуу элсэн өдрийн ангид суралцаж ...", 3.2-т "Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг магистрантад 2 жил, докторантад 3 жил хүртэлх хугацаатайгаар ...болгоно" гэж тус тус заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Салбарын сайдын 2014.10.08-ны өдрийн А/398 дугаар тушаалд 2 жил гэснийг 2017.04.21-ний өдрийн А/150 дугаар тушаалаар 4 жил гэж өөрчлөн баталж суралцсан суралцагч нь хэлний бэлтгэл болон бакалаврын хөтөлбөрт суралцсан байна.
- Салбарын сайдын 2023.03.03-ны А/80 дугаар тушаалаар 2020.10.23 №А/114 тоот тушаалд University of York гэснийг Griffith University гэж өөрчлөн баталж суралцсан суралцагч нь 2020 онд 1 жил бэлтгэл хөтөлбөрт сурсан ба 2023-2024 оны хооронд дахин санхүүжилт авсан байна.
- Салбарын сайдын 2019.11.15-ны өдрийн А/738 дугаар тушаалаар 2018 оны А/368 тоот тушаал дахь 2 жил гэснийг 3 жил гэж өөрчлөн баталж магистрын хөтөлбөрт 3 жилийн санхүүжилт авч суралцсан байна
- 2019.03.07-ны өдрийн А/120 дугаар тушаалаар 2017 оны А/125 тушаал дахь University of Illinois at Chicago гэснийг Shinhan University гэж өөрчлөн баталж мөн 2023.03.03-ны өдрийн А/80 дугаар тушаалаар 2017 оны А/125 тушаал дахь боловсрол, магистр, 2 жил гэснийг боловсрол, доктор, 3 жил болгон өөрчлөн баталсан байна. Тухайн суралцагч нь 2018, 2019, 2022 онуудад 40,500 ам.долларын санхүүжилт авч суралцсан.

278 суралцагчийн хувийн хэрэгт үл хөдлөх хөрөнгийн лавлагаа хавсаргаагүй, 178 суралцагчийн барьцаа хөрөнгө нь сургалтын төлбөрийн зээлийн дүнд хүрэхгүй байна.

2.33. Сангийн санхүүжилтээр гадаадын ДБСБ-д сургалтын төлбөрийн зээлээр суралцах иргэдтэй гэрээ байгуулахдаа Засгийн газрын 2012 оны 19⁷⁰, 2013 оны 271⁷¹, 2021 оны 347⁷², 2024 оны 102⁷³ дугаар журмуудаар үл хөдлөх хөрөнгө барьцаалахаар тусгаж, БСШУС, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 70/369⁷⁴ дүгээр, БШУС, Сангийн сайдын хамтарсан 2014 оны А/169/93⁷⁵ дугаар, 2022 оны А/544/256⁷⁶ дугаар тушаалаар холбогдох гэрээний загварыг баталсан.

2.34. Гадаадын их, дээд сургуульд 2017-2024 оны хооронд суралцах гэрээ байгуулсан 495 суралцагчийн сургалтын төлбөр болон амьжиргааны зардлын зээлийн гэрээ, үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээг байгуулахдаа 278 суралцагчийн хувийн хэрэгт Үл хөдлөх хөрөнгийн лавлагааг хавсаргаагүй, 178 суралцагчийн үл хөдлөх хөрөнгийн барьцаалбарын дүн нь сургалтын төлбөрийн зээлийн нийт дүнд хүрээгүй нь тухайн суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд үл хөдлөх хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн зээлийг эргэн төлүүлэхэд эрсдэл үүсгэж болзошгүй байна.

⁷⁰ "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-д 4.4.5.зээлийн барьцааны гэрээ;

⁷¹ "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-д 2.4.Сургалтын зээлийг тухайн их сургуулиас ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалан олгоно.

⁷² "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-д 6.3.Зээлийн барьцааны зүйл нь үл хөдлөх хөрөнгө байна.

⁷³ "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-д 10.10....гадаадын сургалтын байгууллагад суралцагчид олгох зээлд үл хөдлөх эд хөрөнгө барьцаална.

⁷⁴ Гэрээний загварыг шинэчлэн батлах тухай

⁷⁵ Гэрээний загварыг шинэчлэн батлах тухай

⁷⁶ Гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай

Суралцаж төгссөн 313 иргэнээс 91.1 хувь нь зээлээ эргэж төлөөгүй нь сангаас суралцагчдын гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

2.35. 2017–2024 оны хооронд Дэлхийн шилдэг их сургуульд суралцахаар нийт 452 суралцагчид 22,065.7 мянган ам.долларын зээлийн санхүүжилт авснаас суралцаж төгссөн 312 иргэний 20,237.6 мянган ам.доллараас 13 иргэний 309.7 мянган ам.доллар буюу 1.5 хувийн эргэн төлөлттэй байгаа нь зээлийн гэрээнд эргэн төлөлтийн нөхцөл, хуваарь тусгаагүй, сангаас зээлдэгчдэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

2.36. Зээлийн эргэн төлөлтийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь БЗС-ийн хөрөнгийг нөхөн бүрдүүлэх боломжийг хязгаарлаж, тусгай сангийн үйл ажиллагааны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, Улсын төсөвт үзүүлэх санхүүгийн ачаалал нэмэгдэх эрсдэлтэй.

2.37. БЗС-ийн зээлдэгчийн мэдээллийг хууль, тогтоол, гэрээний дагуу бүрэн хөтлөөгүй, эргэн төлөлт маш бага хувьтай байгаа нь тус сангийн хөрөнгийн эргэлтэд эрсдэл үүсгэж байна.

Боловсролын зээлийн сангийн төгсөгчид гэрээний үүргийн биелэлт хангалтгүйгээс тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэх, тандах, мөшгөх судалгаа хийгдэхгүй байна.

2.38. БШУС, Сангийн сайдын хамтарсан 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/169/93 дугаар тушаалын 3 дугаар хавсралт болон 5 дугаар хавсралтын 3.6-т "Их сургуулиа төгсөж эх орондоо ирснээс хойш ажлын 21 хоногийн дотор СТС-д өөрийн биеэр ирж мэдэгдэнэ" гэж заасан ч тус сангийн санхүүжилтээр суралцсан иргэдээс төгсөж ирээд санд бүртгэл хийлгээгүй 237, одоо суралцаж буй 139, бүртгэл хийсэн 119 иргэн байна. Үүнд:

- Төгсөгчдийн статустай уялдсан нэгтгэсэн бүртгэлийн хяналт (хэнийг, хэзээ төгссөн, эх орондоо ирсэн эсэх, ирсэн өдрөөс тоолсон 21 хоног) хэрэгжихгүй байна.
- Гэрээ зөрчигдсөн үед гэрээний дагуу авах арга хэмжээ (сануулах, шаардлага хүргүүлэх, эрх зүйн арга хэмжээ авах) шат дараалалтай хэрэгжүүлээгүй байна.
- Сангаас төгсөгчдийн бүртгэлд тавих хяналт дутмаг, зээлдэгчийн хөдөлмөр эрхлэлт, байршил, эргэн төлөлтийн бүхий л бодлогын гол үзүүлэлтүүдийг найдвартай хэмжих, тайлагнах боломж хязгаарлагдсан.
- Гэрээний заалтыг биелүүлээгүй иргэдэд зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь зохион байгуулаагүйгээс зээлийн эргэн төлөлтийн санхүүгийн сахилга, хөрөнгийн эргэлт сулрах эрсдэлтэй
- Зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл ил тод бус, бүрэн бүртгэлгүй байдал нь суралцагчид зориулсан зээлийн нөхцөл нь нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн үндсэн зарчим алдагдсан байна.

Дотоодын их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлд 90,094.2 сая төгрөгийг олгосон байна

2.39. Дотоодын их, дээд сургуульд 2017-2024 онд Оюутны хөгжлийн зээлээр суралцах гэрээ байгуулсан 47140 суралцагчид 88,094.2 сая.төгрөгийн сургалтын төлбөрийн зээл олгож, 77,712.2 сая төгрөг буюу 88 хувийн эргэн төлөлт хийгдэж, 2025.05.31-ний өдрийн байдлаар 4259 суралцагчийн сургалтын төлбөрийн зээл 10,381.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сан нь 2016-2019 оны хооронд магадлан итгэмжлэгдээгүй 9 байгууллагатай гэрээ байгуулахгүйгээр санхүүжилт олгосон байна.

2.40. Дээд боловсролын тухай хуулийн 8.11⁷⁷, Засгийн газрын 2016 оны 111⁷⁸, 2017 оны 176⁷⁹, 2018 оны 46⁸⁰, 2021 оны 347⁸¹ дугаар журмын хүрээнд 2016-2017 онд Сан, арилжааны банк, ДБСБ-тай хамтран ажиллах гэрээ, харин 2018-2019 онд Сан, ДБСБ-тай хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан. Үүнд:

⁷⁷ Дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын магадлан итгэмжлэл хийх эрх бүхий байгууллагаар байгууллагын магадлан итгэмжлэлийг заавал хийлгэнэ /2023.07.07 хүртэл хүчинтэй/

⁷⁸ Хавсралт 3 "Оюутны хөгжлийн зээлийн журам" 3.2.5. оролцогч банк болон сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулах; /2016.10.05-2017.06.20/

⁷⁹ "Оюутны хөгжлийн зээлийн журам" 3.2.2. оролцогч банк болон сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллах; /2017.06.20-2018.02.06/

⁸⁰ "Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам" /2018.02.06-2021.11.10/

1.1.Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид "Оюутны хөгжлийн зээл" олгох, эргэн төлүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

⁸¹ Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам /2021.11.10-2024.02.28/

- 2016-2017 онд Сан нэр бүхий 6 арилжааны банк, дотоодын дээд боловсролын 74 сургалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулсан ба тухайн гэрээ байгуулах үед 33 сургууль нь магадлан итгэмжлэгдээгүй буюу хугацаа нь дууссан байна.
- Сан 2018-2019 онд дотоодын 72 ДБСБ-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан ба тухайн гэрээ байгуулах үед 40 сургууль нь магадлан итгэмжлэгдээгүй буюу хугацаа нь дууссан байна.
- 2018-2024 оны хооронд дээд боловсролын сургалтын 9⁶² байгууллагатай гэрээ байгуулахгүйгээр санхүүжилт олгосон байна.

Оюутны хөгжлийн зээлийн санхүүжилт олгосон 81 сургууль эрсдэлийн сангийн дансгүй байсан.

2.41. Засгийн газрын 2018 оны 46⁶³ дугаар журмын 4.1.3 зээлийн 5 хувьтай тэнцэх хэмжээгээр "Зээлийн эрсдэлийн сан" бүрдүүлж... гэж, 2021 оны 347⁶⁴ дугаар журмын 6.10... зээлийн 5 хувийг... эрсдэлийн сангийн дансанд байршуулна гэж тусгасныг үндэслэн тус Сан нь 2024 он хүртэл нийт 85 их, дээд сургуулиар дамжуулан "Оюутны хөгжлийн зээл"-ийг олгож ирсэн. Тухайлбал:

- Оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламж/тэтгэлэг/-ийн санхүүжилт авч байсан 85 сургуулиас БХИС, ДХИС, Монгол-Герман ХАМИС, Монгол Улсын консерватор зэрэг сургуулиуд эрсдэлийн сангийн данстай, үлдсэн 81 сургууль нь эрсдэлийн сангийн дансыг үүсгээгүй байна.
- Харин Сан ДБСБ-тай жил бүр олгосон санхүүжилтийн тооцоог Оюутны хөгжлийн зээл, Эрсдэлийн сан, Буцалтгүй тусламж гэсэн төрлөөр "тооцоо нийлсэн акт"-ыг баталгаажуулж байсан.
- 2024 оны "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 12.4-т "Суралцагч ...санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдэлийн даатгалаар даатгуулсан байна" гэж зохицуулсан байна.

БЗС нь зарим арилжааны банктай байгуулсан "Зээлийн гэрээ"-ний үүргийн хэрэгжилтийг бүрэн дүгнээгүй, холбогдох хууль, эрх зүйн акт хүчингүй болсон байхад гэрээ үргэлжилсээр байна.

2.42. Оюутны хөгжлийн зээлийн журамд ...Боловсролын зээлийн сан, арилжааны банк, их, дээд сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулах, ...БЗС-аас жилийн хоёр хувийн хүүтэй зээлийг банканд олгох, ...банкнаас оюутанд жилийн 5 хувийн хүүтэй зээл олгох... гэж тус тус заасны дагуу 2017-2018 онд Оюутны хөгжлийн зээлийг хүүтэй олгож байжээ. Тухайлбал:

- БЗС, арилжааны банк хоорондын 2016.11.30-нд байгуулсан "Зээлийн гэрээ", 2017.08.16-нд нэмэлт өөрчлөлт оруулсан гэрээний дагуу тус сангаас арилжааны банканд 2 хувийн хүүтэйгээр хүү бууруулах, богино хугацаатай, урт хугацаатай гэсэн нөхцөлтэйгөөр нийт 11,000.0 сая төгрөгийн хөрөнгийг банканд эх үүсвэр болгон шилжүүлж, арилжааны банкнаас "энгийн вексель" бичиж баталгаажуулсан байна.
- БЗС-аас арилжааны банктай гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөж байсан ЗГТСТ хууль /2020.01.01-ний өдрөөс хүчингүй/, ДБССНБТ хууль /2023.07.07-ны өдрөөс хүчингүй/, Оюутны хөгжлийн зээлийн журам /2017.06.20-ны өдрөөс хүчингүй/ нь тус тус хүчингүй болсон байхад зээлийн гэрээний үйлчлэл нь хүчинтэй хэвээр байгаа нь эрх зүйн чадамжгүй акт байна.
- Харин Зээлийн гэрээний 9.1-т ...гэрээнд заасан талуудын эрх, үүрэг бүрэн биелэгдсэнээр уг гэрээ дуусгавар болно гэж, 7.3-т ...Сан энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж... гэж заасан байхад Сангаас эрх зүйн актанд нийцүүлэн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, гэрээний үүргийг дуусгавар болгох зохицуулалтыг хийгээгүйгээс 2025.06.30-ны өдрийн байдлаар Арилжааны банканд олгосон зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл дүн 35.8 сая төгрөг байна.

⁶² Г.В.Плехановын нэрэмжит ОЭЗИС, ДХИС, ДУАДС, Маргадтамир, МУБИС, Рояль-Академи, Хөдөлмөрийн ДС, ХҮДС ирээдүй, ХМХОУДС

⁶³ Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам

⁶⁴ Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам

Хүснэгт 7 Арилжааны банканд олгосон зээлийн эх үүсвэр, үлдэгдэл /сая.төгрөгөөр/

Арилжааны банкны нэр	Олгосон зээлийн нөхцөл			Нэмэлт эх үүсвэр	Нийт дүн	Зээлийн үлдэгдэл /2025.06.30/	
	Хүү бууруулах	Богино хугацаатай	Урт хугацаатай			Нийт төлбөр	Үлдэгдэл дүн
Голомт банк	200.0	500.0	300.0	500.0	1,500.0	1,498.1	1.9
Капитрон банк	200.0	500.0	300.0		1,000.0	996.9	3.1
Хаан банк	500.0	1,000.0	500.0	2,500.0	4,500.0	4,482.5	17.5
Хас банк	200.0	500.0	300.0		1,000.0	999.0	1.0
Төрийн банк	500.0	1,000.0	500.0		2,000.0	1,987.8	12.2
Улаанбаатар хотын банк /ХХБ/	200.0	500.0	300.0		1,000.0	1000.0	-
Нийт дүн	1,800.0	4,000.0	2,200.0	3,000.0	11,000.0	10,964.2	35.8

Эх сурвалж: Арилжааны банкнуудын албан бичиг

2.43. Эрх зүйн зохицуулалт хүчингүй болсон байхад арилжааны банкнуудтай байгуулсан гэрээний үйлчлэл нь хэвээр байгааг цаашид хууль, эрх зүйн орчинд нийцүүлэх, гэрээний үүргийг дуусгавар болгох, банкнуудад олгосон зээлийн эх үүсвэрийн үлдэгдлийг Улсын төсөвт төвлөрүүлэх шаардлагатай байна.

Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлгээр 2022-2024 оны хооронд 738 суралцагчид нийт 45,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна

2.44. ЗГ-ын 2022 оны 347, 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан журмыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийг гадаадын 20 улсад 759 суралцагчийг бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах шийдвэрийг 2022-2024 оны хооронд салбарын сайдын 3 тушаалаар 738 суралцагчид нийт 45,000.0 сая төгрөгийг Улсын төсвөөс /23,180.8 сая төгрөгийн сургалтын төлбөр, 11,888.5 сая төгрөгийн дотуур байр, 9,822.9 сая төгрөгийн амьжиргааны зардал/-д зарцуулсан байна.

2.45. Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ын 2.1.1 дэх заалтын дагуу 4 улсад 150 суралцагч, мөн 2.1.2-т заасан 15 улсад 584 суралцагч хамрагдсан ба дараах сургуультай хамтын ажиллагааны гэрээгүй байхад 4 суралцагчийг суралцуулж байна. Тухайлбал:

- Тайвань улсад 3 суралцагч "Tamkang их сургууль"-ийн бакалаврын үндсэн ангид хамрагдсан боловч журамд заасан шаардлагад нийцээгүй /Хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр огт байхгүй;
- Мөн хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээргүй сургууль буюу "Kookmin University"-д нэг суралцагч хамрагдсан нь Дэлхийн шилдэг их сургуулиудын эхний 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцуулах тэтгэлэгт хамрагдах гэсэн шалгуурыг хангаагүй байна

Засгийн газрын тэтгэлгээр нийт 77 суралцагчид 3,267.2 мянган ам.долларын сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон байна

Салбарын сайд 2024 оны сонгон шалгаруулалтад тэнцээгүй нэг иргэнийг тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцуулах шийдвэрийг гаргасан байна.

2.46. БШУС-ын 2022.07.05-ны өдрийн А/243 дугаар тушаалаар сонгон шалгаруулалтад тэнцээгүй 1 иргэнийг Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилээс дэлхийн шилдэг их, дээд сургуулийн магистрантурт суралцуулах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- БШУС-ын 2022 оны А/91 дүгээр тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын ажлын хэсэг нь МУЕС-ын нэрэмжит тэтгэлгээр "Гадаадын их, дээд сургуульд магистр, докторын хөтөлбөрт суралцах" хүсэлт ирүүлсэн 73 иргэний баримт бичгийн бүрдүүлэлтмйн үнэлгээгээр Б.Э нь 10 онооноос 2 оноо⁸⁵ авч тэнцээгүй, дараагийн ярилцлагын шатны сонгон шалгаруулалтад оролцсон 32 иргэний нэгтгэл жагсаалтад нэр нь тусгагдаагүй, гэтэл дээрх

⁸⁵ TOP-100 сургууль 0-5 оноо авахаас 2 оноо авсан, Гадаад хэлний оноо 0-5 оноо авахаар 0 оноо авсан, нийт 2 оноо авч тэнцээгүй.

иргэний ярилцлагын шатны сонгон шалгаруулалтын үнэлгээний /нийт 1-10 оноо авахаас 5 оноо⁸⁶/ хуудсыг тусад нь гаргаж, нийт 7 оноотой тэнцээгүй байна.

Засгийн газраас ЗГТСТ хуулинд "...Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох" гэж заасантай нийцээгүй суралцуулах шийдвэрийг гаргасан байна.

2.47. ЗГТСТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.3⁸⁷-т "...Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох...", 8.4-т "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална" гэсэн заалт, "Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"⁸⁸-ын 4.1.1-д "...дотоодын сургалтын байгууллагад суралцах 50 хүртэлх суралцагч тус бүрд 10,000,000.0 (арван сая) хүртэл төгрөгийн тэтгэлэг" гэж заасныг тус тус зөрчиж Засгийн газрын 2023.06.07-ны өдрийн 226 дугаар тогтоолоор ... 2023 онд 100 хүртэлх суралцагчдад олгох ... гэж тогтоож, мөн Монгол Улсын Ерөнхий сайд, БШУС-аас дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- БШУС-ын 2023 оны А/17, А/86 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2023.05.10-ны өдрийн №АХ2023-А/86-1 дугаар, 2023.05.12-ны өдрийн №АХ2023-А/86-2 дугаар тэмдэглэлд ...дотоодын их, дээд сургуулийн шилдэг суралцагчийн тэтгэлэгт бүртгүүлсэн 334 суралцагчаас⁸⁹ "Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ын 2.1.2⁹⁰-т заасан шаардлагыг 59 суралцагч хангаагүй⁹¹, 2023.05.15-ны өдрийн №АХ2023-А/86-3 дугаар хурлын тэмдэглэлд ...ярилцлагын шатны сонгон шалгаруулалтад 113 суралцагч⁹² шаардлага хангаагүй... гэж тэмдэглэж, сонгон шалгаруулалтын II шатны үнэлгээнд тэнцсэн 222 суралцагчийн жагсаалтыг гаргаж, 2023.05.23-25-ны өдрүүдэд ярилцлагын шатны жагсаалт дахь 75-84 суралцагчийн үнэлгээг гишүүн тус бүр гарын үсэг зурж баталгаажуулсан ч нэгдсэн жагсаалт байхгүй байна. /нотлох баримтгүй/,
- Засгийн газрын 2023.06.07-ны өдрийн 226 дугаар тогтоолоор ... сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн 2023 онд 100 хүртэлх суралцагчдад олгохоор тогтоосугай... гэж шийдвэрлэсэн,
- БШУС-ын 2023.06.08-ны өдрийн 1а/2593 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т ...дотоодын их, дээд сургуулийн шилдэг суралцагчийн тэтгэлэгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 100 оюутны жагсаалтыг хүргүүлсэн,
- МҮЕС-ын 2023.06.09-ний өдрийн 107 дугаар захирамжаар ...Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн дотоодын их, дээд сургуулийн шилдэг 100 оюутны жагсаалтыг... баталсан,
- БШУС-ын 2023.06.09-ний өдрийн А/250 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэгийн 2023 онд ...дотоодын их, дээд сургуулийн шилдэг сурагчийн тэтгэлэгийн хяналтын тоо 94... гэж баталсан,
- БШУС-ын 2023.06.19-ний өдрийн А/261 дүгээр тушаалын 1-т "Монгол Улсын Ерөнхий Сайдын нэрэмжит хөтөлбөрийн хүрээнд ...нэр бүхий 100 шилдэг суралцагч тус бүрд 10.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор тогтоосугай... гэж тус тус шийдвэрлэсэн нь "Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ын 4.1.1-д "... дотоодын сургалтын байгууллагад суралцах 50 хүртэлх суралцагч ...тэтгэлэг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Монгол Улсын Засгийн газар буюу Ерөнхий Сайдын нэрэмжит тэтгэлгээр суралцаж буй 22 суралцагч нь журмын шалгуур хангаагүй байна.

2.48. Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийн дагуу 2021-2024 онд 3 тушаалаар нийт 77 суралцагчийг гадаадын их, дээд сургуульд "магистр, доктор"-т суралцуулах шийдвэр гаргасан ч Дэлхийн шилдэг сургууль, гадаад хэлний шаардлага хангаагүй, 2 дах удаагаа суралцаж буй, тэргүүлэх болон эрэлттэй чиглэлийн жагсаалтад ороогүй мэргэжлийг

⁸⁶ Судалгааны аргачлал 1 оноо, мэргэшсэн байдал туршлагад 1 оноо, судалгааны бүтээл туурвисан эсэх 1 оноо, өөрийгөө илэрхийлэх үр чадвар 1 оноо, төгсөөд ажиллах төлөвлөгөө 1 оноо, нийт 5 оноо

⁸⁷ 8.3.Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна

⁸⁸ Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан

⁸⁹ Ажлын хэсгийн 2023.05.10-ны өдрийн №АХ2023-А/86-1 дугаар хурлын тэмдэглэлийн ...Тэтгэлгийн бүртгэлийн дүн ... нийт 356 суралцагч бүртгэгдсэнээс дотоодын их, дээд сургуулийн шилдэг суралцагчийн тэтгэлэгт 334,... гэж тэмдэглэсэн байна.

⁹⁰ 2.1.2.бакалаврын хөтөлбөрөөр суралцагч сүүлийн 3 улирал дараалан 3.4 болон түүнээс дээш голч оноотой үнэлэгдсэн байх;

⁹¹ Ажлын хэсгийн 2023.05.12-ны өдрийн №АХ2023-А/86-2 дугаар хурлын тэмдэглэлд ...Тэтгэлгийн техникийн шатны шалгалтын үр дүн ... 65 оюутан шаардлага хангаагүй гэж тэмдэглэсэн, мөн Ажлын хэсгийн 2023.05.12-ны өдрийн №АХ2023-А/86-2 дугаар хурлын тэмдэглэлд ... өмнөх хуралдаанд танилцуулсан 64 оюутнаас 5 оюутан хасагдахгүй болсон... гэж дурдсан байна.

⁹² Ажлын хэсгийн 2023.05.15-ны өдрийн №АХ2023-А/86-3 дугаар хурлын тэмдэглэлд ... эсээний танилцуулга ярилцлагын шатны зохион байгуулалтаар ...дотоодын их, дээд сургуулийн шилдэг суралцагчийн тэтгэлэгийн шаардлагыг хангаагүй 113,... гэж тэмдэглэсэн байна.

сонгосон зэрэг нийт 22 суралцагчид /санхүүжилтийн дүн 675,461.11 ам.доллар/ зөрчил илэрлээ. Тухайлбал:

- 2022 онд дэлхийн шилдэг сургууль, гадаад хэлний шаардлага хангаагүй 9 суралцагч, хоёрдох удаагаа суралцаж буй 3 суралцагч, 2023 онд дэлхийн шилдэг сургууль, гадаад хэлний шаардлага хангаагүй 4 суралцагч, 2024 онд тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн жагсаалтад ороогүй мэргэжлээр 7 суралцагч суралцаж байгаа нь "Монгол улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам"-ын 2.3.1, 2.3.2, 6.2 "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 4.1, 4.12.2, 4.12.3, 4.12.4-т тус тус заасан шалгуурыг хангаагүй байна

Дүрслэл 10 Суралцсан суралцагчийн тоо, санхүүжилт



Эх сурвалж: Аудитын баг.

Хоёр улсын Засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу амьжиргааны зардлын тэтгэлэгт нийт 390 суралцагч 7 улсад суралцсан байна

Монголын талын ажлын хэсгийн сонгон шалгаруулалтын үнэлгээ хийгдээгүй байхад жагсаалтад оруулсан байна.

2.49. БШУС-ын 2022.07.26-ны өдрийн А/264 дугаар тушаалаар Хоёр орны Засгийн газар хоорондын тэтгэлгээр 2022-2023 оны хичээлийн жилд БНАЛАУ, БНКУ-д "бакалавр, магистр, докторын сургалтад суралцах иргэд"-ийг сонгон шалгаруулах "Монголын талын ажлын хэсгийн удирдамж"-ийн дагуу БНКУ-ын ЭСЯ-нд суралцагчдын баримт бичгийн бүрдүүлбэр, чанарын үнэлгээ хийсэн жагсаалтыг хүргүүлсэн ч "Монголын талын ажлын хэсэг"-ийн сонгон шалгаруулалтад 3 иргэн хамрагдаагүй, сонгон шалгаруулалтын үнэлгээнд ажлын хэсгийн зарим гишүүд оролцсон эсэх нь тодорхойгүй, ажлын хэсэг нэгдсэн үнэлгээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй зэрэг алдаа зөрчлүүд гарсан байна. Тухайлбал:

- БШУЯ-ны 2022.08.26-ны өдрийн 9/4049 дугаар "БНКУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам"-нд хүргүүлсэн албан бичигт "...2022-2023 оны хичээлийн жилээс суралцах хүсэлтээ танай Элчин сайдын яаманд хандсан МУ-ын иргэдийн мэдээллийг нэгтгэн ...шинэчлэн хүргүүлж байна..." гэж дурдсан,
- Гэтэл БНКУ-ын ЭСЯ-нд хүргүүлсэн 9 иргэний жагсаалтад ...Монголын талын сонгон шалгаруулалтад тэнцсэн 3 иргэний нэрийг хасаж, Монголын талын сонгон шалгаруулалтаар баримт бичгийн бүрдүүлбэр, чанарын үнэлгээ хийгдээгүй ч тус ЭСЯ-нд хандсан гэх 3 иргэний нэрийг тусгаж хүргүүлсэн байна.
- БНАЛАУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцах сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан Монголын талын ажлын хэсгийн 7 гишүүнээс 3 гишүүн үнэлгээ /9 иргэнийг шалгаруулсан үнэлгээний хуудаст/ өгч, 4 гишүүн үнэлгээ өгсөн эсэх нь тодорхойгүй /нотлох баримтгүй/, нийт гишүүдийн 57.2 хувь нь оролцоогүй, нэгдсэн үнэлгээнд гишүүд гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

2024 оны "БНПУ-ын Засгийн газрын тэтгэлэгт магистрын хөтөлбөрт суралцах" сонгон шалгаруулалтад тэнцээгүй 1 иргэнийг салбарын сайдын тушаалаар суралцуулахаар шийдвэрлэсэн байна.

2.50. Мөн БШУС-ын 2024.03.11-ний өдрийн А/124 дугаар тушаалаар ..."БНПУ-ын Засгийн газар хоорондын тэтгэлгээр 2024-2025 оны хичээлийн жилд бакалавр, магистр, докторын сургалтад суралцах иргэд"-ийг сонгон шалгаруулах Монголын талын комисс болон БНПУ-ын Үндэсний боловсролын солилцооны агентлаг /NAWA/-аас тус бүрийн ирүүлсэн сонгон шалгаруулалтаар тэнцсэн иргэдийн жагсаалтад байхгүй иргэнийг Боловсролын сайдын 2024.09.30-ны өдрийн А/110 дугаар "Амьжиргааны зардал олгох тухай" тушаалд нэрийг нь оруулж баталсан байна. Үүнд:

- БНПУ-ын ЭСЯ-аас 2024.05.27-ны өдрийн албан бичгээр БШУЯ-д ...ярилцлагын шатны сонгон шалгаруулалтад тэнцсэн⁹³ нэр дэвшигч 22 иргэн, нөөцөд 7 нэр дэвшигчийн жагсаалтыг хүргүүлсэн ч уг жагсаалтад "Ч.Н" гэсэн нэр байхгүй,
- БШУЯ-ны 2024.06.27-ны өдрийн 8/2859 дугаар БНПУ-ын Үндэсний боловсролын солилцооны агентлагт хүргүүлсэн ...тэтгэлэгт хамрагдагч Монгол Улсын 22 нэр дэвшигчийн жагсаалтад "Ч.Н" гэсэн нэр байхгүй,
- БНПУ-ын Үндэсний боловсролын солилцооны агентлаг /NAWA/-ийн 2024.10.18-ны өдрийн албан бичигт ...БНПУ-ын БШУС, Монгол Улсын БШУЯ хооронд дээд боловсролын салбарт хамтран ажиллах Монгол Улсын нэр дэвшигчид элссэн нийт 22 иргэн⁹⁴ жагсаалтад "Ч.Н" гэсэн нэр байхгүй байна.
- Боловсролын сайдын 2024.09.30-ны өдрийн А/110 дугаар тушаалаар баталсан Амьжиргааны зардал олгох иргэдийн нэрсийн жагсаалтын 22-д "Ч.Н", Боловсрол судлал" мэргэжлээр 2 жил магистр ... гэж баталсан байна.
- Харин БШУС-ын 2023.12.25-ны өдрийн А/570 дугаар тушаалаар⁹⁵ баталсан "Монгол Улс, БНПУ-ын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд бакалавр, магистрын сургалтад хамрагдах иргэдийн нэрсийн жагсаалт"-ын 18-д Ч.Н нь суралцах чиглэл "боловсрол", суралцах хугацаа "3 жил", эрдмийн зэрэг "судлаач солилцоо"... гэж баталсан байна.
- Гэтэл салбарын сайд нь "Ч.Н" суралцагчтай холбоотой өөрчлөлтийн шийдвэрийг гаргаагүй, 2023, 2024 он тус бүрд шинээр суралцуулах шийдвэр гаргасан нь БНПУ-д суралцаж буй суралцагчийн тоо бодитой бус, тухайн суралцагч амьжиргааны зардал нэмж авах эрсдэлийг үүсгэсэн байна.

БНПУ-д суралцаж буй 8 суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг, Засгийн газар хоорондын тэтгэлгийг давхардуулан олгосон байна.

2.51. Хоёр Улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд 2017-2024 оны хооронд 27 тушаалаар АНУ, ИБУИНВУ, БНФУ, БНПУ, ОХУ, БНКУ, Украин зэрэг улсуудад сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын тэтгэлгээр нийт 390 иргэнийг хэлний бэлтгэл, бакалавр, магистр, докторын зэргээр суралцуулах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

Дүрслэл 11 Засгийн газар хоорондын гэрээгээр тэтгэлэгт хамрагдаж буй суралцагчид /суралцсан улсаар/



Эх сурвалж: Аудитын баг

2.52. БНПУ-д суралцаж буй 8 суралцагч нь 2022-2024 оны хооронд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр сургалтын төлбөр, дотуур байрны төлбөр, амьжиргааны зардалд 182.2 сая.төгрөг, Засгийн газар хоорондын тэтгэлгээр амьжиргааны зардалд 129.3 сая.төгрөгийг тус тус давхардуулж олгосон байна.

⁹³ нэр дэвшигч нартай ярилцлагын шатны сонгон шалгаруулалтыг биечлэн хариуцан зохион байгуулсан.

⁹⁴ /овог нэр, хүлээн авагч байгууллага, бэлтгэл курс, Польш улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр/

⁹⁵ Амьжиргааны зардал батлах тухай

БЗС болон суралцагчтай байгуулсан гэрээ, хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байна

БЗС дахь архивын баримтад давхардсан тоогоор 1857 суралцагчийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, 9 сургуульд хамтран ажиллах гэрээгүйгээр санхүүжилт олгосон байна.

2.53. БСШУ-ны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 70/369, БШУ-ны сайд, Сангийн сайдын хамтарсан 2014 оны А/169/93, БСШУ-ны сайдын 2018 оны А/179, БШУ-ны сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны А/544/256, БШУ-ны сайдын 2023 оны А/179 дугаар тушаалаар Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцагчдад сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээл, тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцуулах тухай гэрээний үлгэрчилсэн загварыг тус тус баталсан.

2.54. БЗС дахь архивын баримтад давхардсан тоогоор 1857 суралцагчийн хувийн хэргийн бүрдлээс гэрээний загвар өөрчилсөн 794, амьжиргааны тэтгэлгийн гэрээ байгуулаагүй 516, холбогдох тогтоолын заалтыг үндэслэн гэрээний загварт өөрчлөлт оруулаагүй 332, хүчин төгөлдөр бус загвараар гэрээ байгуулсан 183, гэрээ байхгүй 28, баталгаажуулаагүй 4 гэрээ байна.

2.55. БЗС-ийн архивын баримт дах суралцагчийн хувийн хэрэгт суралцуулах гэрээ байхгүй, байгуулсан гэрээ баталгаажаагүй, тушаалаар баталсан гэрээний загварыг өөрчилсөн, хүчин төгөлдөр бус загвараар гэрээ байгуулсан, Засгийн газрын тогтоолыг үндэслэн гэрээний загварт өөрчлөлт оруулаагүй, суралцагчтай батлагдсан загвараар гэрээг байгуулаагүй байна. Тухайлбал:

- 3Г-ын 2016 оны 111 дүгээр тогтоолын 1-д "Сургалтын төрийн санг "Боловсролын зээлийн сан" болгон өөрчлөн зохион байгуулж ..." гэсэн байхад 2014 онд батлагдсан гэрээний загварт өөрчлөлт оруулалгүй 332 суралцагчтай "Сургалтын төрийн сан" гэж зээлийн гэрээ байгуулсан, 9 суралцагчийн гэрээ байхгүй.
- Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдсан суралцагчтай байгуулсан гэрээний санхүүжилтийн дүнтэй хуудаст 2024 онд БЗС-ийн ажлын албаны даргын "БАТЛАВ" гэсэн тэмдэглэгээг дарсан нэмэлт хуудас хавсаргасан.
- 2022-2023 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр суралцсан 516 суралцагчтай "Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгийн амьжиргааны тэтгэлэг олгох гэрээ"-г байгуулаагүй.
- 2022-2023 онд Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хамрагдсан 56 суралцагчтай батлагдсан гэрээний загварыг өөрчлөн "хоёр талт" гэрээ/тухайн орон нутгийн ЗД-ыг хассан/ байгуулсан, 4 суралцагчийн хувийн хэрэгт гэрээ байхгүй.
- Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр АНУ, ИБУИНВУ, БНФУ, БНПУ, ОХУ, БНКУ, Украин улсад суралцсан 202 суралцагчтай байгуулсан гэрээтэй холбоотой дараах зөрчил:
 - 183 суралцагчтай хүчингүй гэрээний загвараар гэрээ байгуулсан.
 - 15 суралцагчийн хувийн хэрэгт гэрээ байхгүй
 - 4 суралцагчийн гэрээг баталгаажуулаагүй /БЗС-ийн даргын гарын үсэг, тамгагүй/

Салбарын сайд 2017-2024 оны хооронд 487 суралцагчийн 16.1 сая ам.долларын чөлөөлөлт хийснээс 381 суралцагчийн 11.2 сая ам.долларын чөлөөлөлт шаардлага хангаагүй байна

2020 онд Улсын Их Хурлаас холбогдох хуульд заасан журмыг батлаагүй буцаасан, Засгийн газраас дахин өргөн мэдүүлээгүй байна.

2.56. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн⁹⁶ /2011.07.09-ний өдрөөс 2023.07.07-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр/ 8 дугаар зүйлийн 8.8-т "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн Улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно" гэж заасан ч хууль хэрэглээний явцад Засгийн газраас 2020 онд өргөн мэдүүлсэн журмын төслийг УИХ-аас батлаагүй буцааж, Засгийн газраас дахин өргөн мэдүүлээгүй байна.

- БСШУ-ны сайдын 2020.02.04-ний өдрийн 1а/686 дугаар албан бичгээр "Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх

⁹⁶ 2011.07.09-ний өдөр батлагдаж, 2023.07.07-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан

нөхцөлтэй зээлийн Улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, журмын төсөл, танилцуулга, тандан судалсан тайлан, тогтоолын төслийн үр нөлөө үнэлэх судалгааны тайлан, тогтоолын төслийн зардлын тооцоо зэргийг Засгийн газарт⁹⁷ хүргүүлж,

- Засгийн газраас 2020.03.05-ны өдрийн 3Г-1/22 дугаар албан бичгээр УИХ-д “Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн Улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл, журмын төслийн хамт өргөн мэдүүлсэн,
- УИХ-ын 2020.10.08-ны өдрийн 28 дугаар тогтоолоор ...УИХ-ын бусад шийдвэрийн төслийн хууль санаалагч нь өөрчлөгдсөн, зарим төслийн талаар шинээр байгуулагдсан Засгийн газрын саналыг авах шаардлагатай гэж үзэн шийдвэрийн төслүүдийг хууль санаачлагчид буцаасан байна.
- БЗС-аас 2023.05.05-ны өдрийн 523 дугаар албан бичгээр БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын удирдлага зохицуулалтын газарт ... Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-т заасан журмын төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус хүргүүлсэн ч БШУЯ-аас Засгийн газарт дээрх хуульд заасан журмын төсөл, УИХ-ын тогтоолын төслийг хүргүүлээгүй байна.

2.57. Гэтэл Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн /хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/ 8 дугаар зүйлийн 8.8-т заасан журам батлагдаагүй байхад Засгийн газрын 2013.04.27-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлээр ... БШУС⁹⁸-д сургалтын төлбөрөөс чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх ... гэсэн чиглэл өгч, салбарын сайдаас 2017-2023 оны хооронд СТС, БЗС-аар дамжуулан Улсын төсвийн хөрөнгөөр 1997-2021 оны хооронд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж төгссөн нийт 390 иргэний 11,420.6 мянган.ам долларын сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлсөн нь хуулиар олгогдоогүй эрх, мэдлийг хэтрүүлэн хэрэглэсэн байна.

2.58. Улсын Их Хурлаас холбогдох хуульд заасан журмыг батлаагүй буцаасан ч Засгийн газраас дахин өргөн мэдүүлээгүй, харин одоогийн мөрдөж буй Боловсролын Ерөнхий хуулиар Засгийн газар холбогдох журмыг батлахаар хуульчилсан байна.

Гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн 390 суралцагчийн 11,420.6 мянган.ам долларын сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлсөн шийдвэр нь хуульд нийцэхгүй байна.

2.59. БШУСС-ын 2017 оны А/88, 2018 оны А/555, 2019 оны А/658, 2020 оны А/97, А/195, БШУС-ын 2021 оны А/312, БШУС-ын 2022 оны А/83, А/200, 2023 оны А/31, А/139 дүгээр тушаалаар Гадаадын их, дээд сургуульд 1997-2021 онуудад суралцаж төгссөн 487 иргэний /317 суралцагч сан, захиалагч, суралцагч 3 талт, 73 суралцагч сан суралцагч 2 талт гэрээ байгуулсан/ сургалтын төлбөр, амьжиргааны зардалд олгосон 16,090.1 мянган ам.долларын сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлсөн нь эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан байна.

2.60. Зээл чөлөөлсөн үндэслэлийг ...Монгол Улсад 5-аас доошгүй жил ажиллаж НДШ төлсөн гэх 390 иргэн, нас барсан 3 иргэн⁹⁹, хөдөлмөрийн чадвар алдсан 7 иргэн¹⁰⁰, тэтгэлгээр суралцсан 81 иргэн¹⁰¹ гэрээний үүргээ биелүүлсэн... гэж үзэж сургалтын төлбөрийн зээл, үл хөрөнгийн барьцааг чөлөөлөх шийдвэрийг тус тус гаргасан байна. Үүнд:

⁹⁷ Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргат хүргүүлсэн

⁹⁸ БШУС 2016 он

⁹⁹ Засгийн газрын 2000 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”-ын 6.36 Суралцагч нас барсан... /нийт 3 иргэний 279.2 мянган.ам.доллар/

¹⁰⁰ Засгийн газрын 2000 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам”-ын 6.36 ... хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу 70-аас дээш хувиар алдсан нөхцөлд түүнийг зээл болон хүүгийн төлбөрөөс чөлөөлнө. /нийт 7 иргэний 218.3 мянган.ам.доллар/

¹⁰¹ Фулбрайт тэтгэлэгт хөтөлбөрийн 79 иргэн, Инженер, технологийн дээд боловсролын коосен хөтөлбөрт 2 иргэн, нийт 81 иргэний үл хөдлөх хөрөнгө чөлөөлсөн / Фулбрайт 79 суралцагчийн 4,044.4 мянган.ам долларын тэтгэлэг, /

Хүснэгт 8 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлсөн шийдвэрийн судалгаа

№	Чөлөөлөлтөд хамрагдсан			Чөлөөлөлтийн үндэслэл			
	Огноо, дугаар	суралцагч тоо	Сургалтын зээл тэтгэлгийн дүн /ам.доллар/	МУ-д 5-аас доошгүй жил ажилласан	Нас барсан	Хөдөлмөр ийн чадвар алдсан	Үл хөдлөх хөрөнгө барьцаа ¹⁰²
1	2017.07.27-ны А/88	51	1,367,530.0	50	0	1	
2	2018.08.31-ний А/555	74	1,853,847.0	70	1	3	
3	2019.10.18-ны А/658	71	2,241,709.7	67	2	2	
4	2020.02.21-ний А/97	13	408,000.0	13			
5	2020.12.21-ний А/195	26	540,843.0	23			
6	2021.09.03-ны А/312	39	1,126,592.4	39			
7	2022.03.14-ний А/83	40	1,094,537.6	38		1	
8	2022.06.06-ны А/200	10	323,271.4	9			
9	2023.02.01-ний А/31	71	2,324,985.8	69			2
10	2023.04.03-ны А/139	92	4,808,734.8	12			80
	Нийт дүн	487	16,090,051.7	390	3	7	82

Эх сурвалж: БСШУСС-ын 2017 оны А/88, 2018 оны А/555, 2019 оны А/658, 2020 оны А/97, А/195, БСШУС-ын 2021 оны А/312, БШУС-ын 2022 оны А/83, А/200, 2023 оны А/31, А/139 дүгээр тушаал

2.61. Харин аудитын явцад БЗС-аас 2000-2018 оны хооронд гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн 5 суралцагчийн /нийт 87.5 мянган.ам.долларын сургалтын төлбөрийн зээл авсан/ баримт материалыг ирүүлээгүй, БСШУС-ын 2020 оны А/195, 2023 оны А/31 дүгээр тушаалаар дээрх суралцагчдын гэрээний үүргийг дуусгавар болгож, сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлөх шийдвэр гаргасан нь нотлох баримтгүй байна. Үүнд:

Хүснэгт 9 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөгдсөн шийдвэрт багтсан ч нотлох баримтгүй иргэдийн нэгтгэл

№	Салбарын сайдын шийдвэр /суралцуулах/	Сургалтын төлбөрийг Чөлөөлсөн шийдвэр	Сургалтын төлбөр, зээлийн дүн (ам.доллар)
1	2000.08.31 №14	2020.12.21-ний А/195	11,550.0
2	2008.03.03 №38, 2008.07.31 №182	2020.12.21-ний А/195	21,020.0
3	2013.02.22 №А/57	2020.12.21-ний А/195	3,992.0
4	2002.11.28 №345	2023.02.01-ний А/31	32,000.0
5	2003.07.08 №235	2023.02.01-ний А/31	18,904.8
	Нийт		87,466.8

Эх сурвалж: БСШУСС-ын 2020 оны А/195, БШУС-ын 2023 оны А/31 дүгээр тушаал

2.62. Салбарын сайдаас 2017-2023 оны хооронд гэрээний үүргийг дуусгавар болгосон тушаалд орсон 390 иргэний 11,420.6 мянган.ам долларын сургалтын төлбөрийн зээлийн хууль бус чөлөөлөлтийн шалтгаан ...Монгол Улсад 5-аас доошгүй жил ажиллаж, НДШ төлсөн байх 390 иргэнээс 296 иргэн буюу 75.9 хувь нь НДШ төлж, 94 иргэн буюу 24.1 хувь нь НДШ төлөлт 5 жил хүрээгүй /үүнээс 42 иргэн НДШ төлөөгүй/, 3 талт гэрээгээр төгсөж ирээд захиалагч байгууллагад ажиллах нөхцөлийг 214 иргэн буюу 67.5 хувь нь хангаагүй... байхад гэрээний үүргээ биелүүлсэн гэж үзэн сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

Хүснэгт 10 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөгдсөн иргэдийн холбогдох нөхцөлийг хангасан эсэх судалгааны нэгтгэл

№	Салбарын сайдын шийдвэрийн огноо, дугаар	Монгол Улсад 5-аас доошгүй жил ажиллаж, НДШ төлсөн байх	үүнээс			Захиалагч байгууллагад ажиллах нөхцөл	
			НДШ-ийг 5 жил төлсөн	НДШ төлөлт 5 жил хүрээгүй	НДШ төлөөгүй	хангах	хангаагүй
1	2017.07.27-ны А/88	50	23	10	17	50	37
2	2018.08.31-ний А/555	70	46	11	13	70	47
3	2019.10.18-ны А/658	67	53	10	4	62	44
4	2020.02.21-ний А/97	13	9	1	3	11	6
5	2020.12.21-ний А/195	23	22	1	0	18	6
6	2021.09.03-ны А/312	39	33	4	2	35	25
7	2022.03.14-ний А/83	38	38	0	1	24	12
8	2022.06.06-ны А/200	9	8	0	2	3	1
9	2023.02.01-ний А/31	69	56	11	0	40	34
10	2023.04.03-ны А/139	12	8	4	0	4	2
	Нийт дүн	390	296	52	42	317	214
	нийт дүнд эзлэх хувь		75.9		24.1		67.5

¹⁰² Тэтгэлгээр суралцсан

Эх сурвалж: БСШУСС-ын 2017 оны А/88, 2018 оны А/555, 2019 оны А/658, 2020 оны А/97, А/195, БСШУС-ын 2021 оны А/312, БШУС-ын 2022 оны А/83, А/200, 2023 оны А/31, А/139 дүгээр тушаал

2.63. Дээрх байдлаас харахад тухайн суралцагчтай гэрээ байгуулах үед мөрдөж байсан Засгийн газрын 1997 оны 179, 2000 оны 96, 2008 оны 177, 2013 оны 271, 2016 оны 111, 2021 оны 347 дугаар тушаалаар баталсан дараах журамд **“сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөх нөхцөл”**-ийг тодорхой тусгасан ч дараах шалгуур, шаардлагыг баримтлаагүй, чөлөөлөх шийдвэрийг гаргаж иржээ. Тухайлбал:

- “Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журмын¹⁰³ 4.6-д “Суралцагч амжилттай суралцан төгсөөд гэрээнд заасан байгууллагад 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан тохиолдолд зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлт гаргаж болно. Зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан иргэний асуудлыг Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөл хэлэлцэн, дүгнэлтийг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ” гэж,
- “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-ын¹⁰⁴ 4.1-д “Энэхүү журмын дагуу дэлхийн шилдэг их сургуульд суралцагчийн сургалтын зээлийн хөнгөлөлт, эргэн төлөлттэй холбогдох асуудлыг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна” гэж,
- “Боловсролын зээлийн сангийн дүрэм”-ийн¹⁰⁵ Удирдах зөвлөлийн үүргийн 2.7.5-д “сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх” гэж,
- “Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын”-ын¹⁰⁶ 6.9-д “Сантай гэрээ байгуулж үл хөдлөх хөрөнгө барьцаалан гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч нь төгссөнөөс хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд мэргэжлээрээ Монгол Улсад ажилласан бол тухайн иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтад үндэслэн хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасан нөхцөл, шалгуурыг тус тус баримтлаагүй байна.

2.64. Харин БСШУСС-ын 2017 оны А/88, 2018 оны А/555, 2020 оны А/195, БСШУС-ын 2022 оны А/83, 2023 оны А/31 дүгээр тушаалаар сургалтын төлбөрийн зээл, гэрээний үүргийг чөлөөлсөн иргэдээс нэр бүхий 9 иргэн нийт 228.9 мянган ам.долларын сургалтын төлбөрөөс 2023-2024 оны хооронд 187.4 мянган ам.долларын төлбөрийг эргэн /үлдэгдэл 41.5 мянган ам.доллар/ төлсөн нь чөлөөлөлт хийсэн нийт 11,420.6 мянган ам долларын 1.6 хувийг л эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 11 Боловсролын асуудал эрхэлсэн салбарын сайдын тушаалаар сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлөгдсөн шийдвэрт хамрагдсан ч сургалтын төлбөрийг эргэн төлсөн иргэдийн судалгаа

№	Суралцуулах шийдвэрийн огноо, дугаар	суралцсан түвшин	СТЗ-ийн дүн /ам.доллар/	Гэрээний Үүргээс чөлөөлсөн шийдвэр	Сургалтын төлбөр төлсөн		үлдэгдэл
					баримтын огноо	дүн /ам.доллар/	
1	2007.08.08 №292	Магистр	32,000.0	2018.08.31-ний А/555	2023-03-28	32,000.0	-
2	2004.07.20 №А/240	Магистр	33,500.0	2017.07.27-ны А/88	2023-05-23	33,500.0	-
3	1999.08.05 №А/110	Магистр	32,580.0	2018.08.31-ний А/555	2023-05-24	32,000.0	580.0
4	2001.07.31 №А/241, 2006.08.07 №276	Магистр	18,000.0	2017.07.27-ны А/88	2023-05-26	4,213.5	13,786.5
5	2014.03.03 №А/53	Магистр	16,000.0	2020.12.21-ний А/195	2023-05-26	16,000.0	-
6	2007.07.17 №А/270	Магистр	16,808.0	2018.08.31-ний А/555	2023-05-26	16,808.0	-
7	2003.12.04 №А/411	Магистр	32,000.0	2022.03.14-ний А/83	2023-06-15, 2024-01-12	9,000.0	23,000.0
8	2004.05.24 №185	Магистр	16,000.0	2018.08.31-ний А/555	2023-07-04	11,843.2	4,156.8
9	2013.08.08 №А/278	Магистр	32,000.0	2023.02.01-ний А/31	2024-05-07	32,000.0	-
			228,888.0			187,364.7	41,523.3

Эх сурвалж: Аудитын баг

2.65. Боловсролын асуудал эрхэлсэн Сайдын 2017-2023 оны хооронд эрх мэдлээ хэтрүүлэн гаргасан шийдвэрээс шалтгаалж сургалтын төлбөрийн зээлийн чөлөөлөлтөд хамрагдсан 381 иргэн буюу сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлөөгүй 11,233.2 мянган.ам доллар буюу 38,422.7 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

¹⁰³ Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор баталсан, /Засгийн газрын 2012-01-18-ны 19-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/

¹⁰⁴ Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан /Засгийн газрын 2021.11.10-ны 347 тогтоолоор хүчингүй болсон/

¹⁰⁵ Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор баталсан /Засгийн газрын 2020 оны 70, 2021 оны 347 дүгээр тогтоолоор хүчингүй болсон/

¹⁰⁶ Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан /Засгийн газрын 2024.02.28-ны 72 дугаар тогтоолоор хүчингүй болсон/

БҮЛЭГ-3: ЦАХИМ СИСТЕМ АШИГЛАЛТ, МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ, БОЛОВСРУУЛАХ БОЛОН ДОТООД ХЯНАЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА

Сангийн үйл ажиллагаанд ашиглаж буй цахим системүүд хангалтгүй бөгөөд хоорондын уялдаа хангагдаагүй байна.

Сангийн мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, ашиглаж буй цахим систем нь интеграци, автоматжуулалт дутмагаас мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд эрсдэл үүсэж байна.

3.1. БЗС-ийн үйл ажиллагаанд ашиглаж буй цахим системүүд хоорондын уялдаа холбоотой, сургалтын зээл, тэтгэлэг, сургалтын төлбөр болон амьжиргааны зардал, хамрагдаж буй иргэний хувийн хэргийн мэдээллийг цахим системд бүртгэж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх шаардлагыг Засгийн газрын 2012 оны 19, 2016 оны 111, 2017 оны 176, 2018 оны 46, 2020 оны 70, 2021 оны 347, 275, 2022 оны 346, 2024 оны 102 дугаар тогтоол болон тогтоолоор баталсан журамд тодорхой заагдсан байна.

3.2. БЗС-ийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургуульд зээл, тэтгэлгээр суралцсан, суралцаж буй суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаа бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад)-ийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасаар болон цахимаар хадгална гэж заасан ч цахим мэдээллийн сан бүрдээгүй байна.

- 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан журмын 14.2. Сан суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаалбар бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад)-ийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасаар болон цахимаар хадгална гэж,
- 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан журмын 13.6. Сан суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаа бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад)-ийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасаар болон цахимаар хадгална гэж тус тус заасан.

3.3. Системүүд хоорондоо уялдаа холбоотой, нэгтгэсэн мэдээллийн сантай байх, мэдээллийг гараар давхар оруулахгүйгээр шууд ашиглах нөхцөлийг бүрдүүлэхийг тодорхой заасан ч сургалтын зээл болон тэтгэлгийн мэдээллийг нэгтгэн, нэгдсэн цахим сан үүсгэж, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдал, боловсруулалт хийх, тайлагнах үйл ажиллагааг дараах системүүдэд журмын шаардлагыг хангаж ашиглаж, хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

1. Дотоодын их дээд сургуулийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн мэдээллийн систем (grant.elf.gov.mn)
2. Оюутны хөгжлийн зээлийн мэдээллийн систем (loan.elf.gov.mn) нь Монгол банкны ЗМС-тай холбогддог бөгөөд эргэн төлөлт, нийт зээлийн дүн, хуваарийг хариуцдаг. Дотоодын их дээд сургуулийн зээлээр суралцдаг иргэний дэлгэрэнгүй мэдээллийг тус системд бүртгэн, Filemaker программ ашиглан Сангийн яамны данс чагнах системтэй холбогдож дотоодын их дээд сургуульд зээлээр сурсан суралцагчдын эргэн төлөлтийн мэдээллийг эксэл файл болгож, экспорт хийж, Оюутны хөгжлийн зээлийн систем рүү импорт хийдэг. Оюутны хөгжлийн цахим системээр дамжуулан Монгол банкны ЗМС-д эргэн төлөлтийн мэдээлэл болон эргэн төлөлтийн хуваарь боловсруулж оруулдаг.
3. Гадаадын их, дээд сургуульд суралцаж буй суралцагчдын тэтгэлгийн мэдээллийн систем (elf.gosmart.mn) нь тэтгэлгээр суралцсан болон суралцаж буй иргэдийн мэдээллийг цахим мэдээллийн санд хадгалдаг. Тухайн системийн үндсэн зориулалт нь цахим сургалтын платформ бөгөөд үндсэн системийн үйл ажиллагаа нь БЗС-ийн суралцагчийн хувийн хэргийг үнэн зөв бүрэн бүтэн хадгалах, нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарах, эрсдэл үүсэх болзошгүй юм.
4. Гадаадын их, дээд сургуульд суралцаж буй суралцагчдын зээлийн мэдээллийн системийн хөгжүүлэлтүүд 2016, 2019 он тус бүр шинээр хийлгүүлж байсан ба үйл ажиллагаандаа огт ашиглаагүй байна. 2020 оны 3 сарын 27-ны өдөр мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, онлайн лавлах үйлчилгээ нэвтрүүлэх ба оюутанд зээл олгох ажлыг хөнгөвчлөх автоматжуулсан системийн хамтран ажиллах, гүйцэтгэх гэрээ байгуулсан хэдий ч 2025 оны 1-р улирлын байдлаар гэрээг дүгнээгүй ашиглалтад ороогүй байна.

3.4. Сангийн өдөр тутамд хэрэглэж буй цахим системүүд нь мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх суурьтай ч гараар оруулах, нэмэлт засвар хийх шаардлага байгаагаас мэдээллийн давхардал, алдаатай орох эрсдэлтэй, систем хооронд интеграци хийгдээгүй, мэдээллийн хяналт бүрэн автоматжуулагдаагүй байна.

Боловсролын зээлийн сангийн мэдээлэл Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүрэн, үнэн зөв бүртгэгдэхгүй байна.

3.5. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор баталсан журмын 3.1.4, 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан журмын 6.8, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-58 тушаалаар баталсан "Монгол банкны ЗМС-ийн журам"-ын дагуу БЗС-ийн зээлдэгчийн мэдээллийг нөхөж оруулсан байна. Үүнд:

- 2025 оны 5 дугаар сарын байдлаар ЗМС-д нийт 16,874 зээлдэгч бүртгэлтэй байна үүнээс Гадаадын их, дээд сургуульд зээлээр суралцаж байгаа, суралцсан нийт 1,366 суралцагч бүртгэлтэй байгаагаас 2017-2024 онд сурсан суралцагчдын 410 нь бүртгэлд орсон ба нийт дүн нь 24,1 сая ам.доллар байна.
- 2017-2024 онд гадаадын их, дээд сургуульд зээлээр суралцсан нийт суралцагчдаас 410 нь л бүртгэлд орсон, мэдээлэл нөхөж оруулахдаа нийт болон төлсөн дүнг хамтад нь тусгаагүй, зээл олгосон болон төлөх огнооны зөрүүтэй нийт 14,928 өгөгдөл бүртгэгдсэн зэрэг нь зээлийн мэдээлэл бүрэн, үнэн зөв байх нөхцөл хангагдаагүй ба мэдээлэл оруулах үйл явцад зохион байгуулалтын болон мэдээллийн чанарын асуудалд нөлөөлсөн байна.

3.6. Мөн БЗС, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай 2024.11.14-ний өдөр мэдэгдэл хүргэх систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, сургалтын төлбөрийн зээлээр сурсан иргэд "E-Mongolia" системээр дамжуулан зээлийн мэдээллээ харах боломжтой болсон байна.

3.7. ЗМС дахь мэдээлэл дутуу, зөрүүтэй бүртгэгдсэн нь зээлдэгчийн зээлийн түүхийг буруу харуулах, төлбөрийн чадварын үнэлгээ болон санхүүгийн сахилга батын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Энэ нь зөвхөн хувь хүний зээлийн үнэлгээнд төдийгүй төрөөс олгож буй боловсролын зээлийн хөрөнгийн бодит эргэн төлөлтийн байдлыг гажуудуулж, бодлого төлөвлөлтөд ашиглах мэдээллийн чанарт нөлөөлнө.

Олон нийтэд мэдээлэх, зарлах болон нийтэд хүртээмжтэй байх хэрэгжилт хангалтгүй байна

Засгийн газар дэлхийн шилдэг их сургуулиудад суралцуулах мэргэжлийн чиглэлийг тухай бүр олон нийтэд зарласан ч нийтэд хүртээмжтэй бус байсан.

3.8. ЗГ-ын 2014 оны 71, 2020 оны 70, 2023 оны 115 дугаар тогтоолыг үндэслэн 2017-2024 оны хооронд тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн жагсаалтыг 3 удаа, эрэлттэй мэргэжлийн чиглэлийн жагсаалтыг 1 удаа баталсан байна. Үүнд:

- 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл" (ЗГ-ын 2020 оны 70 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)
- 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт" (ЗГ-ын 2023 оны 115 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)
- 2023 оны 115 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэл", "Дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэл"
- Салбарын яам 2019, 2023 онд тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн жагсаалтын төсөл боловсруулж Засгийн газарт хүргүүлж байсан.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/92 дугаар тушаалаар "Эрэлттэй мэргэжлийн жагсаалт"-ыг 2021 оны "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа"-ны үр дүнд үндэслэн баталсан байна.
- Салбарын яам нь 2024 онд тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл (хөтөлбөр)-ийг тодорхойлох аргачлалыг баталсан ба өмнөх онуудад батлагдсан аргачлалгүйгээр боловсруулалт хийж Засгийн газарт хүргүүлж байсан байна.

3.9. "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын /2013 оны 271/ 1.6-д "...мэргэжлийн чиглэлийг өмнөх оны эхний хагас жилд багтаан тогтоох", 1.7-д "тухайн мэргэжлийн чиглэл болон ... Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод зарлах...", Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолын 6-д "...хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг хоёр жил тутам шинэчилж, хоёр дахь жилийн I улиралд багтаан нийтэд мэдээлэхийг...", "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын /2024 оны 102/ 1.9-д "... тухайн жил тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжид хамрагдах ... мэргэжлийг жил бүрийн I улиралд багтаан тогтоох ёстой" гэж тус тус заасан байна.

3.10. Дээрх тогтоол, журмын шалгуурыг үндэслэн эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /legalinfo.mn/-д тухай бүр, харин Салбарын яам нь тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг батлах бүрд өөрийн цахим хуудсанд мэдээ хэлбэрээр байршуулсан байна.

3.11. Дээрх байдал нь ерөнхий мэдээллийг хүргэх зориулалттай, хүртээмжтэй хялбар байдлаар харахад хүндрэлтэй, уламжлалт арга барил ба вэбсайтын бүтэцтэй холбоотой, мөн нэн шаардлагатай мэдээллийг хайх, ангилах, татаж авах хэлбэрээр олон нийтэд шууд хүргэхэд технологийн шийдэл хангалтгүй байжээ.

3.12. Харин 2025 онд салбарын яамны захиалгаар сонгон шалгаруулалтын цахим системийг шинээр хөгжүүлж, эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн жагсаалтыг олон нийтэд мэдээлж эхэлсэн нь мэдээллийн хүртээмжтэй, хялбар ашиглах боломжийг бүрдүүлжээ.

Суралцагчдын хяналтын тоог, суралцуулах оюутны тоог тухай бүрд нь олон нийтэд ил тод зарлаагүй байна.

3.13. "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 1.5-д "тухайн жилд сургалтын төлбөрийн зээл авах суралцагчдын хяналтын тоог ... олон нийтэд мэдээлэх", "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын 1.7-д "... тухайн жилд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж...", "Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын 3.1.2-т "хяналтын тоог батлагдсан өдрөөс эхлэх 14 хоногийн дотор хяналтын тооны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх" гэж тус тус заасан байна.

3.14. Гэтэл Салбарын яам, БЗС нь тухайн жилд сургалтын төлбөрийн зээл авах суралцагчдын хяналтын тоог, суралцуулах оюутны тоог батлагдсан өдрөөс эхлэх 14 хоногийн дотор дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлаагүй нь ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг сайжруулах боломж хязгаарлагдсан байна. /аудитын явцад 2018–2024 он тус бүрийн батлагдсан хяналтын тоог өөрийн цахим хуудсан дээр байршуулж нөхөн бүрдүүлсэн^{107/}

Сургалтын зээл, тэтгэлгийн сонгон шалгаруулалтын ил тод байдал алдагдсан нь үнэлгээ, шийдвэрийн үндэслэлийг хянах боломжгүйд хүргэсэн байна.

3.15. Сонгон шалгаруулалтын шалгуур, шаардлага нь ил тод, нийтэд нээлттэй байх ёстой бөгөөд сонгон шалгаруулалтын үе шат бүрийн үйл ажиллагаа бүртгэгдсэн, хяналттай, нээлттэй ил тод байх шаардлагатай гэж дараах журамд заасан байна. Үүнд:

- 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 3.3-т заасны дагуу батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам"-ын 1.3-т¹⁰⁸
- 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журам"-ын 2.4-т¹⁰⁹

¹⁰⁷ Боловсролын зээлийн сан нь 2025 оны 8 дугаар сард

¹⁰⁸ Дэлхийн шилдэг их сургуульд сургалтын төрийн сангийн зээлээр суралцах хүсэлтэй иргэнийг сонгон шалгаруулалт болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө яамны цахим хуудсаар дамжуулан зарлаж бүртгэнэ

¹⁰⁹ Зээлд хамрагдах суралцагчийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталсан комисс, удирдамжийн дагуу сонгон шалгаруулна.

- 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 1.3-т¹¹⁰
- 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын 3.26¹¹¹, 11.4¹¹², 11.5¹¹³, 11.6¹¹⁴, 11.12¹¹⁵, 11.13¹¹⁶

3.16. 2024 оны Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн даргаар БЗС-ийн ажлын албаны дарга томилогдсон, харин өмнөх онуудын СШАХ-ийн даргаар салбарын яамнаас томилогдсон бөгөөд сонгон шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй байдлаар байршуулсан байна. Тухайлбал:

- 2024 оны СШАХ-ийн удирдамжид заасан аргачлал, шалгуур, шаардлага, шалгарсан суралцагчдын жагсаалт цахим хуудсанд дээр онооны эрэмбээр БЗС-ийн цахим хуудсанд нээлттэй, ил тод байршуулсан байна.
- 2025 онд шалгуур, шалгарсан суралцагчдын жагсаалт сонгон шалгаруулалтын цахим хуудсанд онооны эрэмбээр харагдаж байна.

3.17. Харин Боловсролын яамнаас сонгон шалгаруулалтын 2017-2022 оны ажлын хэсгийн баримт материалыг аудитын явцад ирүүлээгүйгээс мөн онуудын сонгон шалгаруулалтын үнэлгээ, шийдвэрийн үндэслэлийг хянах боломжгүй, сонгон шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй болгосон мэдээлэл байгууллагын цахим хуудсанд байхгүй байна.

Сангийн үйл ажиллагаанд тавьсан дотоод хяналтын үр дүн хангагдаагүй байна

Салбарын яамнаас 2019-2023 оны хооронд сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын үр нөлөө гараагүй байна.

3.18. БСШУСС-ын 2019 оны А/124, А/739 дугаар, 2020 оны А/31, А/66 дугаар, БСШУС-ын 2022 оны А/299 дугаар, 2023 оны А/39, А/58, А/211, А/523 дугаар тушаалаар БЗС-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна.

3.19. Дараах ажлын хэсэг сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлтийг гаргасан эсэх, илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн эсэх, хяналтын үр дүн, үр нөлөөг тооцсон эсэх тодорхойгүй байна. Үүнд:

БСШУСС-ын 2019 оны А/124 дугаар тушаал	БЗС-ийн хууль тогтоомжоор олгосон чиг үүрэг, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах, дүгнэлт гаргах
БСШУСС-ын 2019 оны А/739 дугаар тушаал	БЗС-д сургалтын төлбөрийн чиглэлээр үүссэн авлагын нөхцөл байдлыг судалж, нягтлан бодох бүртгэлийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, санал гаргах
БШУС-ын 2020 оны А/66 дугаар тушаал	БЗС-ийн санхүүжилтээр "Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ"-г биелүүлж, улмаар зээлээс чөлөөлөгдөх шаардлагыг хангасан иргэдийн баримт бичигт дүн шинжилгээ хийх
БШУС-ын 2022 оны А/299 дугаар тушаал	• Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийн сонгон шалгаруулалт, санхүүжилт, Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар яаманд ирүүлсэн өргөдөл, гомдолд дурьдсан асуудлын дагуу төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх
БШУС-ын 2023 оны А/211 дугаар тушаал	• Боловсролын зээлийн сангийн хөрөнгөөр гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн иргэдийн зээлийн чөлөөлөлт, эргэн төлөлтийн асуудлыг судалж, шийдвэрийн санал, төсөл боловсруулах /А/58 тушаалаар ажлын хэсэгт нэмэлт оруулсан/

¹¹⁰ Энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, сонгон шалгаруулалт нь шударга, ил тод, нээлттэй, тэгш боломжийг хангах зарчмыг баримтална.

¹¹¹ Энэ журмын 3.11-д заасан тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн оны II улиралд зохион байгуулах бөгөөд зарыг сонгон шалгаруулалтын баримт бичиг хүлээн авах хугацаанаас 3 сарын өмнө боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, сангийн цахим хуудсаар нээлттэй хүргэнэ.

¹¹² Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар дотоодын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн I, III улиралд, энэ журмын гурав дахь хэсэгт зааснаас бусад гадаадын сургалтын байгууллагад суралцах сонгон шалгаруулалтыг жил бүрийн II улиралд цахимаар зохион байгуулна.

¹¹³ Сонгон шалгаруулалтын мэдээллийг хүсэлт хүлээн авах хугацаанаас 30 хоногийн өмнө сан болон сургалтын байгууллагын цахим хуудсаар нээлттэй зарлана.

¹¹⁴ Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтийг дотоодын сургалтын байгууллагад суралцах бол сургалтын байгууллагадаа, гадаадын сургалтын байгууллагад суралцах бол санд сонгон шалгаруулалтын заасан хугацаанд гаргана.

¹¹⁵ Ажлын хэсэг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгийг шаардлага хангасан суралцагчдын нэрсийн хамт сангийн Ажлын албаны даргад хүлээлгэн өгөх бөгөөд суралцагч тус бүрд Ажлын хэсгийн гишүүний өгсөн оноо ил байх боломжийг бүрдүүлнэ.

¹¹⁶ Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 2 өдрийн дотор нэрсийг баталгаажуулж, шийдвэрийг цахим шуудан эсхүл утсаар мэдэгдэн, сан болон холбогдох байгууллагын цахим хуудсаар нээлттэй, ил тод мэдээлнэ.

3.20. Салбарын сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг БЗС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг тухай бүрд нь хүргүүлж, үр нөлөөг тооцож ажиллах шаардлагатай.

Хөндлөнгийн хяналтаар БЗС-ийн 2017-2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр 2017-2019, 2022-2024 онуудад "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна.

3.21. УАГ-аас 2017-2024 он тус бүр сангийн санхүүгийн тайланг баталгаажуулж, 2017-2019 он, 2022-2024 онд "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгч, 2017-2024 оны хооронд нийт 115.9 сая төгрөгийн дүнтэй 4 төлбөрийн акт, 941,167.8 сая төгрөгийн дүнтэй 51 албан шаардлага, 32 зөвлөмж өгснөөс 2025.06.30-ны өдрийн УАГ-ын статистик мэдээгээр биелэлтийн хугацаа болоогүй 201,600.0 сая төгрөгийн дүнтэй 20 албан шаардлага, 1 зөвлөмж биелэгдээгүй үлдэгдэлтэй байна.

Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 31,293.0 мянган ам долларын алдаа, зөрчил илэрсэн байна.

3.22. Салбарын сайдаас эрх мэдлээ хэтрүүлэн гаргасан 381 иргэний 11,233.2 мянган ам.долларын сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлсөн шийдвэрийг хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлж, нийт 132.0 мянган ам.доллар буюу 491.4 сая төгрөгийг¹¹⁷ нөхөн төлүүлэх төлбөрийн акт 2, Боловсролын яаманд алдаа зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага, БЗС-д нийт 19,927.8 мянган ам.доллар буюу 71,643.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан шаардлагыг хүргүүлсэн. Үүнд:

Хүснэгт 12 Алдаа зөрчлийн нэгтгэл

№	хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Зөрчлийн дүн									Нийт дүн	
		төлбөрийн акт			албан шаардлага			ХХБШ ¹¹⁸				
		тоо	мянган ам доллар	мянган төгрөг	тоо	мянган ам доллар	мянган төгрөг	тоо	мянган ам доллар	тоо	мянган ам доллар	мянган төгрөг
1	Боловсролын сайд				2			1	11,233.2	3	11,233.2	
2	БЗС-ийн ажлын алба	2	132.0	491,382.9	3	19,927.8	71,643,339.2			5	20,059.8	72,134,722.1
Нийт		2	132.0	491,382.9	5	19,927.8	71,643,339.2	1	11,233.2	8	31,293.0	72,134,722.1

Эх сурвалж: Аудитын баг

¹¹⁷ Монгол банкнаас зарласан 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн ханшаар хөрвүүлэв.

¹¹⁸ Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх

ДҮГНЭЛТ

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Сангийн хууль, эрх зүйн орчин, боловсон хүчний тогтвортой байдал:

1. Засгийн газраас Боловсролын зээлийн сангийн ажлын албыг байгуулаагүй, тусгай сангийн зорилгыг бүрэн тодорхойлж чадаагүй, хуулийн этгээдийн улсын бүртгэлд санг "ТБАГ", "УТҮГ" гэсэн тусдаа хариуцлагын хэлбэрийг хамтатган бүртгүүлсэн байна.
2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар "Боловсролын зээлийн сан"-ийн ажлын албаны үйл ажиллагааны зориулалтыг тодорхойлсон ч Боловсролын ерөнхий хуульд сангийн тогтолцоог хуульчлаагүй, бусад хууль хоорондын уялдаа хангагдаагүй байна.
3. Засгийн газраас баталсан сангаас үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг зохицуулсан журмын олон удаагийн өөрчлөлтөөс эрх зүйн зохицуулалт хангалтгүй, сангийн хөдөлмөрийн дотоод журамд зарим нэгжийн чиг үүргийг тусгаагүй, боловсон хүчин тогтворгүйгээс төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, үр нөлөөтэй үзүүлж чадахгүй байна.
4. Засгийн газрын тогтоолоор баталсан 2012-2024 оны хооронд мөрдөж байсан журмуудад сургалтын төлбөрийн зээлд хүү тооцох зохицуулалтгүй, Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан одоо мөрдөж буй журамд "...Дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээлийг орлогын түвшинд тохируулан төлөх боломжийг олгож...", суралцагч төлбөрийн дарамтгүй, илүү хялбар нөхцөлөөр зээл авах, уян хатан, таатай нөхцөлтэй ч улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ жил бүр нэмэгдэх, улсын төсөвт ачаалал үүсгэх эрсдэлтэй байна.

Сангийн төрийн үйлчилгээний үр дүн:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2017-2024 оны хооронд гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцагчдад олгосон санхүүжилтээс 269,468.6 сая төгрөг буюу 57 хувийг сургалтын төлбөрийн тэтгэлэгт, 203,689.9 сая төгрөг буюу 43 хувийг сургалтын төлбөрийн зээлд зарцуулсан байна.
2. Гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцагчдын хяналтын тоо, суралцуулах оюутны тоог тухайн бүр, гадаадын их, дээд сургуульд суралцах иргэдийн сонгон шалгаруулалтын явц, үр дүнг олон нийтэд ил тод зарлаагүй, салбарын сайдаас сонгон шалгаруулалтад тэнцээгүй иргэнийг тэтгэлэгт хөтөлбөрөөр суралцуулах шийдвэрийг гаргасан байна.
3. Тус сантай 2017-2024 оны хооронд гэрээ байгуулж гадаадын их дээд сургуульд суралцаж төгссөн иргэдийн гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй, хариуцлага тооцох систем байхгүйгээс 299 иргэний 19,927,8 мянган.ам доллар буюу 71,607,560.1 мянган төгрөгийн зээлийг эргэн төлүүлээгүй байна.
4. Салбарын сайдын 2022 оны тушаалаар БНПУ-д суралцаж буй 8 суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг, 2016-2018 оны хооронд Дэлхийн шилдэг их, дээд сургуульд зээлээр суралцуулах шийдвэрийг гаргаж, Засгийн газрын тогтоолоор баталсан журамд "Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг нэг суралцагчид нэг удаа олгоно", "сангаас өмнө авсан зээл төлөөгүй тохиолдолд зээл олгохгүй" гэж заасныг зөрчиж 3 иргэнд өмнө авсан зээлээ төлөөгүй байхад давхар санхүүжилт олгож, нийт 474,246.9 мянган төгрөгийг илүү олгосон байна.
5. Боловсролын зээлийн сан нь 6 арилжааны банкт байгуулсан "Зээлийн гэрээ"-ний үүргийн хэрэгжилтийг бүрэн дүгнээгүй, холбогдох хууль, эрх зүйн акт хүчингүй болсон байхад гэрээний биелэлтийг дүгнээгүй, 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 5 арилжааны банканд нийт 35,779,082.0 төгрөгийн үлдэгдэл байна.
6. Салбарын сайдаас 2017-2023 оны хооронд 10 удаагийн тушаалаар 487 суралцагчийн гэрээний үүргийг дуусгавар болгосноос 381 иргэний 11,233.2 мянган.ам долларын сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлсөн нь хуулиар олгогдоогүй эрх, мэдлийг хэтрүүлэн хэрэглэж, гаргасан шийдвэр нь хуульд нийцээгүй байна.

7. Гадаадын их, дээд сургуульд 2017-2024 оны хооронд нийт 22 улсад, 103 мэргэжлээр суралцаж буй суралцагчдаас тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцаагүй 123, төгсөж ирээд санд бүртгүүлэх гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй 237 суралцагч нь эх орондоо эргэж ирсэн эсэх, суралцсан мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэх талаар бүртгэлгүй, тандах, мөшгөх судалгааг хийдэггүй, улсын төсвийн хөрөнгөөр боловсон хүчин бэлтгэсэн үр нөлөөг тооцоогүй байна.
8. Боловсролын зээлийн санд мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, ашиглаж буй мэдээллийн систем нь интеграци, автоматжуулалт дутмагаас мэдээлэл бодитой биш, Монгол банкны зээлийн мэдээллийн санд суралцагчийн зээлийн мэдээлэл зөв бүртгэгдээгүй, сангийн архивд цаасан сууриар хадгалж буй 1857 суралцагчийн хувийн хэрэг дэх баримт бичгийн бүрдэл нь шаардлага хангаагүйгээс зээлийн сан, суралцагчдын хооронд маргаан үүсэх, холбогдох баримт бичиг устаж үгүй болох эрсдэлтэй, мэдээллийн ил тод, найдвартай байдал алдагдсан байна.

Сангийн үйл ажиллагаанд тавьж буй хяналт, түүний үр нөлөө:

1. Хөндлөнгийн хяналтаар тус сангийн 2017-2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр 2017-2019, 2022-2024 онуудад “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна
2. Салбарын яамнаас 2019-2023 оны хооронд тусгай сангаас үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн тайлан, дүгнэлтийг гараагүй, алдаа зөрчилд зөвлөмж чиглэл өгөөгүй, хяналтын үр дүн, үр нөлөөг тооцоогүй, салбарын хяналт сул байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газар /Ерөнхий Сайдад

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан "Боловсролын зээлийн сан"-ийн зориулалт, тогтолцоо, хариуцлагын хэлбэрийг Боловсролын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай болон бусад хууль тогтоомжтой уялдуулах, сангийн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг ил тод, нээлттэй, ялгаварлан гадуурхахгүй байхад чиглэгдсэн хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх;
2. Засгийн газраас ТБОНӨТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д "хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, ..." гэж заасны дагуу хуулийн этгээдийг зохих журмын дагуу байгуулах асуудлыг шийдвэрлэх, тус сангийн үйл ажиллагаа, үйлчилгээ нь олон улсын сайн жишигт нийцсэн байх нөхцөлийг бүрдүүлэх.

Боловсролын Сайдад

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан "Боловсролын зээлийн сан"-ийн тогтолцоо, зориулалт, хариуцлагын хэлбэрийг салбарын хууль, бусад хууль хооронд уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийж, тусгай сангийн эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагыг тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын шийдвэрийг гаргах, Засгийн газарт холбогдох хууль хоорондын уялдааг хангасан хуулийн төслийг оруулах;
2. Боловсролын зээлийн сангийн зорилго, зорилтыг хуульд нийцүүлэн тодорхойлж, сангийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үйлчилгээнд нийцсэн бүтэц, нэгж, албан тушаалтны чиг үүргийг тодорхой болгох шийдвэрийг гаргах;
3. Сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн иргэдийн гэрээний үүргийн биелэлт, зээлийн эргэн төлөлт, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, сангийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарах;
4. Салбарын сайдаас гадаадын их, дээд сургуульд суралцагчдыг суралцуулах шийдвэрийг гаргахдаа сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн онооны дараалал, эрэмбийг харгалзан сонгох, иргэнд эрх тэгш үйлчлэх зарчмыг баримталж ажиллах;
5. Салбарын яамнаас бусад яамдтай хамтран "Дээд боловсрол"-ын чиглэлд салбар хоорондын уялдааг хангасан тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг үндэслэлтэй тогтоох, сангийн санхүүжилтээр суралцаж төгссөн иргэний эзэмшсэн мэргэжлээр ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг тогтмол гаргаж, урт хугацааны зорилго, зорилтыг хангахад чиглэсэн бодлогын шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлэх;
6. Боловсролын зээлийн сангийн одоо ашиглаж буй цахим мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах, нэгдсэн цахим мэдээллийн системтэй болгоход шаардагдах төсөв, хөрөнгийн саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, батлуулах, сангийн төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй үзүүлэхэд чиглэсэн бодлогын шийдвэрийг гаргах;
7. Гадаад, дотоодын их дээд сургуульд суралцах суралцагчдын хяналтын тоо, сонгон шалгаруулалтын үйл явц, үр дүнг тухай бүрд нь "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байх.

Боловсролын зээлийн сангийн ажлын албанд:

1. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх хариуцлагын хэлбэрийг хуульд нийцүүлэн зөв тогтоолгох.
2. Тусгай сангийн зорилгыг холбогдох хуульд нийцүүлэн бүрэн тодорхойлох, сангийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг эрх тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх нөхцөлийг хангасан холбогдох журмын төслийг дээд шатны байгууллагад оруулж шийдвэрлүүлэх.
3. Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан сангийн үйл ажиллагааны чиг үүргийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд бүрэн тусгаж, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг чиг үүргийн давхардалгүй, холбогдох журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүлэх.
4. Сангаас төрийн үйлчилгээг иргэдэд чанартай үзүүлэх чадварлаг хүний нөөцийг бий болгох, боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын сайн туршлага, жишгийг нэвтрүүлэх.
5. Улсын төсвийн хөрөнгөөр гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн 299 иргэний 19,927.8 мянган.ам долларын сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх хуваарь, хугацааг иргэн бүртэй хийж, гэрээний үүргийг хэрэгжилтийг хангуулах үр нөлөөг тооцож хэвших;
6. Сангийн одоо ашиглаж буй мэдээллийн системийн интеграци, автоматжуулалтыг сайжруулах, мэдээллийн давхардлыг арилгах, систем хооронд мэдээлэл солилцох, нэгдсэн мэдээллийн системтэй болгоход шаардагдах төсвийн саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй болгох, мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй түгээх нөхцөлийг бүрдүүлэх;
7. Байгууллагын архивд байгаа цаасан суурьтай суралцагчийн хувийн хэрэг, баримт материалыг цахим хэлбэрт шилжүүлэх, “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль болон холбогдох хууль, журамд нийцүүлэн цаасан суурьтай баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах;
8. Гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн иргэдтэй гэрээний үүргийг харилцан биелүүлэх нөхцөлийг сануулах, шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн байгууллагын цахим мэдээллийг авах хүсэлтийг салбарын яамаар дамжуулан санал тавьж шийдвэрлүүлэх, хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах;
9. Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг суралцагчдад олгосон зээлийн дүн, зээлийн эргэн төлөлтийн дүнг бодитой бүртгэж, мэдээллийн найдвартай, ил тод байдлыг хангах.

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-61) 26 08 17, Факс: (976-61) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 10. 03 № НЭГ/2754
танай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

Танаас Монгол Улсын Ерөнхий сайдад ирүүлсэн "Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны үр дүн" сэдэвт гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлангийн Боловсролын сайдад зөвлөмж өгсөн хэсэгт дараах асуудлыг тусгах саналыг хүргүүлж байна:

Тайлбар
1-г үзэх

-Боловсролын зээлийн сангийн асуудлаар олон нийтийн дунд үүсээд байгаа эргэлзээг арилгах, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тус санг олон улсын жишигт нийцсэн сан болгон өөрчлөх арга хэмжээ авах;

Тайлбар
2-г үзэх

-Боловсролын зээлийн сангийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлээр 1997-2016 онд гадаад улсад суралцсан иргэдийг зээлийн гэрээний үүрэгтэй холбоотой чөлөөлөх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн судалж, шийдвэрлэх арга хэмжээ авах.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255014096



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: info@mo.gov.mn,
Цахим хуудас: www.mo.gov.mn

2025.10.02 № 1/4566

танай -ийм № -т

Тайлангийн төсөлд санал өгөх тухай

Танаас ирүүлсэн "Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны үр дүн" сэдэвт гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй сайтар танилцан, холбогдох саналыг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

1. Боловсролын зээлийн сангийн асуудлаар олон нийт, нийгмийн сүлжээгээр иргэдийн дунд үүсээд байгаа төөрөгдлийг арилгах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор "Засгийн газрын тусгай сангийн тухай хууль", "Төрийн албаны тухай хууль", "Боловсролын ерөнхий хууль", "Дээд боловсролын тухай хууль"-д тус тус нийцүүлэн Боловсролын зээлийн санг олон улсын жишигт нийцсэн Боловсрол хөгжлийн сан болгон өөрчлөх тухай саналыг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэн батлуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт;

Тайлбар
3-г үзэх

2. Сангийн албан хаагчдын тогтвортой байдлыг хангах зорилгоор бүтэц, нэгжийн чиг үүрэг орон тосонд өөрчлөлт оруулж зээл, тэтгэлэг олгох, зээлийн эргэн төлөлтийг хариуцах хууль эрх зүйн нэгжийг бий болгох, тухайн байгууллагын төрийн албан хаагчийн ангилал зэрэглэлийг тусгайлан авч үзэж, хэвийн ажиллах эрх зүйн орчныг бий болгох;

3. Олон улсын сайн туршлагад тулгуурлан хөрөнгө бүрдүүлэлт, ашиглалт, эндаументын (байнгын хөрөнгө бүрдүүлэх) сангийн тогтолцоог бий болгож сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах;

Тайлбар
4-г үзэх

4. Эргэн төлөлтийн орлогыг оновчтой ашиглах зорилгоор эргэн төлөлтөөс бүрдэж буй санхүүжилтийг бие даан дахин санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, сангийн хөрөнгийг үр өгөөжтэй эргэлтэд оруулах боломжийг хангах;

5. Архив, албан хэрэг хөтлөлт болон суралцагчдын бүртгэл, хувийн хэргийг хадгалж буй тогтолцоог цахимжуулж, суралцагчидтай байгуулах гэрээ болон гэрээ дүгнэлтийг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

6. Сангийн үйл ажиллагаа, зарцуулалт, шийдвэрийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх, сурталчлах, харилцагчдыг хүлээн авч мэдээллээр хангах зэрэг эрх зүйн зохицуулалт болон техникийн боломжийг бий болгох асуудлыг дүгнэлтэд нэмж тусган хамтран ажиллахыг хүсье.



П.НАРАНБЯЯР

14256 2004



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ
БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САН

САН plaza, Ченджерэвэн гудамж-32/2, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976) 7004 7009, Факс: (976) 7010 9499
Цахим шуудан: contact@elf.gov.mn
Цахим хуудас: www.elf.gov.mn

2025.09.30 № 01/984
Танай -ны № -т

Санал хүргүүлэх тухай

"Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны үр дүн" сэдэвт гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, цаашид санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахын тулд тус сангийн асуудлаар Засгийн газрын тогтоол гаргуулах саналтай байна. **Тогтоолд:**

1. Боловсролын зээлийн сангийн статусыг тодорхой болгож эрх зүйн орчныг шинэчлэх. Боловсролын зээлийн сан 2016 оноос эхлэн зээлийн сан гэдэг нэршилтэй болсон боловч өнөөдрийн байдлаар нийт үйлчилгээний 86 хувь нь тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлт, үлдсэн 14 хувийг зээлийн үйлчилгээ бүрдүүлж байна. Энэ санг олон улсын жишигт нийцсэн, Алсын хараа 2050 бодлогын баримт бичигт туссаны дагуу Хөгжлийн сан болохын тулд сангийн эх үүсвэрийн тогтворжилтыг хадгалах буюу өөрийгөө санхүүжүүлэх эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээг түлхүү санал болгож, эргэн төлөгдөх нөхцөлгүй тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлтийг хязгаарлаж, цаашид бууруулах чиглэл байж урт хугацаанд тогтвортой байдлаа хангаж ажиллах ёстой. Иймд эрх зүйн орчны шинэчлэлийг бие даасан санхүүгийн эх үүсвэртэй, хараат бус санг бий болгох зээлийн хэлбэрийн санхүүгийн дэмжлэгт анхаарал хандуулах шаардлагатайг эрх бүхий байгууллагад даалгах саналтай байна.

Мөн Боловсролын зээлийн сан улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн нэршилтэй ч санхүүгийн харилцаа нь өөр буюу улсын төсвийн эх үүсвэрээр үйлчилгээ үзүүлж байна. Төсвийн тухай хуулиар жил бүр Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний багцад төсөв нь дээд боловсролын санхүүжилтэд тусгаж, төрийн үйлчилгээний ангиллаар үндсэн үйл ажиллагаа зохицуулагдаж байна. Өөрөөр хэлбэл Засгийн газрын бусад тусгай сан шиг олгосон санхүүжилтийн эргэн төлөлтөөр санхүүждэг, энэ чиглэлд зориулагдсан бүтэц зохион байгуулалттай (эргэн төлүүлдэг албатай), бие даасан санхүүжилттэй, үйл ажиллагааны үр дүнгээр албан хаагчдын бүтээмжтэй уялдсан цалин хөлсний бодлого зохицуулалттай бүхий эрх зүйн орчны шинэчлэл тулгамдсан асуудал болсныг энэ саналаар уламжилж байна.

1425031900

2. Боловсролын зээлийн сан нь "2012 оны технологи бүхий мэдээллийн систем өнөөдөр ашиглаж байгаа" нь цахим шилжилтийг шаардсаар байгаа цаг үеэс хоцрогдсон төдийгүй сангийн үйл ажиллагаанд илэрсээр байгаа зөрчлийн төрөл, мөнгөн дүн нэмэгдэх шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл системийн технологи хуучирсан бөгөөд хөгжүүлэгч компаниас тогтмол шинэчлэл хийх шаардлагатай тухай санал, дүгнэлтүүд ирүүлсээр байгаа хэдий ч өнөөдрийг хүртэл хэрэгжүүлээгүй байдаг. Системийн шинэчлэл, сайжруулалт, хөгжүүлэлтийн асуудлаар холбогдох байгууллагуудад удаа дараа төсвийн санал хүргүүлсэн боловч шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгахгүй, салбарын асуудал эрхэлсэн сайдын багцаас шийдвэрлэж байгаагүй. Иймд зээлийн эргэн төлөлтөөс санхүүгийн хэрэгцээг эрэмбэлэн тодорхойлж, 2025-2026 ондоо багтаан мэдээллийн системийн шинэчлэлтийг хийх саналыг дэвшүүлж байна. Үүнд төсөв захирагчийн хувьд Боловсролын Сайдын багцаас шийдвэрлүүлэх, Боловсролын Сайдын тушаал шийдвэрээр эрх зүйн орчныг бий болгож шийдвэрлүүлэх, Сангийн яамнаас энэ асуудалд зөвшөөрлийг олгуулах саналтай байна. Ингэснээр Боловсролын зээлийн сангийн мэдээллийн системийг орчин үеийн технологид нийцүүлэн шинэчилж, үйл ажиллагааны үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдэд хүрэх үйлчилгээний чанарыг сайжруулах боломж бүрдэнэ.

Мөн гар ажиллагаа бүхий сангийн үйлчилгээг цахимжуулах ажил үе шаттай хэрэгжих тул Засгийн газрын 2025 онд батлагдсан тогтоолын хаасралт журмаар өөрчлөгдсөн "шинэ тутам үйлчилгээнүүд, одоо ашиглаж буй мэдээллийн системийн хэвийн ажиллагааг хангах зорилго"-оор 2025 оны зээлийн эргэн төлөлтөөр тодорхой хувийг системийн чиглэлд зарцуулах боломжийг энэ тогтоолд тусгуулах нь цаг үеийн тулгамдсан асуудал болоод байна. Учир нь сангийн одоо ашиглаж буй системийн хөгжүүлэгч компаниас энэ тухай буюу систем хэзээ ч зогсож магадгүй тухай анхааруулга ирсээр байна.

3. Засгийн газрын бодлого, 2024-208 оны мөрийн хөтөлбөрт Боловсролын зээлийн сангаар гадаадад ахисан түвшинд суралцуулах чиглэлийг хэрэгжүүлэх тухай санал дэвшүүлж байна. Цаашид Боловсролын зээлийн сангийн авлагын 70-80 хувийг эзэлж байгаа гадаадад суралцсан зээлдэгч нарын төлбөрийг Засгийн газрын тогтоолд тусгаж эрх зүйн орчныг хүчитгэх замаар эргэн төлөлт хэлбэрийн эх үүсвэрийг тогтворжуулах. Зээлийн эргэн төлөлтийг хуулийн хүрээнд Боловсролын зээлийн сан бие даан өөрийн үйл ажиллагаанд (хөтөлбөр үйл ажиллагаа болон үндсэн үйл ажиллагаанд эрэлт хэрэгцээг эрэмбэлэх зарчимд суурилах) зарцуулах эрх зүйн орчныг Засгийн газрын тогтоолд тусгуулах саналтай байна.

4. Суралцагч нартай гэрээний биелэлт дүгнэх асуудалтай холбоотой төрийн байгууллагуудын мэдээллийн системд нэвтэрдэг эрхийг Боловсролын зээлийн сан тодорхой хэмжээний нууцлалтайгаар ашиглах саналыг гаргаж байна. Жишээ нь Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Иргэний мэдээлэл авах), Боловсролын яамны ESIS зэрэг системээс сантай гэрээ байгуулсан иргэний гэрээний хэрэгжилт дүгнэх асуудлаар холбогдох мэдээлэл (хөдөлмөр

Тайлбар
5-г үзэх

эрхлэлт)-ийг авдаг байх, системүүдийн механик ажиллагааг бууруулж автоматжуулах асуудалд анхаарал хандуулж, тогтоолоор албажуулж өгөхийг хүсье.

Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, цаашид тогтвортой байлгахын тул Монгол Улсын Их хурлаас Засгийн газарт чиглэл өгүүлэх саналтай байна. Засгийн газарт өгөх чиглэлд:

1. Боловсролын зээлийн сангийн хараат бус байдлыг хангах.

Боловсролын зээлийн сан хуулиар олгогдсон эрхлэх асуудлын хүрээнд суралцагчдын гэрээ дүгнэх, зээл эргэн төлүүлэхтэй холбоотой иргэдэд үзүүлэх үйлчилгээнд төр нэг чиглэлийн бодлого баримталж, сангийн ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх чиг үүргээ төрийн дээд шатны байгууллага баримталж ажиллах талаар чиглэлд тусгуулах. Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх явцад үүргээ биелүүлээгүй иргэдийн өргөдөл гомдлын асуудлаар төрийн байгууллагуудын хяналт шалгалтын тоо жилд 12 удаад хүрч, шалгалтын давтамж ойртох, давхардаж байгаа нь сангийн үндсэн үйл ажиллагаа доголдуулахад хүрч байгааг анхаарч ажиллах тухай чиглэлд тусгуулах саналтай байна. Тодруулбал:

Боловсролын зээлийн сангийн үндсэн үйл ажиллагаа нь ажлын ачаалал ихтэй, сонгон шалгаруулалт зохион байгуулах, зээлийн гэрээ байгуулах, зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор иргэдээс байнга санал гомдол ирүүлдэг. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Боловсролын яам, Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн алба зэрэг байгууллагуудаас олон удаагийн шалгалтууд ирж сонгон шалгаруулалт, зээлийн гэрээ, эргэн төлөлттэй холбоотой материалуудыг хуулбарлан авах, Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх, дүүргүүд дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс удаа дараа материалын хуулбар ирүүлэх, хариу тайлбар авах, Захиргааны хэрэг, Иргэний хэргүүд дээр байгууллага төлөөлсөн хариуцагч томилуулж шүүхийн маргаанд оролцуулж байгаа нь ажлын ачааллыг улам ихэсгэж, хүний нөөцийн тогтворгүй байдлыг бий болгож, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, үр нөлөөтэй үзүүлж чадахгүй байгаа тул хяналт шалгалтуудтай холбоотой зохиомол ачааллууд байгаа талаар тайланд тусгуулж, гаднаас ирэх хяналт шалгалтыг багасгаж, хараат бус байдлыг хангах талаар Засгийн газарт өгөх чиглэлд оруулах саналтай байна.

2. Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд холбогдох газруудаас хийсэн шалгалтын дүгнэлтэд хүний нөөцийн тогтвор суурьшилгүй талаар дурдсан байгаа шалтгаан нь ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах төсөв хангалтгүй, ажлын ачаалал их байна. Боловсролын зээлийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг цахимжуулах үндэслэл нь төрийн албыг цомхотгон, цахимжуулж, ажлын ачааллыг бууруулж “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай байгаа боловч төсөв мөнгө шийдэж өгөхгүй байгаа тул зээлийн эргэн төлөлтийн орлогоос ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах, дотоод үйл ажиллагаандаа зарцуулах эрх зүйн орчныг бий болгох саналтай байна.

“Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлангийн төслийн 2.41-т “Оюутны хөгжлийн зээлийн санхүүжилт олгосон 81-н сургууль эрсдэлийн сангийн дансгүй байсан” гэсэн

Тайлбар
6-г үзэх

байна. Энэ асуудалд 2024 оны 102 дугаар тогтоолын шинэчлэлтийн мөрөөр авагдсан арга хэмжээ учир түүнээс өмнө эрсдэлийн сангийн данстай байсан талаар тусгуулах саналтай байгааг уламжилж байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 О СИЙЛЭГМАА



Үндэсний аудитын газрын тайлбар:

ЗГХЭГ-аас 2 санал, Боловсролын Сайдаас 6 санал, Боловсролын зээлийн сангаас 6 санал, нийт 14 санал ирүүлсэн нь аудитын тайланд дурдсан илрүүлэлт, дүгнэлт, зөвлөмжтэй агуулгатай нийцэж байна. Харин ЗГХЭГ-аас ирүүлсэн 1 саналыг хүлээн авах боломжгүй, нийт 5 саналыг хүлээн авч тайлангийн 2.41-т болон холбогдох зөвлөмжид найруулгын өөрчлөлт оруулав.


Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Зөвлөмж: Монгол Улсын Засгийн газар /Ерөнхий Сайдад 1. Засгийн газраас ТБОНӨТ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, ...” гэж заасны дагуу хуулийн этгээдийг байгуулах шийдвэрт тус сангийн үйл ажиллагаа, үйлчилгээ нь олон улсын сайн жишигт нийцсэн байх нөхцөлийг бүрдүүлэх... гэж найруулгын өөрчлөлт оруулав.
Тайлбар 2	Аудитаар Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааг хамруулсан тул саналыг хүлээн авах боломжгүй
Тайлбар 3	Зөвлөмж: Боловсролын Сайдад 2. Боловсролын зээлийн сангийн зорилго, зорилтыг хуульд нийцүүлэн тодорхойлох, сангийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үйлчилгээний чиглэлд нийцүүлэн сангийн бүтэц, нэгж, албан тушаалтны чиг үүргийг тодорхой болгох шийдвэрийг гаргах... гэж найруулгын өөрчлөлт оруулав
Тайлбар 4	3. Сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн иргэдийн гэрээний үүргийн биелэлт, зээлийн эргэн төлөлт, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн сангийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, сангийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарах... гэж найруулгын өөрчлөлт оруулав.
Тайлбар 5	Зөвлөмж: Боловсролын зээлийн сангийн ажлын албанд: Гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн иргэдтэй гэрээний үүргийг харилцан биелүүлэх нөхцөлийг сануулах, шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн байгууллагын цахим мэдээллийг авах хүсэлтийг салбарын яамаар дамжуулан санал тавьж шийдвэрлүүлэх, хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах... гэж найруулгын өөрчлөлт оруулав.
Тайлбар 6	Тайлангийн 2.41-т ... 2024 оны “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”-ын 12.4-т “Суралцагч ...санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдэлийн даатгалаар даатгуулсан байна” гэж зохицуулсан байна... гэж найруулгын өөрчлөлт оруулав.

Хавсралтууд

"Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн" аудитын тайлан


Хавсралт 1.

1 Дүрслэл БШУС-ын Боловсролын зээлийн сангийн орон тоог баталсан тухай мэдээлэл



Эх сурвалж: Аудитын баг

2 Дүрслэл БШУЯ-ны Боловсролын эзэлийн сангийн захирлын орон тооны нээжийн бүтцийг баталсан тухай мэдээлэл



"Боловсролын эзэлгйн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн" аудитын тайлан

Хүснэгт 13 Монгол Улсын Боловсролын эзэлгйн сан, АНУ-ын Холбооны Оюутны Санхүүгийн Тусламжийн Алба / FSA/, Өмнөд Солонгосын Оюутны санхүүгийн дэмжлэгийн сан /KOSAF/, БНХАУ-ын Хятадын тэтгэлгийн зөвлөл (China scholarship council) хоорондын үйл ажиллагаа үйлчилгээний нөхцөлийг харьцуулсан судалгаа

Хавсралт-3

№	Үзүүлэлт	Монгол улс	АНУ	Өмнөд Солонгос Улс	БНХАУ
1	Үүсгэн байгуулагдсан	1997 оноос /Сургалтын төрийн сан/ 2016 он Боловсролын эзэлгйн сан	1965 оноос Дээд боловсролын тухай хууль /Higher Education Act/	2009 он /Хууль батлагдсан/	1996 он
2	Байгууллагын нэр	Боловсролын эзэлгйн сан	Холбооны оюутны тусламжийн алба (FSA/Federal Student Aid, 2025)	Өмнөд Солонгосын Оюутны санхүүгийн дэмжлэгийн сан (Korea Student Aid Foundation (KOSAF))	Хятадын тэтгэлгийн зөвлөл (China scholarship council)
3	Байгууллагын харьяалал	Боловсролын яам	Боловсролын яам	Боловсролын яам болон Сангийн яамны хяналт дор ажилладаг	Боловсролын яам
4	Хууль эрх зүйн хувьд	ЗГТСТ хууль Төрийн албаны тухай хууль Дээд боловсролын тухай хууль Боловсролын ерөнхий хууль Засгийн газраас баталсан холбогдох журам	Дээд боловсролын тухай хууль /Higher Education Act /1965 он//	- Солонгосын тэтгэлэгт сангийн тухай хууль /Korean Scholarship Foundation /2009 он//	-Боловсролын яамны захирамжаар байгуулагдсан /1996/ -Хятадын Засгийн газрын хууль тогтоомж, хоёр талын болон олон улсын гэрээний дагуу ажилладаг
5	Бүтэц зохион байгууллага	Орон тооны бус зөвлөл -Ажлын албаны дарга -Захиргааны удирдлагын хэлтэс -Санхүүгийн хэлтэс -Дотоод зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн хэлтэс -Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс -Цахим хөгжүүлэлтийн хэлтэс	-Ерөнхий захирал /Chief Operation Officer/ -Бодлого, төлөвлөлтийн газар/Policy,Planing&Oppnovation/ -Грант, зээл, Work-Study газар /Programm Operation/ -Санхүү, эрсдэл, хяналтын газар/Financial Management/ -Оюутны ажил эрхлэлт хариуцсан газар/Customer Experience group/ -Мэдээлэл технологийн болон Data төлөвлөлтийн газар /FAFSA, student.gov/	-Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч -Санхүү, хяналт, мэдээлэл технологийн газар -Зээл, тэтгэлгийн газар -Work-study болон орлогын дэмжлэгийн хэлтэс -Судалгаа, хөгжлийн төв -Орон нутгийн салбар оффис /Аймаг, муж/ ¹¹⁰	-Удирдах зөвлөл (Дарга, орлогч дарга) -Гадаадын оюутны хөтөлбөрийн газар -Дотоодын оюутны хөтөлбөрийн газар /гадаадад сургах/ -Олон улсын хамтын ажиллагааны газар -Судалгаа, бодлого, мэдээтэл хариуцсан газар ¹²⁰
6	Ажилчдын тоо	32	1,400 /тов салбар/ 4,000 /нийт улсын хэмжээнд/	500-1,000 ажилтантай ¹²¹	
7	Байгууллагын тогтолцоо	Боловсролын эзэлгйн сан нь Боловсролын яамны харьяа байгууллага. • ЗГТСТ хуулиар "...Боловсролын эзэлгйн сан" тусгай сан... "Ажлын алба"-тай, Тусгай сангийн зориулалтыг хуульчилсан • Боловсролын Ерөнхий хууль"-д боловсролын байгууллагын	Холбооны Оюутны Санхүүгийн Тусламжийн Алба (Federal Student Aid, FSA) нь АНУ-ын Боловсролын Яамны (U.S. Department of Education) харьяа байгууллага байна. ✓ Дээд боловсролын тухай хуульд үндэстэн байгуулагдсан ✓ Оюутнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэгтэй.	KOSAF нь 2009 оны 5 дугаар сард "Korea Scholarship Foundation" хуулиар байгуулагдсан, Өмнөд Солонгосын боловсролын яамтай хамтран ажилладаг төрийн түвшний хуулийн этгээд байгууллага юм. Тус байгууллага нь үндэсний түвшний оюутны санхүүгийн тусламж түүний дотор хэрэгцээнд суурилсан тэтгэлэг,	China Scholarship Council (CSC) нь Хятадын Боловсролын яамны харьяа байгууллага бөгөөд оюутны солишоо, тэтгэлгийн бодлогыг удирддаг үндсэн байгууллага юм. Энэ байгууллага нь гадаад оюутнуудыг Хятадад суралцуулах, мөн Хятад оюутнуудыг гадаадад сургах бодлогыг хэрэгжүүлдэг ¹²⁴

¹¹⁰Өмнөд Солонгосын Оюутны санхүүгийн дэмжлэгийн сан, <https://theorg.com/org/korea-student-aid-foundation>

¹²⁰ Хятадын тэтгэлгийн зөвлөл, https://cscet.georgetown.edu/wp-content/uploads/China-Scholarship-Council-Overview.pdf?utm_source=chatgpt.com

¹²¹ Өмнөд Солонгосын Оюутны санхүүгийн дэмжлэгийн сан (Korea Student Aid Foundation (KOSAF)), https://theorg.com/org/korea-student-aid-foundation?utm_source=chatgpt.com

¹²⁴ Хятадын тэтгэлгийн зөвлөл, https://en.wikipedia.org/wiki/China_Scholarship_Council

8	Эх үүсвэр	Улсын төсөв	Алба нь санхүүгийн тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, өргөдөл хүлээн авах, боловсруулах, санхүүгийн боловсрол олгох, зээлийн эргэн төлөлтийг удирдах үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ¹²²	Холбооны төсөв	Улсын төсөв-баталгаа	Улсын төсөв + Олон улсын гэрээ
9	Санхүүжилтийн хэлбэр	Хүүгүй зээл, буцалтгүй тусламж, төрийн тэтгэлэг	Грант, зээл, work-study		Зээл (ICL, Direct, LRS, Living), тэтгэлэг, work-study	Бүрэн/хэсэгчилсэн тэтгэлэг, олон улсын хамтын хөтөлбөр ¹²⁵
10	Зээлийн Хүүгийн нохдол	Зээлийн хүүгүй	Бакалавр: 5% орчим Магистр/Доктор: 7% Plus, loan: 8%		ICL: хүүгүй LRS: хүүгүй Direct loan/Living express loan: Застгийн газраас тогтоосон, банкны зээлээс доогуур бага хэмжээний хүүтэй	Голчлон тэтгэлэг (буцалтгүй) олгодог Зээл маш ховор
11	Сургалтын төлбөр, зээлийн эргэн төлөх хугацаа	5-20 жил хүртэл	10-25 жил		Эргэн төлөлт зөвхөн орлогоотой болсон үед эхэлдэг: ✓ Тодорхой босго орлогоос (жиншээ нь: жилийн ₮20 сая төгрөгөөс дээш) хэтэрмэгц тухайн орлогын хувиар төлнө. Хэрэв төгсөөд ажилгүй эсвэл орлого багатай бол эргэн төлөлт түр хойшлогдох боломжтой.	Тэтгэлэг-төлөхгүй
12	Үзүүлж буй үйлчилгээ	Зээл: Гадаад, дотоод сургалтын зээл, сургалтын төлбөрийн хөтөлөлттэй зээл Зорилготой бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламж: Тэтгэлэг: ✓ Ерөнхийлөгчийн тэтгэлэг дараах төрөл: ✓ Монгол Улсын Застгийн газрын т этгэлэг: ✓ Застгийн газар хоорондын тэтгэлэг ✓ Зарим эрэлтгүй мэргэжлийн тэтгэлэг: Дотоодын сургалтын	Зээл: ✓ Direct Subsidized Loan: Сангийн дэмжлэгтэй, бакалаврын оюутанд олгогддог, хүүгийн төлбөр оюутан сурч байх хугацаанд тавигдахгүй. Жилийн дээд хэмжээ ойролцоогоор 3,500-5,500 ам.доллар, суртах түвшнээс хамаарна. ✓ Direct Unsubsidized Loan: Хүү төлөх шаардлагатай, бакалавр, магистр, докторын оюутанд зориулсан. Жилийн дээд хэмжээ ойролцоогоор 5,500-12,000 ам.доллар ✓ Direct Plus Loan: Эцэг, эх, магистр, докторын оюутанд зориулсан зээл. Хүүгийн нөхцөл нь харьцангуй өндөр.		Income-Contingent Loan (ICL): Доод орлогын бүлгийн оюутнууд, эсвэл 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн суралцагчдад хамаарах хүүгүй зээл. Зээл авахдаа эзэлдэгчийн зээлийн чадвар, кредит шаардлага тавигддаггүй Loan for Rural Students (LRS): Хөлөөд амьдардаг, эсвэл газар тариалан, загас агнуурын салбарт 6 сараас дээш хугацаанд амьдарсан өрхөд зориулсан хүүгүй зээл. Living Expenses Loan: Суралцагч өөрийн хэргээрээс хамааран ₮500,000- ₮1,000,000 (нийт ₮2 сая хүртэл хичээлийн жилийн хугацаанд) зээл авч,	Гадаад оюутнуудын тэтгэлэгүүд: Хятадын застгийн газраас санхүүжлэг тэтгэлэгүүдийг CSC зохион байгуулдаг бөгөөд сургууль бүр, эсвэл элчин сайдын яам, хоёр талын хэлцлээр олгодог төрөл "Turs A, B, C" гэх ангилалтай хөтөлбөрүүд байдаг. Хятад оюутнуудыг гадаадад сургах хөтөлбөр: National Postgraduate Program (NCHUPP) нь жилд 30,000 орчим Хятад докторант, докторт гадаадад суралцуулах томоохон хөтөлбөр

¹²² АНУ, Холбооны Оюутны санхүүгийн тусламж. Хандсан: <https://studentaid.gov/about>. Хандсан: 2024.03.10

¹²³ Өмнөд Солонгосын Оюутны санхүүгийн дэмжлэгийн сан, https://www.bloomberg.com/profile/company/0790035D%3AKS?utm_source=chatgpt.com

¹²⁵ Хятадын тэтгэлгийн зөвлөл, <https://www.chinesescholarshipcouncil.com/scholarships-in-china>

байгууллагад мэргэжлээр	зарим эрэлтэй	зээлийн дээд хэмжээ хязгааргүй буюу суралцагчийн хэргээрэнээ хамаарна Тэлэлт: ✓ Pell Grant: ихэвчлэн бакалаврт суралцагчид зориулсан, жилийн дээд хэмжээ 7,395 ам.доллар, сургалтын төлбөр, амьжиргааны зарим хэсгийг хамруулж буцаан төлөх шаардлагагүй Federal Supplement Educational Opportunity Grant: санхүүгийн эрсдэл онодоор, жилийн хэмжээ ойролцоогоор 4,000 ам.доллар ¹²⁶	орон байр, түгээр, сурах бичиг зэрэг зардлыг толох боломжтой Loan Conversion Program: Суралцагчид тухайн улиралд шууд зээл (Direct Loan) авсан тохиолдолд, шаардлага хангасан хэсгийг ISL-д шилжүүлэх боломжтой байдаг. Гэхдээ өмнө авсан зээлийн нөхцөлүүд өөрчлөгддөггүй ¹²⁷	“Outstanding Self-Financed Students Abroad” нэртэй, тухайн оюутныг өөрийн хөрөнгөөр гадаадад сурч буй академичдыг хүтээн зөвшөөрдөг шагнал—жилд ойролцоогоор 650 хүнд олгогддог Олон улсын хамтын ажиллагаа: CSC-ийн дэргэдэх ICSPIT (International Cooperative Program for Innovative Talents) нь дэлхийд тэргүүлэгч их дээд сургуультай хамтран, инновацын чиглэлээр мэргэшсэн хөтөлбөр. ¹²⁸
12 Мэдээллийн цахим систем	Мэдээллийн нэгдсэн системгүй, одоогийн ашиглаж буй цахим систем нь журмын шаардлага, шалгуурыг хангаагүй	FAFSA ✓ Санхүүгийн тусламжийн эрх, хэмжээ шалгах ✓ Зээлийн үлдэгдэл, эргэн төлөлтийн төлөвлөгөө харах ✓ Income-driven repayment зэрэг тохиргоог онлайнаар хийх ✓ Өрхийн орлого, татварын мэдээллийг IRS системтэй холбосон	One-step service буюу бүх үйлчилгээг нэг дороос авах боломжтой, ил тод байдал өндөр. ✓ Зээл, тэтгэлэг онлайнаар өргөдөл гаргах ✓ Эргэн төлөлтийн үлдэгдэл, төлбөрийн хуваарь харах ✓ Work study болон амьжиргааны дэмжлэгийн мэдээлэл авах Мобайл апп зээл болон тэтгэлгээ утсаар шалгах боломжтой	CSC Online Application System Олон улсын хамтын ажиллагааны тэтгэлэг өргөдлийг бүтцийг цахимаар авдаг. ✓ Гадаад болон дотоодын тэтгэлэг онлайнаар бүртгүүлэх ✓ Шаардлагатай баримт бичгийг цахимаар оруулах Тэтгэлгийн шийдвэр, статусыг онлайнаар хянах

Эх сурвалж: Аудитын баг

¹²⁶ Холбооны оюутны тусламжийн алба (FSA, 2025), https://en.wikipedia.org/wiki/Federal_Student_Aid

¹²⁷ Өмнөд Солонгосын Оюутны санхүүгийн дэмжлэгийн сан, https://blog.sleavenwards.com/blog/topic/korea-student-aid-foundation?utm_source=chatgpt.com

¹²⁸ Хятадын тэтгэлгийн зөвлөл, https://en.wikipedia.org/wiki/China_Scholarship_Council

Монгол улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: +976 51-261585. Факс: +976 11-323266, 11-324853
И-мэйл: info@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn